

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-8

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

9-62

- | | |
|---|-------|
| 1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/ | 9-10 |
| 2.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/ | 10-12 |
| 3.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл | 12-18 |
| 4.Улсын Их Хурлын даргын 2024 оны 84 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт | 19-28 |
| 5.“Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэл | 28-35 |
| 6.“Сэлбэ дэд төв”-ийн нийгмийн хангамж болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Үндэсний аудитын газар болон холбогдох бусад байгууллагын мэдээллийг сонсох | 35-62 |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
06 дугаар сарын 17-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 22 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Ж.Ганбаатар, Р.Сэддорж;
Чөлөөтэй: М.Энхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Энхтүвшин;
Тасалсан: Ш.Бямбасүрэн, Х.Ганхуяг, Б.Жаргалан, О.Цогтгэрэл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд хэлэлцэх асуудлын дарааллын зургаадугаар асуудал болох “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг гуравдугаар асуудал болгох горимын санал гаргав.

А.Ундраа: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа тогтоолын төслийн талаар танилцуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, О.Батнайрамдал, Ч.Лодойсанмбуу, П.Сайнзориг, А.Ундраа нар орж ажиллахаар тогтов.

А.Ундраа: “Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа

Уг асуудлыг 10 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар, мөн газрын Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Ууганбаяр, Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Тулгаа, Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга В.Ганзориг, Сорьцын хяналтын газрын дарга Д.Бэхбат, Нийслэлийн лабораторийн дарга Д.Эрдэнэтуяа, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батзориг, Хууль эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн дарга С.Оюунцэцэг, Мэдээллийн технологи, стандартын лавлагаа, сургалтын төвийн дарга Ч.Содном, Хууль эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн Эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Даваасүрэн, Үндэсний итгэмжлэлийн төвийн дарга С.Ням-Эрдэнэ, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын Судалгааны төвийн эрхлэгч Г.Оюунболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын талаарх илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд санал хэлээгүй болно.

А.Ундраа: 1.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Мандхай нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 13 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4

Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Стандартчилал, техникийн зориулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, П.Сайнзориг, Н.Батсүмбэрэл нар үг хэлэв.

А.Ундраа: “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Улсын Их Хурлын даргын 2024 оны 84 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын даргын 2024 оны 84 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцлаа.

Уг асуудлыг 11 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ч.Сарантуяа нар байлцав.

Ажлын хэсгийн мэдээллийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Мандхай нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн талаар ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 11 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. “Сэлбэ дэд төв”-ийн нийгмийн хангамж болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Үндэсний аудитын газар болон холбогдох бусад байгууллагын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Батцэцэг, мөн газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Г.Анар, Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Б.Амарболд, С.Болдбаатар, “Сэлбэ-20 минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар, мөн компанийн Төслийн удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ш.Ганзориг, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Ганзориг, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, “Барилгын нэгдсэн холбоо” ТББ-

ын Ерөнхийлөгч Ч.Наранбаатар, мөн ТББ-ын төлөөлөл Ц.Цэндхүү, С.Алтанцог, Ц.Наранбат, Я.Дашням, Б.Өлзийбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ч.Сарантуяа нар байлцав.

“Сэлбэ дэд төв”-ийн нийгмийн хангамж болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Л.Соронзонболд, М.Мандхай, П.Батчимэг, Л.Мөнхбаясгалан, А.Ундраа нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, “Барилгын нэгдсэн холбоо” ТББ-ын Ерөнхийлөгч Ч.Наранбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Соронзонболд, Г.Лувсанжамц, М.Мандхай, А.Ундраа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Сэлбэ дэд төв”-ийн нийгмийн хангамж болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаарх Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 08 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
10 цаг 22 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

А.Ундраа: Та бүхний өглөөний амгаланг айлтгая. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтган хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

М.Бадамсүрэн, Р.Батболд, О.Батнайрамдал Э.Батшугар, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Ундраа, Б.Найдалаа, С.Цэнгүүн гишүүд хүрэлцэн ирсэн байна. Тэгээд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хороодын гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны хуралдааны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

Нэгдүгээрт, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны хур тогтоолын төсөл, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай.

Хоёрдугаарт, Стандартчилал, техникийн зориулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх үргэлжилнэ.

Гуравдугаарт, Улсын Их Хурлын даргын 2024 оны 84 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцах.

Дөрөвдүгээрт, “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэлтэй танилцах.

Тавдугаарт, Сэлбэ дэд төвийн нийгмийн хангамж болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Үндэсний аудитын газар, Нийслэлийн засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад байгууллагын мэдээллийг сонсох.

Зургаадугаарт Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Энэ Лувсанжамц гишүүний ахалж байгаа 85 дугаар ажлын хэсгийн асуудлыг хэлэлцэх асуудлын гуравдугаарт, оруулж санал хурааж өгвөл болох уу гэсэн санал гаргамаар байна. Санал хураалт явагдаж байгаа учраас.

А.Ундраа: Горимын саналаар санал хураая. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Техникийнх нь санал хураалт бэлтгэгдсэн байдлыг хянаадах уу? Дахиад хуруу уншуулаадах уу? Гишүүд ээ санал хураалт.

Санал хураалт тоо бол 69.2 хувиар санал дэмжигдлээ. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Ингээд 85 дугаар ажлын хэсгийн боловсруулсан тогтоолын төслийг хэлэлцэх асуудал гуравдугаарт, орлоо. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэгдүгээрт, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэх байгаа. “Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай”.

Тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсэг байгуулах тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай шинэчилсэн найруулгад нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийг хэн ахлах бэ? Санаачлагч ахлахгүй. Ажлын хэсгийг Лувсанжамц гишүүн ахалъя.

Ажлын хэсгийн гишүүд, бүрэлдэхүүнд орох Сайнзориг гишүүн, Алдаржавхлан гишүүн санаачилсан. Батболд гишүүн, өөр орох хүсэлтэй гишүүн байна уу? Би орчихъё. 4 гишүүн. Өөр? Цэцэрлэг, сургуулийн хүртээмж сайжруулах асуудал байгаа л даа. Батнайрамдал гишүүн. Өөрөө санал гаргахгүй бол. Тэгвэл ажлын хэсгийн бүрэлдэхүүнээ, тийм тогтоол батлах уу? Лувсанжамц гишүүн ахлаад тэгээд Батболд, Батнайрамдал, Сайнзориг, Лодойсамбуу, Ундраа ийм бүрэлдэхүүнтэйгээр энэ, угаасаа санаачилсан гишүүн ахалж болохгүй ажлын хэсгийг. Хууль санаачлагч болохгүй. Лука. Ажлын хэсэгт орох юм уу Бадамсүрэн гишүүн ? Саяын бүрэлдэхүүнтэйгээр баталъя.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг хуралдаанд оролцуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж гэсэн тогтоол байна.

Энэ дээр тийм ээ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Алга байна. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

69.2 хувиар тогтоол батлагдлаа. Дараагийн асуудалдаа оръё. Уучлаарай, Байнгын хорооны тогтоол батлагдлаа. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

10.32 цаг

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Хуулийн төслийн хэлэлцүүлэг гишүүд асуулт асуугаад дууссан байгаа түрүүний хуралдаан дээр.

Одоо хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын хурал чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1. 11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Бэлэн болсон.

Нэгдүгээрт, 1.Стандартчилал, техникийн зориулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Сайнзориг гишүүн дэмжсэнээр, Мандхай гишүүн дэмжсэнээр протоколд үлдээе. Угаасаа хууль ажлын хэсэг байгуулна л даа.

2.Хамт өргөн мэдүүлсэн Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдэх үү? Санал хураалт бэлдчихсэн байгаа тээ.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

4.Хамт өргөн мэдүүлсэн Баяжуулсан хүнсний, 71.4 хувиар санал дэмжигдлээ.

4.Хамт өргөн мэдүүлсэн Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

6.Хамт өргөн мэдүүлсэн Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын тойм томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд ээ санал хураалт шүү.

71.4 хувиар санал дэмжигдлээ.

7.Хамт өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зориулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Батсүмбэрэл гишүүн ирцэд орсон байна.

8.Хамт өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Хамт өргөн мэдүүлсэн Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

73.3 хувиар санал дэмжигдлээ.

10.Хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

80 хувийн хувиар санал дэмжигдлээ.

11.Хамт өргөн мэдүүлсэн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

80 хувиар санал дэмжигдлээ.

Мөнхбаясгалан гишүүн ирцдээ орсон байна.

Санал хураалт явуулж дууслаа. Саяынх 80 хувиар. Санал хураалт явуулж дууслаа.

Стандартчилал, техникийн зориулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал танилцуулна.

Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалд оръё.

Амжилт хүсье. Олон олон юмнуудыг янзлах хэрэгтэй. Их олон хуулийг янзлах хэрэгтэй болох юм.

10.40 цаг

Хэлэлцэх асуудал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.1 дэх хэсгийг баримтлан Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг эхэлье.

Ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамцыг тогтоолын төслөө танилцуулахыг урьж байна. Гишүүний микрофоныг нээнэ үү.

Г.Лувсанжамц: Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүдэд өглөөний мэндийг хүргэе.

Өмнөх Эдийн засгийн байнгын хороон дээр танилцуулсан 85 дугаар тогтоолоор байгуулагдсан Ногоон санхүүжилтийн тогтолцоог бий болгох Улсын Их Хурлын тогтоолыг Засгийн газарт чиглэл өгөхөөр боловсруулсан байгаа. Та бүхэнд тараасан байгаа. Багц зүйлээр бол 3 багц саналуудыг оруулсан. Нийтдээ 17 заалтууд байгаа. Эдгээр ажлыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан энэ тогтоолд заасан хэмжээний арга хэмжээний биелэлтийн тайлан үр дүнг үндсэн дүгнэлтийг Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн

засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар болон Монголбанканд тус тус даалгасугай гэсэн агуулгатайгаар боловсруулсан.

Та бүхэнд өмнөх Эдийн засгийн байнгын хороогоор бүх агуулгыг болон танилцуулгыг хийсэн бөгөөд групп чат дээр бас файлууд байгаа болохлоор энэ тогтоолын төслийг дэмжиж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд оруулж өгөхийг хүсэж байна.

А.Ундраа: Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Сайнзориг гишүүнээр тасалъя. Сайнзориг гишүүний микрофоныг.

П.Сайнзориг: Ажлын хэсэг ажиллаад л ороод ирснийг нь ойлгож байгаа юм. Яг энэ Засгийн газарт энэ өгч байгаа энэ тогтоолын хүрээнд энэ жилийн хөгжлийн төлөвлөгөө улсын төсөвтэй уялдах асуудал зайлшгүй чухал байгаад байгаа юм. Цаг хугацааны хувьд жоохон оройтчихсон байна.

Хоёрдугаарт, энэ бас яг улсын эдийн засагт гэдэг юм уу тодорхой ямар нөлөө үзүүлэх вэ гэдэг дээр бас яг ажлын хэсгээс дүгнэлт хийсэн юм бий юу? Эхний ээлжид яг энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй, магадгүй 25 гэдэг чинь 26 оны төсвийн жилд хэчнээн төгрөг хэрэгтэй байгаа юм? Энэ ямар эх үүсвэрээс хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа юм?

Хоёрдугаарт, энэ тогтоолын гол амин сүнс, агуулга нь уг нь хариуцлагатай иргэн буюу эргээд энэ орчны бохирдлын эсрэг бас тодорхой хэмжээний асуудалд гар, бие оролцож байгаа хүмүүсийг л урамшуулж дэмжих тогтолцоо байх ёстой. Хариуцлагагүй хүмүүсийг байгаа байдалд нь ингээд тэр байдлыг нь улам дэвэргэж байгаа юм шиг байдалд ерөөсөө байж болохгүй байгаад байгаа юм.

Хоёрдугаарт, би бас энэ Улсын Их Хурлын гишүүн болоод Ерөнхий сайдад бас хүсэлт тавиад, нийслэлд хүсэлт тавиад энэ хуучны орон сууцуудыг дулаалах асуудлыг энэ жилдээ багтааж бүгдийг нь дуусгаж байгаа. Манайх үйлдвэрлэсэн эрчим хүчнийхээ үндсэндээ бас 30 орчим хувийг энэ 1990 оноос хойш, зарим 90 оны дундуур баригдсан цөөн тооны барилгууд байгаа. 2000 оны эхээр баригдсан. Эдгээр барилгуудаар дамжуулж алдаад байгаа юм. Алдаад байгаа юм. Энэ бас хэд хэдэн хүчин зүйлтэй байгаа. Тэгэхээр би энэ ногоон энэ дулаалга байдаг юм уу, дулаан алдагдлаас багасгах ер нь цаашдаа энэ ногоон амьдралын хэвшил гэдгийн цаана хууль, эрх зүйгээс гадна эдийн засгийн ч бас хэлж байгаа. Энэний цаана бас иргэдийн ухамсрын асуудал байгаа. Эргээд зөв зохион байгуулалтын асуудал байна. Өнөөдөр энэ СӨХ-ны эрх зүйн байдлын хуулийг бас яг тодорхой болгож өгөхгүй бол бидний авч байгаа арга хэмжээ бас цаашдаа ач холбогдолгүй болно. 1 өдөр дулаалаад өгдөг. Хуулиараа ганцхан удаа дулаалж өгнө гэдэг хуультай. Орон сууцын тухай хуулиар л 1 удаа улсын төсөв, орон нутгийн төсвөөс дэмжиж болно.

Тэгэхдээ энэ бүрэн бас дэмжээгүй юм байна лээ, бас тодорхой хувийг нь нийслэл дагаад, тодорхой хувийг нь оршин суугчид өөрсдөө дагаад ийм байдлаар ингээд явж байгаа арга хэмжээ. Тэгэхээр энийг амины орон сууц, гэр хорооллын юм руу оруулж байна. Тэгэхээр энэ дээр би бас хамгийн гол нь ажлын хэсгийн ахлагчаас ирэх жилийн жилийн төсвийн жилд хэчнээн төгрөг хэрэгтэй байгаа юм? Энэний тооцоо судалгаа гарсан юм уу? Төр хувийн хэвшилд оролцох бололцоо нь

юу гэж харагдаж байгаа юм, дээрээс нь Барилга, хот байгуулалт, орон сууцжуулалтын яамнаас тэр ногоон амины орон сууцын стандарт тэр загварын орон сууцуудын стандарт энэ тэрийн мэдээллийн сан үүсгэсэн юм уу? Яг ингээд ийм яг иргэдэд их гоё сонсогддог. Яг бодит байдал дээр хэрэгжихээр яг алийгаа ногоон орон сууц гэж тодорхойлох боломжгүй нөхцөл байдал байгаа учраас энэ зээл чинь гарахгүй, зээл гарахгүй.

Тийм учраас яг энэ бэлтгэл ажил энэ тэр хэр байна? Энийг бас ажлын хэсгийн ахлагч тодорхой мэдээлэл өгөөч гэж хүсэж байна.

А.Ундраа: Лувсанжамц гишүүний микрофон өгье.

Г.Лувсанжамц: Сайнзориг гишүүнд баярлалаа. Эхний ээлжид ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөө, 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгах ажил дээр ажлын хэсэгт орж ажиллаад яг энэ ногоон санхүүжилтийн хүрээнд утааг бууруулах, гэр, байшинг дулаалах, дээрээс нь нэмээд орон сууцын, угсармал орон сууцын дулаалгын ажил дээр энэ төсвийн хөрөнгө оруулалтыг тусгах ёстой гэсэн үндэслэлээр 26 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийтдээ 300 тэрбум төгрөг шаардлагатай 2032 он хүртэл 1.8 их наяд төгрөгийн зардал хэрэгтэй болно гэсэн тооцоог гаргаад, та бүхэн бас ажлын хэсэг болон нэгдсэн чуулганаар 26 оны хөгжлийн төлөвлөгөө дээр дэмжиж өгсөн. Энэ дээр маш их баярлалаа гэж хэлмээр байна эхний ээлжид.

Хоёрдугаарх нь болохлоор 1.3 дээр заасан байгаа ногоон зээл хүүгийн татаасаа ил тод байдлыг хангах, хэмжих, хянах, тайлагнах гэсэн ийм баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоог нь боловсруулах ажлыг нь Байгаль орчны яам болон Монголбанктай хамтраад ажлын хэсгийн хүрээнд бас хэлэлцсэн. Тэгэхлээр энэ бэлтгэх ажил нь явж байгаа. Тэгээд удахгүй энэ нь батлагдаад явахлаар бодитоор энэ ногоон санхүүжилтийн механизм нь бүрдээд явна гэсэн үг.

Стандартын хувьд бол 1.5 дээр байгаа эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилгын шалгуур Бэст гэр гэж байгаа. Бэст гэр стандартын хувьд өнгөрсөн жилийн 12 сард Хот байгуулалтын яаман дээр ногоон барилгын стандарт гэж албан ёсоор батлагдсан. Энэ жилийн 3 сард журам нь батлагдсан. Тэгэхлээр энэ стандартыгаа бариад явахад хангалттай гэсэн зүйл байгаа.

Хоёрдугаарт, энэ эрчим хүчний хэмнэлттэй гэдгийг тогтоож байгаа байгууллага нь бол Эрчим хүчний зохицуулах хорооноос зохион байгуулдаг сургалтаар Эрчим хүчний аудитор гэсэн зэрэг авсан хүмүүс эрчим хүчний хэмнэлтийн тохирлын гэрчилгээ гэдэг зүйлийг гаргадаг. Одоо үүний хүрээнд хувийн банкнуудаас бол зээл олгогдож байгаа.

Тэгэхлээр байшингийн хувьд бол стандарт болон ногоон зээлийн энэ тогтолцоо нь, олгох тогтолцоо нь бүрэн бүрдсэн байгаа. Энэ дээр нэмээд тусгаж байгаа зүйл нь бол гэрийн стандартыг боловсруулах ёстой буюу 1.9 дээр байгаа монгол гэрийн эрчим хүчний хэмнэлттэй дулаалгын стандартыг шинээр боловсруул гэж бичсэн байгаа. Энийг бол ШУТИС-ийн Мөнхбаяр профессор болон бусад мэргэжлийн холбоодын байшин, гэр дулаалах дээр ажилладаг өнөөдрийг хүртэл ажилласаар ирсэн. UNICEF-ээс хэрэгжүүлсэн пин, чип/CHIP/ багц гэсэн багц байгаа. Тэрийг нь албан ёсоор үндэсний стандарт болж батлуулах ажлыг нь бас зэрэгцүүлээд хэрэгжүүлээд явж байгаа.

Гуравдугаарт нь пассив барилгын стандарт гэдэг зүйлийг бас үндэсний хэмжээнд батлах ёстой гэсэн ажлын хүрээнд Барилгын хөгжлийн төвтэй хамтраад түүнээс зарласан ажлын хэсэг дотор пассив барилгын стандартыг монголчилж Монголдоо баталдаг болно гэсэн тийм ажлын хэсэг бас явж байгаа. Тэгэхлээр стандарт эрх зүйн орчин бий болчихсон. Монгол гэрийнх үлдчихсэн байгаа. 26 оны хөгжлийн төлөвлөгөө дээр 300 тэрбум төгрөг хэрэгтэй гэсэн төлөвлөгөө дээр туссан байгаа. Намрын чуулганаар 26 оны төсөв дээр бас эдгээр санхүүжилтийн эх үүсвэрийг тусгана гэж байгаа.

Гэхдээ энэ нэг зүйлийг тодотгож хэлмээр байна. Шинээр ямар нэгэн төсвийг улсын хөрөнгөөр гаргах биш өнөөдрийг хүртэл сайжруулсан түлшний татаасанд олгож ирсэн энэ оновчгүй зардлыг нь ногоон барилга буюу дулаалгад чиглүүлээд утааг бодитоор бууруулъя. Улаанбаатарын хувьд бол 2028 он гэхэд 50-60 хувийн агаарын бохирдлыг бууруулах, 32 он гэхэд утаагүй болгох ийм боломж бололцоог бүрдүүлэхээр санал оруулсан. Тэгээд манай ажлын хэсгийн гишүүд болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүд өнгөрсөн долоо хоногт явуулсны дагуу 1, 2 санал туссан байгаа. Эд нарыгаа тусгаад оруулсан байгаа.

А.Ундраа: Баярлалаа. Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Би ерөнхий агуулга мэдээллүүдийг авлаа. Тэгээд манай Байнгын хороо бас энэ дээр нь бас жоохон орж ирэхэд нь зөвхөн Засгийн газрын ажил биш байгаад байгаа юм өнөөдөртөө бол. Ер нь Засгийн газрын хэрэгжүүлэх ажил. Тэгэхдээ яг энэ тогтоолуудыг Засгийн газарт дангаар нь хариуцуулах асуудлуудыг яагаад Монголбанк гэдэг юм уу Улсын Их Хурлын харьяа байгууллагуудтай холбоотой юмнуудыг уг нь бас шийдчихмээр байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол энэ чинь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд бас зөвлөмөөр байгаа байхгүй юу. Аль болохоор энийг байна шүү дээ бодлогын түвшинд ойлгуулж, ИТХ-д бас зөвлөж, Монголбанканд бас энэ ипотекийн зээлийн тодорхойлсон ногоон зээл болгох энэ асуудал дээр бодлогын яам тогтолцооны хувьд болон бодлогын ямар асуудлууд байхын бас зөвлөөд ийм хамтарсан байдлаар энэ тогтоолын хэрэгжилтийг хангаач ээ гэдэг зүйлийг уг нь боловсруулалтын хувьд бас 2 хуваагаад ороод ирсэн бол их зөв байсан. Тэгээд энэ зүйлүүдийг Барилгын яам цаашдаа хэрэгжүүлэхдээ анхаарна биз. Би зүгээр хэлж байгаа юм. Энэ Засгийн газраар дамжаад Барилгын яам, Барилга, хот, орон сууцжуулалтын яам хэрэгжүүлэх байх. Энэ дээрээ бас анхаарна биз дээ. Улсын Их Хурлаас илүү .../минут дуусав./

А.Ундраа: Тийм бас Монголбанкийг энэ ногоон санхүүжилтийн асуудал дээр маш нягт ажиллаж байж энэ чинь нөгөө ногоон зээлийн тэгээд ялангуяа барилгад оногдох хэмжээг нэмэгдүүлэх арга механизмаа хэрэгжүүлэлт дээр нь дээрээ бас ярвигтай байгаа нь яг тодорхой Сайнзориг гишүүний саналыг тусгах хэрэгтэй байх тийм ээ ажлын хэсгийн дарга. Соронзонболд гишүүн та үг хэлэх юм байна тийм ээ? Одоо тэгвэл энэ асуулт дуусаж байгаа юм.

Саналтай гишүүн байна уу? Нэрээ өгье.

Батсүмбэрэл гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүнийг. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Ирцээрээ Батсүмбэрэл гишүүн юм байна шүү дараа нь. Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Энэ тогтоолын төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Энэ 14, 15 дээр бас энэ зээлийн хүүг 6 хувиар ингээд явахаар цаад талдаа тодорхой хэмжээний энэ хэмжээ байх ёстой л доо. Хэдэн төгрөгийн асуудал яригдаж байгаа вэ гэдэг асуудлыг бас тодорхой гаргах ёстой гээд түрүүн тэр Сайнзориг гишүүний хэлдэг бас зөв шүү. Тэгээд энийг анхаарах ёстой.

15 дээр бас энэ монгол гэрийн нийт дулаалгын нийт зардлын тодорхой хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх чиглэлээр гээд. Энэ болохоор бас яг орон нутгийн төсөв маань бас бид нар энэ татварын багц хуулийн шинэчлэлт эд нар явагдаж байгаа. Ингээд орон нутгийн төсөв ер нь уул уурхайн циклээ дагаад эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа. Тэгэхээр энэ дээр эд нар бас жоохон яг тодорхой цаад талд нь энэ судалгаа байхгүй бол энэ ийм юуны чиглэлтэй л болчихлоо л гэж л харагдаад байна. Тийм учраас энийг бас яг Их Хурал дээр энэ нэлээн л яригдах байх даа л гэж бодогдоно. Тийм учраас энийг ажлын хэсэг анхаарах ёстой байх л.

А.Ундраа: Санал хэлэх Сайнзориг гишүүний микрофон өгье.

П.Сайнзориг: Би энэ Улаанбаатарын орчны бохирдол энэ дулаан алдагдлыг бууруулах гэж бас санаачилгатай бас ажиллахыг хичээж байгаа гишүүн байгаа юм. Тэгээд Улаанбаатар хотод энэ хуучны гэж ярьдаг орон сууцнуудыг дулаалах асуудлыг ямар ч байсан Нийслэлд энэ жилийн төсөв дээр бас тодорхой дүүргүүдийн орон сууцууд тавиад эхнээсээ ажил болоод явж байна. Энэ Барилгын яаман дээр явж байхдаа бас яг яаман дээр бас ийм аж ахуйн ажил очихоор явдаггүй юм байна лээ. 1, 1 орцоор нь ч юм уу ингээд яваад байдаг. Бид хэд бас тодорхой хэмжээнд бас Улаанбаатар луу шахалт үзүүлж байж нэлээн ингээд кампанит эрчимтэй ажил байгаа.

Гэхдээ энэний цаана иргэд хариуцлагатай баймаар байгаа. Тэгэхээр бид хэд иргэдээ хариуцлагатай хамтарч ажиллах тэр дундын асуудлаа, дундын проблемоо шийдэх тэр гарц гаргалгааны асуудал болох тэр СӨХ-ны хуулийг нь бас Улсын Их Хурал яаралтай цэгцэлж өгөх зайлшгүй асуудал байгаа юм. Энийг хэдүүлээ бас анхаармаар байна.

Хоёрдугаарт, ерөөсөө энэ хариуцлагатай иргэдийг л урамшуулах илүү давуу байдал олгодог энэ зүйл рүү явмаар байна. Энэ дулаалгын асуудлуудыг хийж байгаа, эсвэл энэ сэргээгдэх эрчим хүчээр эрчим хүч дулааны асуудлаа шийдэж байгаа иргэдийн газрын төлбөрөөс тодорхой хугацаагаар чөлөөлдөг ч юм уу ийм урамшууллын системийг бид нар бас ингээд оруулж өгмөөр байна. Тэр хүмүүс их бас их мөнгөтэйдөө ч юм уу ингээд тавиад байгаа биш. Энэ бас тодорхой хэмжээний эрчим хүч, дулааны асуудал дээр Монгол Улсын хэмжээнд асуудал дээр Монгол Улсын хэмжээндээ асуудал ороод байхад бас энэ сайн санаачилгыг нь бас тодорхой хэмжээнд ч гэсэн дэмжиж урамшуулдаг энэ системийг бид нар оруулмаар байгаа юм. Иймэрхүү зүйлүүдээс нь бодмоор байна.

Хоёрдугаарт, энэ ипотекийн зээлийн хүртээмж ерөөсөө боломжгүй байгаа. Ялангуяа тодорхой хувийг бас орон нутгуудад өгөх ёстой байна. Дээрээс нь Улаанбаатарт өгч байгаа энэ ипотекийн зээлийн тодорхой хэсгийг банкнуудтайгаа ярьж байгаад энэ дахин төлөвлөлт гэдэг юм уу, гэр хорооллын орчинд босож байгаа орон сууцнуудыг дэмжиж өгөх, дээрээс нь стандартын шаардлага хангасан буюу дулаан алдагдалгүй орон сууцнуудыг өгмөөр байгаа юм. Өнөөдөр бие биеийнхээ байгалийн нарыг хараад хаагаад барьчихаж байгаа орон сууцад өгөөд

байгаа байхгүй юу. Зүв зүгээр ногоон орон сууц байж байсныг аваачаад урд талд нь хааж байшин бариад хүрэн орон сууц болгочхож байгаа юм. Ийм үзэгдэл маш их байгаа учраас энэ иймэрхүү орон сууцууд дээр бодлогын дэмжлэгийг ерөөсөө үзүүлдэггүй баймаар байна. Ингэж байж өөрөө иргэд ийм орон сууцууд чинь ипотекийн зээл гаргаж өгнө гэдгээр иргэдийг шахаанд оруулчхаж байгаа байхгүй юу. За одоо гарч байгаа дээр нь л авчихъя гээд л авдаг. Тэгээд хүний нөгөө сэтгэл зүйн талаасаа байгалийн нар тусдаггүй юун дээр хүн гутардаг, эрүүл мэндийн асуудалд ордог, энэ дулаан алдагдал, байнгын өдөржингөө гэрлээ асаадаг ийм нөхцөл байдал руу орчихдог. Тэгэхээр энэ мэтээс л эхлээд бид нар энэ хотын стандартыг мөрдүүлэхгүй болохгүй байгаа юм.

Хоёрдугаарт, энэ ипотекийн зээл дээр бас бодлогын өөрчлөлт гаргаач. Зөвхөн 80м2-тай-ад ипотекийн зээл 6 хувийг олгоно гээд байдаг. Магадгүй 80-аас дээш дээр нь өндөр хүүтэй л олго л доо. Тэгээд 10 юутай. Тэгээд сонголт байдаг, авбал авдаг. Ингэж байж энэ өөрөө эргээд нөхөгдөж бас эдийн засгийн үр өгөөжөө бас бодолцож яахгүй бол энэ ипотекийн зээлийн хүртээмж чинь энэ эх үүсвэрүүд нь улам агшаад байна л гэсэн үг. Агшаад байна гэсэн үг.

Тэгэхээр бид хэд аливаа зүйлийг ор тас хязгаарлах гэхээсээ илүүтэй яаж тэр сонголтуудаар нь бас иргэдийг авч хэлэлцэх вэ гэдэг зүйлийг нь бас бодохгүй бол ерөөсөө л ийм 80м2-тай тийшээ барилгад өгөхгүй гэдэг ийм зүйлүүдээр ингээд яваад ийм хоёрын хооронд бас нэг туйлшрахаараа нэг талд нь гарч туйлшраад байна. Тэгэхээр бид хэд маш олон ..ууд байгаа. Энэ дээр бас анхаараач ээ гэдэг зүйлүүдийг бас нэгдүгээрт, хэлмээр байгаа юм.

Ер нь энэ ногоон эдийн засгийг дэмжих, ногоон бодлогыг дэмжсэн суурь хуультай болох ёстой юм. Би энийг бас засгийн төсөв батлахад Засгийн газарт өгсөн чиглэл батлах Улсын Их Хурлын тогтоол дээр оруулсан. Эдийн засгийн хөгжлийн яаманд толгой дохиод маш сайн заалт оруулж өглөө. Бид удахгүй ээ л гэсэн одоо хүртэл алга байна. Ингэчих юм бол бид ногоон эдийн засаг гэж юуг ойлгох юм бэ гэхивэл манай аж ахуйн нэгж байгууллагууд хөрөнгө оруулалт хийх, энэ дээр бид хэд стандарт дээрээ ажиллахад хүртэл ойлгомжтой болчих юм. Тэгэхээр ийм зүйлүүдийг илүү их маш хурдтай хиймээр байна.

Нэг талдаа бид хэд ногоон эдийн засгийн асуудал сөрөг, эдийн засагт нэлээн гэдэг юм уу хувийн хэвшилд ч гэсэн зардал болно. Хувь хүн дээр ч гэсэн. Нөгөө талдаа бас зөв судалбал бид нарт боломж бас болгож болох бололцоо байна. Тэгэхээр энэ зүйлүүдийг зайлшгүй анхаарч.../минут дуусав./

А.Ундраа: Батсүмбэрэл гишүүн .

Н.Батсүмбэрэл: Тогтоолын төслийг дэмжиж байгаа. Саяын гишүүдийн хэлж байгаатай төстэй зүйлүүд байна. Тэгэхээр энэ Барилгын яам, Засгийн газар гэхээсээ илүү нийслэл хот дээр энэ хотын стандартыг сайн мөрдүүлэх, Улаанбаатар хотын захиргаа, дүүргүүдийн захиргааны асуудлууд. Тэгээд энэ Их Хурал дээр чинь нөгөө 20, 40 гээд яваад байгаа. Энэ зогсчихсон. Уг нь 20, 40-төөгөө энэ нэлээн сайн уялдуулаад стандарттай нь холбож өгмөөр байгаа юм. Саяын яриад байгаа тэр барилга хоорондын зай, гэрэл сүүдрийн байдал гээд олон асуудал энэний ард ярьж таарна. Нэг.

Хоёрт нь зөвхөн Улаанбаатар хот төдийгүй орон нутгуудад, ялангуяа энэ аймгийн төвүүд томхон сууринууд дээр ногоон санхүүжилтийг ногоон орон сууцын

зээлийг бий болгох боломжийг сайн бүрдүүлж өгмөөр байгаа юм. Тэр дулаалга дээр ер нь монгол гэрийн дулаалга насжилт яаж тооцох юм, тэр тооцож байгаа насжилт маань ямар хугацаанд тооцож байгаа юм, тэгээд эргээд хэдэн удаа, ямар хугацаанд хийгдэх бололцоотой байх юм? Нийтийн орон сууц, амины орон сууц дээр ямар байдалтай байх юм гэдэг юмнуудыг сайн стандартчилж энэ холбогдох яамнууд нь хийж өгөхгүй бол болохгүй байгаад байгаа юм. Одоо бид чинь яг Барилгын сайдгүй болчихсон учраас өөрсдөдөө л хоорондоо ярьж байна шүү дээ бодит байдал дээр.

Тэгэхээр энэ шинэ томилогдох Барилгын сайд дээр хамгийн эхний анхаарах ажил энэ. Ялангуяа 2025-26 оны өвөлжилт бол Монгол Улсын хувьд их хүнд болох нь байна. Тэгэхээр энэ хүнд нөхцөлд энэ томилогдох Барилгын сайд, Эдийн засгийн сайд нар энэ ажил дээр нэлээн анхаармаар байгаа юм. Тэгэхгүй бол өнөөдөр бид нар гишүүд хоорондоо суучхаад л нэг нэгэндээ ярьж байгаа ч юм шиг байдалтай болчихоод байна. Тэгээд Монголбанк энэ дээр нэлээн санаачилга гаргамаар юм байна лээ. Бид нар Монголбанк дээр хийсэн уулзалт дээр оролцсон Банкнууд бас тодорхой санаачилгууд байдаг. Гэтэл уялдаа холбоог сайн холбож өгөх, энэ дээр нь тодорхой дэмжлэг үзүүлэх, зохион байгуулалтыг хийх ажил Монголбанк дээр маш дутуу байдаг нь харагддаг. Тэгээд энэ дээр Монголбанк дээр нэлээн үүргэжүүлэх чиглэлийн, тодорхой үүргэжүүлэх тэгэхдээ энэ нөгөө хоорондоо зохион байгуулалт хийх энэ ажлуудыг хиймээр байгаа юм.

Харамсалтай нь Монголбанк маань ажлаа хийж байгаа юм алга байна. Тэгээд энэ ногоон орон сууц, ногоон зээл байтугай мөнгөний төгрөгийнхөө бодлогыг ч алдчихсан ийм байдалтай нөхөр байдаг юм шиг байгаа юм. Тэгээд ч Монголбанкны даргын нэрийг ч мартчихдаг юм. Хэн билээ дээ нөхөр байдаг байх. Тэгэхээр энэ ажлуудыг бодож ажилламаар байгаа юм. Ийм саналтай байна.

А.Ундраа: Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасныг үндэслэн тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Санал хураалт явах гэж байна.

“Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын чуулганы.

Хэлэлцэх асуудал дөрөв. Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.1 дэх хэсгийг баримтлан Улсын Их Хурлын даргын 2024 оны 84 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцаж эхэлье.

Ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Хурлын гишүүн. Отгоншарын Батнайрамдалыг ажлын хэсгийн санал, дүгнэлтээ танилцуулахыг урьж байна. Гишүүний микрофоныг нээнэ үү.

О.Батнайрамдал: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 84 дүгээр захирамжаар стандартын эрх зүйн орчны шинэчлэх санал дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Батшугар, Ганмаа, Лувсанжамц, Мандухай, Пунсалмаа, Саранчулуун, Цэнгүүн, Энхцэцэг, Эрдэнэболд, Ганзориг, Мөнхсоёл, Хосбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийн шийдвэрийг төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу бэлтгэн танилцуулж байна.

Ажлын хэсэг Монгол Улсад мөрдөж буй стандарт, түүний хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдлын үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлтэй холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлт, сайжруулах санал боловсруулах бодлогын суурь дүгнэлтийг гаргах зорилготой 9 сарын хугацаанд ажиллалаа.

Энэ хугацаанд ажлын хэсэг албан ёсоор 7, албан бусаар 8, нийт 15 удаагийн хурал уулзалтыг зохион байгуулж, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яам, Зам, тээвэр хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газар, Барилгын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газар, Эрчим хүчний, Эдийн засгийн хүрээлэн болон бусад холбогдох байгууллагын мэдээллийг сонсож, нөхцөл байдал, тулгамдсан асуудалтай танилцсан, гишүүдийн санал, зөвлөмжийг авсан.

Мөн 2025 оны 2 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд барилга, эрүүл мэнд, хүнс, хүрээлэн буй орчин буюу голлох 4 салбарын яам болон холбогдох мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн 700 орчим төлөөллийн бүрэлдэхүүнтэй салбар хэлэлцүүлэг болон бүх салбар яамд, төрийн байгууллага, хувийн хэвшлийн 1000 гаруй орчим төлөөлөгчдийг хамруулсан нэгдсэн хэлэлцүүлэг, хуралдааныг Монгол Улсын Шадар сайдын Ажлын албатай хамтран Төрийн ордонд тус тус зохион байгуулж, хэлэлцүүлгийн зөвлөмж, дүгнэлт гаргасан болно.

Эдгээр хуралдаан, хэлэлцүүлгийн уулзалтын үр дүнд дараах саналыг нэгтгэн боловсруулж, үүгээр танилцуулж байна. Үүнд:

1.Стандартыг боловсруулах, санал авах, батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үйл явцыг тодорхой, ойлгомжтой, шуурхай, ил тод болгож, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

2.Салбарын стандарт, норматив, баримт бичгийг боловсруулахад батлахад төсвөөс ангид мэргэжлийн холбоодоор дамжуулан санхүүжүүлэх тогтолцоог оновчтой болгох. Тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, ил тод байдлыг хангаж хяналтыг сайжруулах.

3.Хүн, малын эрүүл мэнд, хүнс, эм, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхолд эрсдэлд учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээс өмнө хяналт тавих тогтолцоог оновчтой болгох, цахимжуулах, салбар дундын уялдаа холбоог сайжруулах.

4.Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд нөлөөлөх хүнс, эмийн хяналтыг зохицуулах чиг үүргийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох.

5.Одоогийн мөрдөж буй стандартад хийсэн үзлэг, дүн шинжилгээний мөрөөр сайжруулах шаардлагагүй стандартын баримт бичгийг хүчингүй болгох. Салбаруудын стандарт, норматив, баримт бичгийн уялдааг хангаж нэгтгэж, олон нийтэд ил тод болгох олон улсын жишигт нийцүүлэх ажлыг зохион байгуулах.

6.Олон улсын стандартын байгууллагын гишүүн орнуудын баталсан дэвшилтэт стандартын баримт бичгийг бүртгэх, нутагшуулах тогтолцоог хялбаршуулах, мэдээллийн сан нэгдсэн санг бүрдүүлэх.

7.Стандартчилал, тохирлын үнэлгээний салбарт ажиллах мэргэжилтнүүдийг бэлтгэх, сургах, гүйцэтгэлд хяналт тавих тогтолцоог мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй хамтран бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулах.

8.Сорилт шинжилгээ хийх лабораториудын тоног төхөөрөмжийг шинэчлэхэд анхаарах. Тохирлын үнэлгээ, сорилт, баталгаажуулалт, хяналтын үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоо болон хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

9.Эмчилгээ, оношилгооны стандартын баримт бичгийг олон улсын нийтлэг жишиг, арга зүй, заавар, зөвлөмжүүдэд нийцүүлэн боловсронгуй болгох. Үндэсний фармакопейн өгүүллэг, олон улсын фармакопейн өгүүлэлтэй нийцүүлж өөрчлөх эрх зүйн зохицуулалтыг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд тусгах.

Энэхүү санал, дүгнэлтийг боловсруулсантай холбогдуулан дараах алхмуудыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн Ажлын хэсгийн зүгээс үзлээ. Үүнд:

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 84 дүгээр захирамжаар стандартын эрх зүйн орчныг шинэчлэх, санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааг үүгээр дуусгавар болгох.

Хоёрдугаарт, уг ажлын хэсгийн ахлагч болон гишүүд засгийн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний

итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцүүлэхэд бэлтгэх, хэлэлцүүлэх ажлын хэсэгт саналаараа орж ажиллах.

Гуравдугаарт, ажлын хэсгийн үйл ажиллагааны явцад цуглуулсан мэдээ, судалгаа, дүгнэлтийг хуулийн төслийн хэлэлцэхэд нээлттэй ашиглах.

Дөрөвдүгээрт, хуулийн төслийг батлах тохиолдолд энэхүү ажлын хэсэгт холбогдох саналыг тусгаж ажиллахад анхаарах.

Анхаарал тавьсан та бүхэндээ баярлалаа.

Санал дүгнэлтээ танилцуулж дууслаа.

А.Ундраа: Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Батчимэг гишүүнээр тасалъя. Батчимэг гишүүний микрофон өгье.

П.Батчимэг: Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе. Ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлтийг уншиж сонслоо. Цаашид энэ Монгол Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа энэ олон мянган стандарт, энэ олон мянган дүрэм журмыг ер нь энэ ажлын хэсгийн хүрээнд, тэгээд цаашилбал хууль хэрвээ батлагдвал ер нь яаж цэгцлэх юм бэ? Ер нь энэ стандарт гэдэг ухагдахуун, энэ ойлголт ер нь Монгол улсад бий болсноос ямар сайн буюу муу, сул тал байдаг юм бол? Ер нь хараад байхад ер нь стандартаар л амьдраад байна л даа. Тэгэхдээ энэ олон стандартууд өнөөдөр яг ажил, амьдрал дээр хэрэгжиж байна уу гэхээр тэр олон салбарууд салбар бүрд хэрэгжиж байгаа стандартууд өнөөдөр бараг огт хэрэгжихгүй стандартууд, тэр битгий хэл бүүр стандартын хэрэгжилт 30 гаруй хувьтай явж байгаа гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ стандартын улсыг ер нь яаж цэгцлэх вэ?

А.Ундраа: Батнайрамдал гишүүний микрофон өгье.

О.Батнайрамдал: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монгол Улсад одоогоор яг хүчин төгөлдөр ойролцоогоор 6700 орчим стандарт байна гэж байгаа. Тэгэхдээ яг гол салбаруудаа бид нар жишээлбэл аваад үзэх юм бол барилгын салбар, эрүүл мэндийн салбар, хүнсний салбарт. Нийт тухайн салбарт байгаа хүчин төгөлдөр стандартуудын бараг 60-70 хувь нь нэг ёсондоо хуучирчихсан, заавал шинэчлэх, эсвэл хүчингүй болгох шаардлагатай гэсэн ийм дүгнэлт гарчихсан. Нэгдүгээрт.

Тэгэхээр нэг ёсондоо бидний мөрдөгдөж байгаа стандартуудыг яаралтай илүү одоо олон улсын жишигт нийцүүлсэн өнөөдрийн бодит амьдралтай нийцүүлсэн өөрчлөлтүүдийг хийх нэгдүгээрт, шаардлагатай юм байна лээ.

Хоёрдугаарт, яг стандарт гэхээр энэ чинь бүхэл бүтэн яг эко систем байгаа юм л даа. Тохирлын үнэлгээг нь хийх энэ стандартыг тэгээд цаашдаа ингээд хэрэгжилтийг хэрхэн хангах вэ гээд. Тэгэхээр энэ болгон дээр нэлээн ер нь асуудлууд байдаг юм байна гэдгийг бид нар барилга, эрүүл мэнд, хүнс, хүрээлэн буй орчны салбар хэлэлцүүлгийг хийж салбарын бараг 700 гаруй хүмүүстэй уулзаж тэдний өөрсдийнх нь, салбарын өөрсдийнх нь санал, дүгнэлтийг сонсоход тодорхой харагдаж байгаа юм.

Тэгэхээр стандартын, энэ стандарт гэхээр ингээд том эко систем. Тэр дундаа яг энэ стандартын эрх зүйн орчныг стандартчиллыг яг зохицуулж байгаа тэр гол хуульд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ нь итгэмжлэлийн тухай хууль нь яг энэ цаг хугацаанд Засгийн газраар шинэчилснээр өргөн баригдаж байна л даа. Тэгэхээр энэ хууль дээр бас бид шинэчилсэн найруулгаар реформын шинж чанартай өөрчлөлтүүдийг бид нар хийх ёстой юм байна лээ.

Цаашдаа энэ стандартыг буцаад Засгийн газраас ч гэсэн хэрэгжүүлэхэд бид нар заавал анхаарах ёстой. Стандарт хэрэгжиж байна уу, үгүй юү гэдгийг жишээлбэл шалгах ёстой зүйл нь лабораторийн асуудал байгаа юм. Тэгэхээр бид нар өнөөдөр Монгол Улсын лабораториудыг аваад үзэхэд ч гэсэн буцаад тэр лабораториуд нь олон улсын жишигт нийцсэн, итгэмжлэгдсэн байна уу гээд аваад үзэх юм жишээлбэл ялангуяа хүнс, эрүүл мэнд дээр бидний амин чухал хүний эрүүл мэнд, аюулгүй байдалтай шууд холбоотой. Тэгэхээр энэ дээрээ үнэхээр маш дутмаг явж ирсэн юм байна лээ.

Дээр нь энэ стандартуудыг цаашаа шинэчлээд явахад ч гэсэн яагаад шинэчлэгддэггүй жишээлбэл ингээд хуучирсан хэвээрээ байна гэхээрээ санхүүжилтийн асуудал байгаа юм байна лээ. Тэгэхээр тэрийг хэн санхүүжүүлдэг вэ? Нэг стандартыг бүүр анхнаас нь бичихээс нь өгсүүлээд батлаад хэрэгжилтийг хангахад энэ чинь бараг 1.5 жилээс 2 жилийн хугацаа шаарддаг болж таарч байгаа. Тэгэхээр энийг хэрхэн бид нар хялбаршуулах вэ, хэрхэн хурдан явуулах вэ? Буцаад энэ маш их санхүүжилт хөрөнгө, хүн, хүч шаарддаг учраас энэ тогтолцоог бид нар хэрхэн бий болгох вэ? Тэгэхээр энэ асуудлыг бид нар ер нь цогцоор нь шийдэж байж буцаад стандарт нь олон улсын жишигт нийцсэн гарна. Буцаад хэрэгжилт нь ч гэсэн хангагдах юм байна лээ л дээ.

Дээрээс нь жишээлбэл би энэ дээр салбар бүр дээр ингээд янз бүр байлаа. Жишээлбэл барилга дээр бид нар Барилгын хөгжлийн төв гээд шинэ гарч ирж байгаа барилгуудаас 0.18 хувийг аваад жил болгон 7-8 тэрбум төгрөг төсөвлөж байгаа юм. Тэрбум төгрөг босдог юм байна.

Гэхдээ энэ нь буцаад тухайн салбарын норм, норматив стандартын бичиг баримтыг сайжруулахад зарцуулагдах ёстой байтал энэ яг зөв зарцуулагдаж байна уу гэхээр бид нар буцаад асуудалтай. Тэгэхээр энийг бид нар илүү институцлэх, ил тод болгох зайлшгүй зайлшгүй шаардлага бид нарт байгаа юм байна лээ. Гэх мэтчилэн салбар болгон дээр яг өөрсдийн ийм санхүүжүүлэх, илүү хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор дамжсан энэ механизмыг бас бүрдүүлж байж энэ буцаад энэ асуудал цогцоороо шийдэгдэх боломж, нөхцөл нь бүрдэнэ гэж харж байгаа юм.

Тэгэхээр манай ажлын хэсэг өнөөдөр ингээд санал, дүгнэлтээ танилцуулж байгаа нь бас энэ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль маань Засгийн газраас өргөн баригдаад Улсын Их Хурал дээр ирж байгаатай холбоотойгоор бид нар энэ хуулийн шинэчилсэн найруулга дээр ажлын хэсэг ажиллах хүрээндээ энэ ажлын хэсгээ санал, дүгнэлтээ гаргаж эцэслээд дараагийн энэ хууль дээрээ шууд бид нар ороод явна гэсэн үг.

Тэгэхээр энэ ажлын хэсгийн санал, дүгнэлтүүд яг энэ хуулийн шинэчилсэн найруулга дээр ажлын хэсэг дээр шууд ашиглагдаад судалгаа, дүгнэлт нь ашиглагдаад хууль дээр одоо энэ Эдийн засгийн байнгын хороон дээр байгаа

гишүүд ээ ажлын хэсэгт бүгдээрээ ороод энэ санал, дүгнэлтийг ашиглаад энэ дээр бид нар.../минут дуусав./

А.Ундраа: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Тийм. Одоо шинээр орж ирж байгаа Засгийн газраас өргөн барьж байгаа Амарсайхан сайдын өргөн барьж байгаа энэ Стандартчиллын талаарх техникийн хуулийн төслийг бодвол дэмжиж энэ ажлын хэсэг ажиллаж байна л гэж ойлгож байна.

Гэхдээ тэр хуулийн төслийг харахаар эргээд төр нь хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн байгууллагуудыг бас дахиад дарамтад учруулах л ийм төсөл харагдаж байна лээ л дээ. Батнайрамдал гишүүн бодвол энэ хуулийн төслийг маш сайн үг, өгүүлбэрээр нь харсан байх. Тэнд зааж өгч байгаа тэр 1.8 сарын тийм ээ гэрчилгээ буцаад авах жишээний. Тэгээд л ерөөсөө ингээд л бичиг цаас, дахиад л дарамт шат шатдаа аж ахуйн нэгжид учруулж байгаа энэ дарамтыг наад хууль чинь өөрөө бас эргээгээд оруулаад ирж байна лээ л дээ. Сая Хүнсний тухай хуулийн төсөл дээр бас хурал ажлын хэсгийн хуралд.../минут дуусав./

А.Ундраа: Болчхож байгаа юм уу? Тэгэхдээ ер нь анхаарах асуудлууд хэлж байна шүү. Ер нь энэ стандартыг шинэчлэл хийх хэрэгтэй нь, дэгээрээ Батнайрамдал гишүүн хариулах юм байна. 1 минут тэгээд хариулт хангалтгүй бол Батчимэг гишүүн ахиад тодруулж болох юм байна.

О.Батнайрамдал: Тэгэхээр бид нарын санал, дүгнэлт дээр ч гэсэн ер нь энэ стандартын энэ боловсруулахаас эхлээд процессууд илүү хувийн хэвшилд мэргэжлийн холбоодоор дамжуулсан процесс яг олон улсын жишиг нь ч гэсэн байх ёстой юм байна лээ л дээ. Тэгэхээр энэ дээр бид нар санал, дүгнэлтээ гаргасан байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн шинэчилсэн найруулал дээр ч гэсэн энэ жишээлбэл аж ахуйн нэгжүүдэд дарамт болох гэхээсээ илүүтэйгээр илүү тус дэм болох тэр өнцгөөс л бид нар бодож харах ёстой. Түрүүнд жишээлбэл тэр хэлэлцэх эсэх дээр ингээд гишүүд бас хэлж байна лээ л дээ. Тэрүүнтэй байр суурь бас нэг байгаа. Стандарт гэдэг өөрөө нэгдүгээрт олон улсын жишгээр аваад ч гэсэн сайн дурын мөрдөх бичиг баримт, хамгийн минимум дагах, тэндээс дээшээгээ байж болно. Гэхдээ тэр техникийн зохицуулалт буюу жишээлбэл хүний амь нас, эрүүл мэндэд хамааралтай тэр зүйлүүд дээр техникийн зохицуулалт гэдэг нь заа.../минут дуусав./

А.Ундраа: Батчимэг гишүүн хариулт хангалтгүй гэж үзсэн учраас тодруулъя. 1 минут. Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Өнөөдөр ер нь төр нь энэ бизнесийн байгууллага хувийн аж ахуйн нэгжийн байгууллагуудаасаа хоцроод байна л даа. Дэлхийн стандартыг аль хэдийн аж ахуйн нэгжүүд бүр тас тодорхой 10, 12 оноос хэрэгжүүлээд хэдэн стандарт хийж байгааг ч бүү мэд. Тэгэхэд өнөөдөр төр 9001-ийг л Ай Эс Оү/ISO/9001 яриад сууж байх жишээтэй. Тэгэхээр төр яагаад ингэж аж ахуйн нэгжээсээ ийм аймаар ухралттай, ийм хоцрогдолтой ийм явж байгаа юм. Ийм цагт ер нь стандарт гэдэг юм энэ улсад ер нь хэрэгжих нь маш бүдэг байгаа юм л даа. Тэгэхээр цаашид энэ олон стандартуудыг хумьж, энэ олон дүрэм журмуудаа жоохон цэгцлэхгүй л бол ерөөсөө болохгүй байгаа юм. Тэр нэгэнт энэ хуулийг өргөн барьж байгаа тэгээд тэрийг дагасан ажлын хэсэг ажиллаж байгаа бол та

ерөөсөө энэ хуулийн юун дээр маш анхааралтай сайн ажиллах хэрэгтэй л дээ. Дутмаг л яваад байна. Дэмжиж байгаа гэдгийг харж байна.

А.Ундраа: Батсүмбэрэл гишүүн ирцээрээ та хоёрын дараалал солигдчихсон юм байна.

Н.Батсүмбэрэл: Зүгээр ээ зүгээр. Энэ чухал ажлын хэсэг байна. Би нэг юмыг асуух гэсэн юм. Манайд чинь саяхныг хүртэл Мэргэжлийн хяналт гээд байгууллага байлаа. Тэгээд энэ чинь салбар салбарын стандартуудыг мөрдүүлэх, хяналт тавих ажлыг хийдэг байсан. Тэгээд энэ байгууллагыг ер нь та бүхэн ажлын хэсэг дээрээ дурдаж авч үзсэнгүй юу? Ер нь энэ байгууллага байхгүй болчихсон байгаа. Байхгүй байх нь зөв гэж үзэж байна уу? Байгуулах нь зөв гэж үзэж байна уу?

Ажлын хэсэг дээр энийг ярьсан уу? Тэгээд энэ стандартыг боловсруулчихаад хэн хэрэгжилтийг нь хангах гээд байгаа юм бэ?

Сая Батчимэг гишүүний хэлээд байгаачлан төрийн яамд өөрсдөө бодлого боловсруулна, тэгээд тэрийгээ өөрсдөө хянаана гэж ярина. Зарим нь бүүр аж ахуй эрхлээд нөгөө хувийн хэвшилтэйгээ булаацалдаад давхичихна. Тэгээд төрийн оролцоо маань хувийн хэвшилтэйгээ оролцоо булаацалдах байдал чинь өөрөө энэний ард л яваад байх шиг байгаа юм. Тэгэхлээр тэр стандарт гэдэг юман дээр яг энэ мэргэжлийн хяналттай холбоотой асуудлыг хэлэлцсэн ямар байр суурь, ажлын хэсэг гаргасан юм? Тэр саяын ярьдаг тэр салбарын яамнууд бодлогоо гаргачхаад өөрсдөө тэрийгээ хянаад байгаа нь их оновчтой байж чадаж байгаа юм уу, чадаж байгаа юм уу? Тэр хүнсний асуудал, эм, эмийн бүтээгдэхүүний асуудал, барилгын асуудал, эрчим хүчний асуудал, сая гараад байгаа тэр ТЭЦ 3-ын дэлбэрэлтийн асуудал чинь энэ стандарт хаанаа байсан юм, хэн хяналт тавьсан юм, тэр ТЭЦ 3-ын хариуцлагыг ер нь хэн үүрэх юм? Эрчим хүчний сайд үүрэх юм уу, Эрчим хүчний үндэсний хороо үүрэх юм уу, нөгөө Эрдэс Монгол гэдэг компани үүрэх юм уу, аль эсвэл эрчим хүчний реформ хийж байгаа гишүүд үүрэх юм уу? Хэн үүрэх юм тэгээд энэ гэх мэтээр ингээд энийг чинь асуудлыг хэдүүлээ ярилцах ёстой болж таарч байна шүү дээ. Тэгээд хүнсний аюулгүй байдлын асуудал яриад байдаг. Тэрийг хаанаа ярих юм? Нөгөө талд нь дахиад яригдаж байгаа юм. Сая Батчимэг гишүүн хөндөөд өнгөрсөн шүү. Төрийн оролцоо хэтэрхий нэмэгдчих вий дээ энэ стандартыг дагаад. Тэгээд хүнийг юм хийлгэх гэж байгаа ч юм шиг, хийлгэхгүй ч байгаа юм шүү. Сүүлдээ ажил хийдэггүй баахан хүмүүстэй, хөдөлмөр эрхэлдэггүй баахан хүмүүстэй боллоо гэж яриад байгаа ард нь. Энэ төрийн оролцоо ерөөсөө ихдээд байгаа нь үнэн.

Засгийн газартай бас 1, 2 жилийн өмнө яригдаж байсан олигтойхон шийдвэр нь төр оролцохгүй байя. Төр оролцохгүй байх хэдэн жагсаалт гаргая гэж ярьсан. Тэр таг зогсчихсон. Тэгэхээр энэ юмнуудыг энэ стандарттайгаа яаж уялдуулж харсан бэ гэдгийг асуугаадахъя.

А.Ундраа: Батнайрамдал гишүүний микрофон. Асуулт үг хамт.

О.Батнайрамдал: Батсүмбэрэл гишүүн бас чухал асуулт асууж байна. Бид нар яг ажлын хэсгийн хүрээнд ч гэсэн ялангуяа хүнс, тэр эмийн салбарууд дээр салбар хэлэлцүүлэг хийхэд салбарын өөрсдийн мэргэжлийн оролцогчид нь яг энэ таны хэлж байгаа асуудлыг дэвшүүлж байна лээ л дээ. Тэгэхээр бидний санал, дүгнэлт дээр 4 дүгээр асуулт дээр бас, 4 дүгээр санал, дүгнэлт дээр ийм юм орж ирж байгаа юм л даа. Ялангуяа хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд

нөлөөлөх хүнс, эм дээр ялангуяа. Тэгэхээр яг бидний салбар хэлэлцүүлэг дээр энэ гарсан дүгнэлтийн нэг. Хүнс, эмийн хяналтыг зохицуулах чиг үүргийн нэгдсэн тогтоол боловсруулах шаардлагатай байна гээд.

Тэгэхээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсанаас хойш яг хяналтын тэр механизм бол яг улс ёсондоо улсын байцаагч дээр хэрэгждэг. Энэ ингээд бүгд салбар яамдынхаа доор очсон байгаа юм. Тэгэхээр энэ дээр хүмүүсийн янз бүрийн санал, дүгнэлтүүд гарч байна лээ л дээ.

Гэхдээ яг салбарын хэлж байгаагаар хүний эрүүл мэндэд яг шууд хамааралтай эм, хүнс хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй байдал шууд нөлөөлдөг. Энэ дээр харин нэгдсэн зохицуулалтын тогтолцоо ингээд зайлшгүй үгүйлэгдэж байна гэж байгаа. Тэгэхээр нэг ёсондоо хүнс эмийн яг мэргэжлийн холбоод шууд хэлж байна лээ л дээ. Хүнс, эмийн агентлаг нэгдсэн тийм тогтолцоо зайлшгүй байх шаардлагатай байна. Ядаж бид нар хүнс, эмийнхээ стандартыг хангаж байна уу? Яг тэр техникийн зохицуулалтууд заавал зайлшгүй даган мөрдөх тэрэнд хэрэгжиж байна уу гэдэг дээр шийдлүүд ярьж байна лээ. Тийм учраас бид нар санал, дүгнэлтдээ бас энийг тусгаж өгсөн байгаа.

Ер нь энэ санал дүгнэлтээс бас гол нэг зарчим байгаа л даа. Тэр ингээд энэ стандартууд ер нь төр гэхээсээ илүүтэйгээр мэргэжлийн холбоодоор дамжиж мэргэжлийн холбоод өөрсдөө тэрийгээ гаргаж баталж, тэр битгий хэл санхүүжилтийн механизм нь мэргэжлийн холбоодоороо дамжиж гарах ёстой. Тэгэхээр өнөөдөр Барилгын хөгжлийн төв дээр бид нар 7-8 тэрбум төгрөг тухайн салбар дээр хангалттай цугладаг боловч тэр нь буцаад энэ салбарын баримт бичгийг боловсруулах, тэр дээрээ зарцуулагдаж байна уу гэдэг нь хүртэл асуудалтай явж ирсэн. Яагаад гэхлээр тэн дээр яамны жишээлбэл төрийн яамнаас журам боловсруулаад Төрийн нарийны гарын үсгээр гардаг жишээтэй. Ингэх тоолондоо энэ дээр асуудал үүсдэг юм байна лээ. Тэгэхээр энэ нь өөрөө цаашдаа салбар салбар дээрээ мэргэжлийн холбоо төрөөс хамааралгүй бие даасан институцийн хэлбэр рүү зайлшгүй орох шаардлагатай нь эндээс гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ стандартчиллын хууль дээр ч гэсэн энэ ингээд хэрвээ төрийн илүү хяналт, эсвэл төрийн дарамт шахалт гэхээсээ илүүтэйгээр мэргэжлийн холбоодоор дамжсан ийм зохицуулалт бас ингээд орж байж, энэ хууль дээр бас тусаж байж энд илүү аж ахуйн нэгжид дарамт гэхээсээ илүүтэйгээр илүү дэм тус болж явах болов уу л гэсэн жишээлбэл агуул агуулгыг бид нар санал, дүгнэлт дээрээ ч тусгасан. Энэ хуулийн агуулга дээрээ ч бас бид нар энэ дээр тусгана гэж бодож байгаа юм. Тэгээд манай сана, дүгнэлт дээр ч гэсэн яг мэргэжлийн холбоод хувийн хэвшлээр илүү дамжуулах гэдэг салбарууд өөрсдөө энэ дээр санал, дүгнэлтээ ч энэ дээр гаргасан байгаа юм.

Тэгэхээр энийг бид нар санал, дүгнэлтдээ ч тусгасан, яг хуулийн шинэчилсэн найруулга дээр ч гэсэн бас тусгана гэж бодож байгаа. Тэгэхээр энэ дээр бас гишүүд маань бас ажлын хэсэг бүгдээрээ энэ дээр хамтарч ороод бас 9 сар гэхэд бид нар энэ дээр санал, дүгнэлт гаргаад энэ дээр мэргэжлийн холбоонуудтай нэлээн уулзалт хийсэн. Тэгэхээр энийгээ бид нар ажлын хэсгийнхээ хүрээнд шийдээ гаргаад явж болно гэж бодож байгаа. Шинэчилсэн найруулгаас учраас бид нар энэ дээр өөрчлөлтүүд гаргах бүрэн боломжтой гэж харж байгаа. Баярлалаа.

А.Ундраа: Ажлын хэсгийн гишүүн Мандхай тодруулж хариулна, нэмж хариулна. Мандхай гишүүний микрофоныг нээе.

М.Мандхай: Батсүмбэрэл гишүүний бас хүнстэй холбоотой стандартын хувьд асуулт бас маш их зөв, мэргэжлийн хяналт байх шаардлагатай юу үгүй, юу гэдэг дээр бас их чухал асуулт тавилаа гэж үзэж байна. Ер нь мэргэжлийн хяналт дотроо хүнсний салбар дээр бие даасан хяналтын тогтолцоог байлгахгүй бол угаасаа яг үндсэндээ Мэргэжлийн хяналт татан буугдсанаас хойш ямар нөхцөл байдал үүссэн бэ гэхлээр үндсэндээ манай нийт яг өвчлөлтэй холбоотой аваад үзэх юм бол хавдар үүсгэж байгаа үүсгэгчийн 35 хувь нь хүнстэй холбоотой, зохистой хооллолт болон идэж байгаа, амаар орж байгаа хүнс, өөрөө хүнсний баталгаат байдал алдагдсан учраас ийм хавдар үүсгэж байгаа гэдэг нь судалгаагаар тодорхой болоод гараад ирчихсэн Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, жил ирэх тусам импортоор авч байгаа хүнсний хэмжээ нэмэгдэж байгаа.../минут дуусав./

А.Ундраа: Мандхай гишүүн гүйцээж хариулъя. Сайнзориг гишүүнийг нэрийг нэмье.

М.Мандхай: Импортоор орж ирж байгаа хүнс жил ирэх тусам нэмэгдэж байгаа. Нэгд.

Хоёрдугаарт, хүнсэнд тавьж байгаа, импортоор орж ирж байгаа болон дотооддоо үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэлийн хяналтын систем алдагдсан. Одоо яаж байгаа вэ гэхлээр мэргэжлийн хяналт тухайн үед хүнсний хяналт нь үндсэндээ тодорхой бүлэг нь Хабулын лаборатори руу шилжээд, нөгөө хүнсэнд тавьдаг байсан нөгөө байцаагч нар ерөөсөө хяналтын бие даасан ийм нэгж байхгүй болчихсон 9 хүн нь яаман дээрээ оччихсон одоо захиргааны ажил хийгээд ингээд ерөөсөө хүнсний хяналтын систем бүрэн алдагдчихсан байгаад байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бид нар импортоор орж ирж байгаа 46 хувь нь хүнс импортоор орж ирж байна гэххээд хорио цээр дээр байгаа лаборатори, дээрээс нь малын болон ялангуяа мал амьтны чиглэлийн хүнсэнд ямар ч хяналт тавих дэд бүтэц, лаборатори, хүн хүч байхгүй. Тэгэхлээр яаж байгаа вэ гэхлээр сая Стандартын Хабул болон Мал эмнэлгийн газраас өгсөн мэдээллээр .../минут дуусав./

А.Ундраа: Сайнзориг гишүүн үг хэлье. Мандхай гишүүн гүйцээж хариулъя.

М.Мандхай: Одоо энэ чинь нөгөө сайн тайлбар хэлэхгүй болохоор болохгүй байгаад байхгүй юу. Тийм учраас Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад 1 дэх өдөр өргөн барих гээд ажиллаж байна. Энэ дээр болохоор хүнсний бие даасан нөгөө агентлагтай байхыг оруулж өгч байгаа. Энэ нь өөрөө шинээр гарсан бүтэц гэхээсээ илүү Ерөнхий сайдын дэргэд хүнсний аюулгүй байдлыг хангах ийм нэгж байгаа. Тэгээд энэ зөвлөлийг үндсэн бүрэн хэрэгжиж эхлээгүй байгааг хэрэгжүүлж эхлээд ингээд бие даасан хүнсний баталгаат байдлыг хангадаг хүнсний аюулгүй байдлыг хангах ийм нэгжийг гаргаж өгснөөрөө энэ хүнсний энэ аюулгүй байдал хангагдах ийм боломжийг үүсгэж байгаа юм. Тэгэхлээр ер нь статистик тоо баримт болон энэ байгаа нөхцөл байдлыг судалж үзээд хүнс өөрөө өөрөө ялангуяа бие даасан ийм хяналтын тогтолцоотой байхыг ороод ингээд стандартын энэ хууль, эрх зүйн орчинд бас нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа.

А.Ундраа: Сайнзориг гишүүн. Батсүмбэрэл гишүүн тодруулж асууя. Хариулт хангалтгүй байна гэж үзвэл тодруулна гэж байгаа шүү дээ.

Н.Батсүмбэрэл: Хариулт хангалтгүй биш юм л даа энэ чинь. Би тодруулалт.

А.Ундраа: Үгүй ээ энэ чинь бид нарын харилцан яриа биш шүү дээ. Дэгээрээ л явах ёстой шүү дээ.

Н.Батсүмбэрэл: Ундраа гишүүн ээ би хоёр дахиа биш энд анх удаагаа тодруулах гэж байна.

А.Ундраа: Үгүй ээ, та тодруулж болно, үгүй ээ тодруулж болно.

Н.Батсүмбэрэл: Үгүй ээ тодруулах гэж байна. Би тэгээд тодруулж болох юм уу?

А.Ундраа: Тэгэхлээр нөгөө үндэслэлээ энэ үндэслэлийн дэг дээр заачихсан байна шүү дээ.

Н.Батсүмбэрэл: Наад хурлаа дэгийнхээ дагуу удирд л даа айн. Хуралдаан удирдаж байгаа Дэгийн дагуу удирд л даа. Наад дэг дээр чинь наад хурлаа дэгийнхээ дагуу бичсэн дэгийн дагуу удирдаач.

А.Ундраа: Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. Энэ ажлын хэсгийн дүгнэлт бол бас залгамж гэдэг юм уу уялдаж явах юм нь тэр өмнөх бид нарын дэмжээд гаргаж байгаа хууль байгаа. Би тэр хуулийг яах вэ зүгээр хэлэлцээд засах бололцоо нь байна гэж, учраас дэмжиж байгаа. Яг энэ стандарт гэдэг зүйлийг бид нар зөв ойлгохгүй бол өнөөдөр дүрэм журмын улс боллоо пүү паа гээд байгаа боловч яг эцсийн дүндээ энэ стандарт гэдэг зүйл чинь нээлттэй бус, яаж батлагддаг процесс нь нээлттэй бус, энэ тодорхой лоббинуудаар батлагддаг, тэгээд Улсын Их Хурлын урдур орж ирээд бага Улсын Их Хурал болчихсон ийм салбар байхгүй юу стандарт батална гэдэг чинь. Яг хууль, тогтоогоод мөрдүүлээд байдаг, хэм хэмжээ тогтоогоод. Уучлаарай, би үгээ хэлчихье, манай 2 байж байгаач.

Тийм учраас өнөөдөр 6200 орчим журмыг дагаж мөрдүүлэх хэм хэмжээ болгоно гэж байгаа нь аймаар том ухралт болох гэж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ дээр бид нар бас Улсын Их Хурал маань анхаарахгүй болохгүй.

Хоёрдугаарт, бид хэд шүүмжлээд байдаг захиргааны хэмжээний акт буюу Улсын Их Хурлаас эрх олгосны дагуу Засгийн газар ерөнхийлөгч, сайд, агентлагуудын баталж байгаа энэ дүрэм, журмууд чинь шүүхийн хяналтад байгаа. Зарим нь Цэцийн хяналтад байгаа. Гэтэл стандарт чинь ерөөсөө юуны ч хяналтад байхгүй. Ингэж аж ахуйн нэгж байгууллагуудыг одоо зовоодог, нэг талдаа яг манай хандлагаасаа болоод стандартыг яг таг мөрдүүлэх гэдэг энэ ойлголтоор буруу ярьдаг байхгүй юу. Стандартыг мөрдүүлэх гэж болохгүй. Тохирлын тэр техникийн зохицуулалт энэ тэрийг болох боловч стандарт сонголт буюу хэрэглэгч өөрөө эргээд авч байгаа бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээндээ хяналт тавих. Энэ нь ямар шаардлагыг хангасан бүтээгдэхүүн бэ гэдэг хэрэглэгчийг мэдээллээр хангаж

байгаа, хэрэглэгч хяналтаа тавих тэр бололцоог нь бүрдүүлж байгаа эд байхгүй юу.

Тэгээд энэ дээр нь аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээлэл багатай, эргээд энэ манай төрийн албан хаагч энэ чиглэлийн хүмүүсийн ч хандлагаас болдог. Бие бие дээрээ яг ингэж мөргүүлж асуудалд хандаад ингээд дарамталдаг. Магадгүй тэр стандартаас ч илүү сайн чанарын бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгоод байхад энэ стандарттай нийцээгүй байна ч гэдэг юм уу ийм байдлаар Монгол Улсад ерөөсөө нөгөө бусад улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн бараа, үйлчилгээ орж ирэхгүй байгаа байхгүй юу. Тэгээд л бид хэд гаслаад байдаг.

Хоёрдугаарт, энэний томоохон бүтээн байгуулалтыг дамжихаар угаасаа манайд стандартыг нь ойлгох хүн байхгүй юм байна лээ. Ялангуяа хамгийн ойрын жишээ энэ салхин сэнс, энэ нарны станцууд байсан шүү дээ. Хэн ч ойлгохгүй тэгээд яах вэ Эрчим хүчний яамны дэргэд ийм хороо байгуулчихсан. Тэнд хэдэн хүмүүс сайн дурын зүгээр явдаг. Мэргэжлийн хяналт ойлгодоггүй. Тэгэхээр бид хэд энэ салбаруудын хөгжлийг бас уяж байгаа юм чинь ерөөсөө энэ байгаад байгаа юм, энэ байгаад байгаа юм. Тэгээд энийг бас илүү анхаармаар байна.

Хоёрдугаарт, саяын зүгээр асуудал дээр үнэхээр хүнсний асуудлыг ярьж байгаа бол би ч гэсэн бас өмнө нь Төсвийн хууль хэлэлцэж байхдаа бас ярьсан юм. Уг нь эрүүл, хүний ходоод руу орж байгаа эм, хүнсний бүтээгдэхүүнийг нэгдсэн хяналттай тийм төвөө байгуулчихаач. Ингэж байж бид нар жоохон зөв явна. Ер нь хүний хөгжлийн асуудлыг яриад байгаа боловч боловсрол, эрүүл мэнд дээр тулаад байна. Тэр урьдчилсан шат.../минут дуусав./

А.Ундраа: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 84 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцаж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

11.32 цаг

“Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэлтэй танилцаж эхэлье.

Хэлэлцэх асуудлаа дэгээрээ эхэнд нь яв баталчихсан. Ажлын хэсгийн ахлагч Монгол Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболдыг ажлын хэсгийн мэдээллээ танилцуулахыг урьж байна. Гишүүний микрофоныг нээнэ үү.

Л.Соронзонболд: Ер нь удахгүй ээ. Ерөнхийдөө энэ манай ажлын хэсэг өнөөдрийн Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж байгаа зорилго нь юу байна вэ гэхээр нэгдүгээрт, товчхон явна. Гишүүдэд Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд ажлын хэсгийн энэ ажлын явцын тайланг зээлийг бууруулах ажлын хэсэг үүний тайланг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж байгаа зорилго нь юу вэ гэхээр нэгдүгээрт ямар ч байсан ажлын хэсгийн мэдээллийг хүргэх.

Хоёрдугаарт, ажлын хэсгийн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газарт энэ зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтээр ирүүлсэн тайлан дээр үнэлгээ

өгөх ажлыг Парламентын судалгааны хүрээлэнд өгсөн. Парламентын судалгааны хүрээлэнгээс энэ ажил бас намраас дуусах чиглэлтэй байна. Тийм учраас та бүхэн энэ хугацааг харгалзаж үзээрэй гэдэг ийм хүсэлт тавьсан.

Нөгөө талаасаа ажлын хэсгийн гишүүдээс Үндэсний аудитын газраар бас гүйцэтгэлийн аудит хийлгэе. Ер нь энэ стратегийг 3 удаа Их Хурал бас өнгөрсөн 10 жилийн хугацаанд баталсан байна. Хэрэгжилт хангалтгүй байгаа. Тийм учраас бас аудитын, гүйцэтгэлийн аудит хийлгэе ээ гэдэг ийм саналууд гаргасан байгаа. Тийм учраас ажлын хэсгийн ажиллах хугацааг намрын чуулган хүртэлх, намрын чуулганы хугацаанд хүртэл ажиллахаар бол сунгах ийм бол саналыг ажлын хэсгээс гаргаж байгаа.

Гуравдугаарт болохоор энэ зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд ажлын хэсэг маань нийтдээ 5 удаа хуралдаан зохион байгуулж, зээлийн хүүгийн дээд тааз тогтоох талаар гаргасан тодорхой эрдэмтдийн саналыг хэлэлцэх эд нарыг зэрэг ийм ажлуудыг зохион байгуулсан. Ингээд Ерөнхий ажлын хэсгийн дүгнэлт, саналыг та бүхэнд ингээд хүргүүлсэн байгаа. Та бүхэн харж байгаа.

Ингээд ерөнхий дүгнэлт юу байна вэ гэхээр стратегийн ерөнхий хүрээ бол их зөв тодорхойлогдож гарсан байна. Гэхдээ зээлийн хүүг бууруулах ажил маань хэрэгжсэнгүй. Энд болохоор мэдээж гадаад, дотоод орчны олон хүчин зүйлс нөлөөлсөн. Гэхдээ энэ дотор ялангуяа энэ зээлийн хүүг бууруулахтай холбоотой хууль, эрх зүйн орчны өөрчлөлт нэлээн чухал юм байна гэж харж байгаа. Та бүхэн хэрвээ харж байгаа бол тэр хүснэгт дээр энэ зээлийн хүүгийн зардлын бүтэц байгаа. Энэ судалгаагаар харахаар зээлийн хүүгийн зардлын бүтцэд эх үүсвэрийн зардал 60 хувийг эзэлдэг. Дараагаар нь эрсдэлийн зардал нь 13 орчим хувийг, үйл ажиллагааны зардал 14 хувийг, ашгийн марж нь 5 хувийг, зохицуулалттай холбоотой зардал 8 хувийг гээд иймэрхүү байдлаар эзэлдэг байгаа.

Хэрвээ бид нар хууль эрх зүйн орчинд тодорхой хэмжээний өөрчлөлт оруулаад болон Засгийн газар болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг холбогдох байгууллагууд тодорхой ажлуудыг зохион байгуулж чадах юм бол ер нь 4 жилийн хугацаанд бас хэрвээ гадаад, дотоод орчны огцом өөрчлөлт байхгүй бол бас хүүг бууруулах боломж байна гэж харж байгаа.

Тийм учраас болохоор ажлын хэсгээс дүгнэлтээ гаргаад саналуудаа боловсруулж байгаа. Тэгээд ирэх Эдийн засгийн байнгын хорооны хурлаар тогтоолын төслөө танилцуулахаар ингэж бэлтгэж байгаа гэдгийг та бүхэндээ танилцуулъя.

Тэгэхээр өнөөдөр гаргуулах гээд байгаа гол шийдвэр маань юу гэхээр ажлын хэсгийн ажиллах хугацааг намрын чуулган хүртэл сунгах ажил байна гэж та бүхэн ойлгох хэрэгтэй. Ингээд асуулт байвал асуултад хариулъя.

А.Ундраа: Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр тасалъя. Сайнзориг гишүүний микрофон.

П.Сайнзориг: Иргэдэд нэг зүйлийг л яг бодит үнэнээр нь хэлмээр байна. Үнэнээр нь. Сүүлдээ энэ юун дээр чинь улс төр хийдэг улс төрийн нам хүртэл гарч ирсэн шүү дээ. Юу гэдэг нөхөр билээ байз 1 нөхөр байгаа. Банкны дарангуйлалд орсон Монгол Улс ч билүү ийм юм яриад явдаг. Тэгэхээр хэдүүлээ энийг иргэдэд

ойлгохгүй болохоор иргэд маань ерөөсөө бас энэ асуудлыг бас том хүлээлт үүсээд л буурах юм байна гэдэг л энэ явдаг. Энэ сэдлээрээ бид хэд зээлийн хүүгийн асуудлыг илүү их бас хэрэглээний болон арилжааны бизнесийн зээлээр ялгаж яримаар байна. Ерөнхий юм яриад байна.

Хэрэглээний зээлийн асуудал дээр зээлийн хүүгийн тааз тогтоох энэ тэр асуудал бусад орны хуулиуд дээр байдаг. Германаас эхлээд, японоос эхлээд, зүүн өмнөд азийн орнууд дээр байгаа. Би яагаад энийг мэдэж байна гэхээр би энэ Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг баталж, хувь хүнээс олгож байгаа тогтвортой зээлүүд болон энэ ломбардаас олгож байгаа зээлийн асуудлыг зохицуулах энэ хуулийг өнгөрсөн парламентаар батлуулсан юм.

Харамсалтай нь яах вэ энэ хэрэглээний зээл дээр зээлийн хүүгийн таазыг тогтоох энэ асуудлыг шийдсэн боловч, уг заалт маань бас Цэц дээр маргаан үүсчихсэн ингээд жоохон явж байгаа юм байна лээ.

Арилжааны зээл, бизнесийн зээл дээр зээлийн хүүгийн таазыг тогтооно гэсэн ойлголт байхгүй. Энийгээ хэдүүлээ харин яаж хүртээмжийг нь нэмэгдүүлэх вэ? Хэрэглээний зээл рүү яваад байгаа банкны системд нөлөө бүхий банкнууд чинь ерөөсөө хэрэглээний зээл дээр ашгийн марж нь хийж байна шүү дээ. Энийг яаж өөрчлөх вэ гэдэг зүйлийг бид нар бодлогоор бодмоор байна. Өөрөөр хэлэх юм бол бизнесийн зээлийг олгох тэр нийлүүлэлт, нийлүүлэлтийг яаж нэмэгдүүлэх вэ гэдэг л энэ бодлогоо ойлгомжтой, цэгцтэй болгомоор байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт өгсөн зээлийг буцаан төлүүлэх асуудал дээр гараад байгаа тэр зардлыг яаж бууруулах вэ буюу Соронзонболд гишүүний хэлж байгаа эрсдэлийг яаж бууруулах вэ? Дээрээс нь энэ банкны системүүдийн хоорондоо илүү зардал гаргаад байгаа, менежментийн нэмэлт зардал олоод байгаа зүйлүүд дээр хамтарсан энэ дэд бүтцийг шэйринг хийх буюу хуваалцах байдлаар энэ зардлаа бууруулах бололцоо байна уу гэдэг зүйлүүдийг бид нар бас ингэж ултай, суурьтай авч үзмээр байгаа юм.

Тэгээд яг энэ зээлийн гэдэг юм уу энэ асуудлыг бид хэд бас бодитойгоор хэрэглээний болоод арилжааны гэдэг байдлаар ингээд стратегийн хувьд авч үзэж бас нарийвчилж зээл, зээлийнх нь бүтэц онцлог байгаа. Энэ дээр нь ялгамжтай байдлаар энэ асуудалд хандахгүй бол ерөнхий ийм байдлаар яваад үр дүн гарахгүй. Өнөөдөр яах вэ Улсын Их Хурал дээр хэлэлцүүлэхээр орж ирээд байгаа Арилжааны хууль, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль, эргээд энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг баталж чадвал бас нэлээн томоохон алхмууд болно. Миний бие ч гэсэн Шүүхийн бус журмаар өр барагдуулах тухай хуулийг бас өргөн барихаар бэлтгэл ажлыг хангаж байгаа.

Дээрээс нь цаашдаа бид хэд яривал хувь хүний дампуурлын хуулийг ч гэсэн ярина. Тэгэхдээ бид хэд аж ахуйн нэгж, байгууллагынхаа дампуурлын асуудлыг ярьж чадаагүй байж байж бас хувь хүний дампуурлын асуудлыг ярихад эрт байгаа. Би яагаад энийг хэлж байна гэхээр ерөнхийдөө манай энэ банкны систем нөлөө бүхий банкнууд хөдлөх хөрөнгүүд.../минут дуусав./

А.Ундраа: Сайнзориг гишүүнд 1 минут нэмж өгье.

П.Сайнзориг: Хөдлөх эд хөрөнгүүд буюу мал барьцаалж зээл олгож байгаа. Энэ нь өөрөө эргээд хувь хүний дампуурлын ярихад эрт байгаа. Магадгүй энэ

банкны системийг энэ зээлүүдээрээ дагаад нураах, унагаах энэ эрсдэл байгаа. Тэгэхээр ер нь ажлын хэсгээс энэ зээлийн энэ асуудлыг нийлүүлэлт дээр юу гэж бодож байгаа юм, эрсдэлийг бууруулах дээр юу гэж бодож байгаа юм? Дээрээс нь энэ шэйринг хийх энэ асуудлыг ямар стратеги баримтлаад байгаа юм? Ер нь хэрэглээний, арилжааны зээлийг ялгамжтай байдлаар зохицуулах бодол дээр таны ажлын хэсэг хэрхэн яаж ажилласан юм бэ? Товчхон хариулт өгөөч гэж хүсэж байна.

А.Ундраа: Ажлын хэсгийн ахлагч Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Тэгэхээр ер нь я ялангуяа тэр бизнесийн зээл олгоход барьцаа хөрөнгийн шаардлага хэт өндөр байна. Тийм учраас үл хөдлөх эд хөрөнгөөс бусад хөрөнгүүдийг барьцаалах боломжуудыг нээх тал руу нь ажиллах ёстой гэдэг ийм чиглэлтэй байгаа. Бидний авсан Монголбанкнаас, Санхүүгийн зохицуулах хорооноос болон Монголын банкны холбоо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос авсан судалгааг харахаар ихэнх улсуудад ЖДҮ-лэлийг дэмжих чиглэлээр тодорхой сангууд тусдаа байгуулсан нэгдүгээрт.

Хоёрдугаарт, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг нэлээн өргөжүүлсэн. Яг тухайн улсынхаа эдийн засгийн бодлоготой нийцсэн ЖДҮ-лэлийг дэмжих нарийвчилсан бодлого явуулсан зэрэг ийм олон ажлууд явуулж байж жижиг, дунд бизнесээ дэмжсэн, нөгөө талдаа зээлийн хүүг бууруулах ийм үр дүнд хүрсэн байна. Бидний ажлын хэсгийн зүгээс юу гэж харж байгаа вэ гэхээр ер нь аливаа бизнес эрхлэгч зөвхөн үл хөдлөх хөрөнгөөс хамаарахгүйгээр хөдлөх хөрөнгөө барьцаалах боломжтой байх ёстой. Тоног, төхөөрөмж мөн дээрээс нь худалдаа, борлуулалттай холбоотой хийгдэж байгаа гэрээнүүдээ барьцаалж зээл авах боломжтой байх ёстой.

Мөн олон жилийн турш хийгдсэн борлуулалтын, худалдан авалтынхаа түүхэн дээрээ үндэслээд зээл авах боломжтой гэх мэтчилний ийм боломжуудыг бүрдүүлэх ёстой гэж үзэж байгаа. Энэ ч утгаараа бид нар зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаанд зөвхөн зээл авсан мэдээлэл биш төрийн байгууллагууд болон хувийн компаниуд хоорондын борлуулалттай холбоотой, худалдан авалттай холбоотой мэдээллүүдийг оруулж тухайн зээлдэгчийн мэдээллийг баяжуулснаараа тухайн зээлдэгч барьцаа хөрөнгөө тавихгүйгээр зээл авах боломжийг бүрдүүлэх ёстой гэж үзэж байгаа. Энэ талаар дурдсан байгаа.

Таны дурдсан тэр малыг барьцаалж байгаа асуудал бас л байж болохгүй биш байх ёстой боломжтой зүйл. Харин энэ Монгол Улсын банкны системд үзүүлж байгаа эрсдэлийг мэдээж тухайн арилжааны банк өөрөө тооцож явж байгаа. Байгаль, цаг агаарын гэнэтийн нөхцөл байдлууд үүснэ. Энэ тохиолдолд нөгөө малын индексжүүлсэн даатгал гээд малын индексжүүлсэн даатгал гэдэг ийм бас даатгалын хэлбэр байгаа. Энд хамрагдаж болж байгаа. Нөгөө талдаа зээлийн эрсдэлийн даатгал гэдэг хэлбэрээр хамрагдаад явах боломж байгаа гэж харж байгаа.

Тэгээд тэр зээлийн эрсдэлийн зардал дээр гол нь Монголбанк 2019 онд хуульд, тухайн үеийн Засгийн газарт болохоор энэ зээлийн эрсдэлийн зардлыг бууруулахтай холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой Иргэний хуульд оруулах өөрчлөлт гээд нэлээн олон ийм хуулийн төслүүдийг өргөн барьсан юм байна лээ. Тэгээд тухайн өнгөрсөн 2025 он хүртэл бол Засгийн газраас ямар

нэгэн зээлийн эрсдэлийн зардлыг бууруулахтай холбоотой хуулийн төсөл орж ирээгүй. Тийм ч учраас болохоор ажлын хэсгийн санал дээр Засгийн газраас эдгээр хуулийн төслүүдээ оруулж танилцуулаач ээ гэдэг хэрэгжүүлэх ажил, үүрэг чиглэлийг өгч байгаа.

Нөгөө талдаа болохоор энэ эх үүсвэрийн зардлыг бууруулах чиглэлээр ажлын хэсгээс болохоор энэ тодорхой ийм зээлийн хүүг бууруулах багц хуулийн төслүүдийг саналыг оруулахаар ажиллаж байна гэж хэлмээр байна.

А.Ундраа: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Соронзонболд гишүүн ээ би малыг ерөөсөө барьцаанд авахыг буруу гэж хэлээгүй байхгүй юу. Авч байгаа нь эрсдэл байгаад байгаа юм. Энийг хүний дампуурлын асуудлыг ч гэсэн ярихад одоо хэцүү байгаа, ийм байгаа нөхцөлд ч хэлсэн шүү. Энэ өөрөө ингээд олон нийтэд буруу мессеж өгчих гээд байгаа юм.

Би бусад таны саналуудыг дэмжиж байгаа юм. Жишээ нь факторингийн гэрээ гэж байдаг манай иргэний эрх зүй, арилжааны эрх зүйд маш том нөлөө үзүүлж болохуйц боловч манай арилжааны банкнууд энэний ач холбогдлыг ойлгохгүй байгаа. Хувийн хэвслүүд маань ойлгохгүй. Факторингийн гэрээг амилуулах ганц юм маань өөрөө эргээд төсвийн хөрөнгө оруулалттай үед яг цаг тухайдаа бас төрийн сангаас мөнгө нь шилждэг байж байж амилдаг. Магадгүй энэ төсвийн хөрөнгө оруулалтаар энэ сургуулийг барих гэж байгаа юм. Би яах вэ мөнгө нь 30 хувьдаа хүрээд ирэх юм бол ороод ирнэ ээ гээд гэрээн дээрээ байгаа юмыг банк барьцаалаад мөнгөн урсгалаар нь дэмжээд өгдөг., жижиг компаниудыг. Тэгэхээр төрийн сан дээр очоод энэ чиглэлийнх нь хугацаа нь болоод, гүйцэтгэл нь болчхоод байхад гүйцэтгэлээр мөнгийг нь шилжүүлэхгүй удах л юм Факторингийн гэрээний ач холбогдол байхгүй. Нөгөө жижиг аж ахуйн нэгж байгууллага чинь гэрээ.../минут дуусав./

А.Ундраа: Соронзонболд гишүүн нэмж хариулъя.

Л.Соронзонболд: Сайнзориг гишүүн маш зөв асуудал ярьж, санал ярьж байна. Ялангуяа Монголын банкны холбооноос ч тэр банк бус санхүүгийн болоод холбооноос ч тэр энэ авлагатай холбоотой, факторинготой холбоотой нэлээн хэдэн саналууд ирсэн байгаа. Ялангуяа энэ факторингийн асуудлыг зээлийн мэдээллийн санд оруулах нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой асуудлууд байгаа. Энэ авлага, өглөг хоорондоо шилжиж байгаа асуудал дээр. Тэгэхээр эдгээр асуудал дээр бас ингээд тодорхой арга хэмжээ авч өгөөч ээ гэсэн ийм саналыг ирүүлсэн. Үүн дээр нь ажлын хэсэг ажиллана гэдгийг та бүхэнд хэлье.

А.Ундраа: Мандхай гишүүний нэрийг нэмж оруулъя. Мандухай гишүүний микрофоныг нээе.

М.Мандхай: Яг зээлийн хүүг бууруулахад олон хүчин зүйл угаасаа байгаа. Түүний нэг нь макро эдийн засгийн хүчин зүйл байгаа шүү дээ. Тэгэхээр одоо яг манай инфляц аягүй өндөр байгаа дээрээс нь валютын ханш өөрөө тогтворгүй өндөр байгаа дээрээс нь зээл. Энэ төсвийн алдагдлын асуудал бид нар бас алдагдалгүй төсөв байлгах, дээрээс нь өөрөө энэ нөгөө нийт орж байгаа орлого өөрөө буурчихсан ийм нөхцөл байдал үүсэж байгаа нөхцөлд манай яг энэ зээлийн

хүүг бууруулах боломж ер нь хэр байгаа вэ гэдэг дээр бас яг бодитой хариулт өгөөч ээ гэж хэлмээр байна.

Дээрээс нь энэ ялангуяа энэ ядуурал, энэ ажилгүйдлийн нөхцөл байдал хүнд байгаа нөхцөлд бид нар эрсдэлийн үнэлгээг сайжруулах шаардлага үүсэж байгаа. Тэгэхээр энэ зээлдэгчийн яг энэ мэдээллийн чанар ил тод байдал ер нь хэр байгаа юм? Зээлдэгчийн өөрийнх нь энэ чанарын асуудал яг ямар түвшинд байгаа юм? Хэрэв үнэхээр зээлдэгч чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа энэ маш олон энэ банк бус болон энэ зээлийн энэ хүүгүй олгодог зээл хүүтэй, өндөр хүүтэй олгодог зээлүүдтэй холбоотой асуудал дээр эргэн төлөлтийн асуудал. Яг бодит нөхцөл байдал ямар байгаа юм бэ? Энэ нь эргээд энэ зээлийн хүүг бууруулахад бас энэ чөдөр тушаа энэ хүнд нөхцөл байдал үүсэх вий гэдэг дээр асуумаар байна. Бодлогын хүү, төв банкны бодлогын хүү өөрөө бас бууруулах нөхцөл бүрдүүлэх нэгдүгээрт шаардлагатай байдаг.

Гэтэл яг бодитой энэ бодлогын хүүг бид нар бас яг шууд бууруулаад ингээд зээлийн хүүг бууруулах нөхцөл байдал яг бодит амьдрал дээр яг ямар байгаа вэ? Жишээлбэл, 23 оны эхээр бид нар Монголбанкны бодлогын хүү өөрөө 13 хувь өндөр тогтоож байсан. Үүнээс болоод бас энэ банкны хүү бас нөлөөлж нөлөөлж байсан ийм үзүүлэлт байгаа. Тэгэхээр энэтэй холбоотой бас мэдээллийг хэлж өгөхгүй юү гэж байна. Дээрээс нь энэ хэт бодлогын хүүг бид нар бууруулаад, зээлийн хүүг бууруулахтай холбоотойгоор бас эрсдэл нь өөрөө банк яг бодитой зээл олгох түвшин бас буурна.

Одоогийн байдлаар яаж байгаа гэхээр арилжааны банкнууд хаашаа илүү их мөнгө вэ гэхлээр байгууллага руу зээлээ олгодог, банк бусад мөнгө өгөөд дээрээс нь банк бус нь өндөр хүүтэйгээр ингээд ийм байгууллагаас би тү би/B to B/ байдлаар ингээд зээл олголтууд хийгдээд яваад байдаг. Яг иргэнд очиж байгаа ч гэдэг юм уу яг бодитой масст чиглэсэн зээлийн хэмжээ олигтой ерөөсөө буурч өгдөггүй. Тэгэхээр яг энэ нөхцөл байдлуудыг түшээд яг өнөөдөр яг бодитой зээлийн хүү буурах боломжтой юм уу гэдэг дээр би бас хариулт авах гэсэн юм.

А.Ундраа: Ажлын хэсгийн ахлагч Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Мандхай гишүүн маш энэ макро орчны асуудал энэ бодлогын хуультай яаж уялдаж байгаа вэ гээд маш зөв асуулт асууж байна. Тэгэхээр 2020 онтой харьцуулах юм бол манай улсын ДНБ 2 дахин өссөн үүнийгээ дагаад манай төсөв тэлсэн урсгал зардал маань тэлсэн хөрөнгийн зардал маань бараг 32.6 дахин өссөн. Энэ бүхэн маань эргүүлээд бас нөгөө улсынхаа инфляцад тодорхой хэмжээнд нөлөөлж байгаа юм.

Нөгөө талдаа манай валютын ханш дээр нөлөөлж байгаа юм. Энэ бүхний эсрэг бодлого авахын тулд Монголбанк зайлшгүй бодлогын хүүгээ өсгөх ийм нөхцөл байдал үүссэн. Нөгөө талдаа энэ зөвхөн макро орчноос гадна, гадаад орчинтой та мэдэж байгаа. КОВИД гарсан КОВИД-ын дараагаар болохоор бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээний тасалдал үүссэн, бараа, бүтээгдэхүүн цаг хугацаандаа ирдгээ больсон. Дээрээс нь Орос ингээд сүүлд Трампын тарифын ингээд ийм олон нөхцөл байдал бас манай улсын гадаад орчинд нөлөөлж байгаа юм. Ингэнгүүт би манай улс болохоор өөрөө эдийн засгийн хувьд уул уурхайн салбараасаа хэт хамаарсан улс учраас уул уурхайн бүтээгдэхүүний үнэ унангуут тэрийг дагаад манай эдийн засаг өөрөө уначхаж байна. Энийгээ бид нар засах ёстой.

Тийм учраас бид нар эдийн засгийн бүтцээ өөрчлөх ёстой. Эдийн засгийн бүтцээ өөрчилъе. Өөр экспортын бүтээгдэхүүн юу байна гээд үзэхээр ноолуур байна, мах байна, ганц хоёр согтууруулах ундааны төрлийн бүтээгдэхүүнүүд байж магадгүй. Өөр одоохондоо яг сайн хөгжиж байгаа юм байхгүй байна шүү дээ. Тийм учраас Монгол Улсын макро эдийн засгийн бодлого бол энэ экспорт нэмэгдүүлдэг энэ уул уурхайн бусад салбарыг яаж хөгжүүлэх вэ гэдэг дээр манай Эдийн засгийн хөгжлийн яам нэлээн сайн анхаарч ажиллах ёстой байгаад байгаа юм. Ингээд макро орчин талаасаа ийм асуудлууд байгаа учраас бас өнгөрсөн хугацаанд бодлогын хүүг бууруулах ийм боломж ерөөсөө байсангүй. Өнөөдрийн нөхцөл байдал ч гэсэн бас шууд бууруулах боломж бага байна гэж харж байгаа.

Ажилгүйдэл ядууралтай холбоотой энэ зээлийн мэдээлэлтэй холбоотой асуудал та асуулаа. Өнөөдөр яг иргэдийн зээлийн чанаргүй зээлийн хувь хэмжээ нь бизнесийн зээлийн чанаргүй зээлийн хувь хэмжээнээс бараг 2-3 дахин бага байгаад байгаа юм. Тийм учраас арилжааны банкнууд хэрэглээний зээл олох дээр банк бус санхүүгийн байгууллагууд хэрэглээний зээл олох дээр их илүү их анхаараад байна. Ингээд эхлэхээр чинь нөгөө бизнесүүдэд очиж байгаа зээлийн хүү нь багасчхаад байна. Эрсдэл нь өндөр байгаа учраас зээлийн хүү нь өндөр болчихоод ийм асуудал байгаад байгаа. Тэгээд энэ иргэдийн зээлийн мэдээллийн чанар ямаар байгаа юм бэ гэж асуугаад байна.

Ер нь Монголбанкин дээр энэ зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг яг бодит цагийн горимоор хүлээж авч, мэдээлдэг байх дээр нэлээн бас ажил хийх шаардлагатай юм байна гэж Ажлын хэсгийн зүгээс дүгнэж байгаа. Ер нь бас ний нуугүй хэлэхэд хэд хэдэн банк бус санхүүгийн байгууллагын онлайн аппликэйшн зээлээр зэрэг зээл авдаг асуудал бас нэлээн байдаг юм билээ. Үүнтэй холбоотойгоор зээлийн өрийн дарамтад орж байгаа асуудал байгаа.

Тийм учраас энэ дээр бас нэлээн анхаарч байгаа. Тэр ч утгаараа Монгобанкнаас ч тэр, Санхүүгийн зохицуулах хорооноос ч тэр өр, орлогын харьцааг бас тогтоож ажиллаж байгаа нь бас нөгөө талдаа бас иргэддээ хэтэрхий их өрийн дарамтад орохоос сэргийлсэн зөв ажил байна гэж харж байгаа юм.

Нөгөө талдаа яг өнөөдөр хэдийгээр ингээд бодлогын хүү буурах боломж бага байна. Гэхдээ жишээлбэл би манай Монгол Улсын нийт Монгол Улсынхаа иргэдээс аж ахуйн нэгжүүдээс авч байгаа ингээд нийт хадгаламж харилцахыг ингээд аваад үзэх юм бол бараг 40 хувь нь харилцах дээр байгаад байгаа юм. Харилцан хугацаагүй хадгаламж дээр байгаад байгаа юм. Энэ хүү өнөөдөр 3-7 хувийн хүүтэй ийм эх үүсвэр байгаад байгаа юм. Хэрвээ бид нар хуулиараа харилцах хугацаагүй хадгаламж дээр хүү тооцдогийг зогсоочих юм бол энэ 40 хувийн эх үүсвэр маань 0, хүүгүй болно. Ингэснээрээ эх үүсвэрийн зардал буураад эхэлнэ. Энэ нь эргээд бизнесийн зээлүүдийг жишээлбэл хүү багатай болгох боломжийг бүрдүүлэх боломжтой юм байна гэж үзэж байгаа учраас ажлын хэсгээс энэ зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах энэ хуулийн багц төслүүдийг ажлаар санаачилж оруулахаар төлөвлөж байгаа.

Нөгөө талдаа Засгийн газрыг зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах энэ хуулийн төслүүдийг өргөн бариач ээ гэдэг ийм шаардлагыг тавьж байгаа юм гэдгийг та бүхэнд хэлье. Нөгөө талдаа тэр банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулж зээл олгох бол Санхүүгийн зохицуулах хорооноос хоригло.../минут дуусав./

А.Ундраа: Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Сая тэгээд хэллээ. Тэгэхээр ер нь макро орчны нөхцөл байдлыг бид нар бас тооцож үзэж байж бас яг энэ зээлийн хүү бууруулах эсэхийг ер нь шийдэх юм байна. Тэгэхээр хугацааны хувьд хараахан яг ингээд зээлийн хүү бууруулах боломж, бололцоо бага байна гэж харж байна. Хоёрдугаарт, түрүүн хэллээ харилцах данс болон хугацаагүй хадгаламжийн хүү 3-7 хувьтай байгааг бууруулна гэсэн үг үү? Тэгэхээр одоо байгаа бид нар хугацаатай хадгаламжид байрлуулна гэдэг чинь орлогын эх үүсвэр өөрөө хангалттай боломжтой учраас хугацаатай хадгаламж нь мөнгөө татаж авахгүйгээр зарцуулж байгаа шүү дээ. Тэгэхээр хугацаатай хадгаламж гэдэг чинь үндсэндээ ээ бас яг ингээд орлогын эх үүсвэр өөрөө ингээд тогтвортой биш учраас тэрийг ингээд хугацаатай хугацаагүйгээр тодорхой хүү бага хүүтэй ч гэсэн байршуулаад эргээд татаж авч байгаа. Тэгэхээр энэ үүсгэж байгаа энэ бүлэг иргэдийн үндсэндээ хүүг бууруулж өгөх юм уу? Тэгэхлээр чинь эх үүсвэр угаасаа буураад.../минут дуусав./

А.Ундраа: Соронзонболд гишүүн тодруулж ярья.

Л.Соронзонболд: Ер нь манай Монгол Улсын энэ хадгаламж тэр энэ хугацаагүй хадгаламж гэдэг чинь өөрөө ингээд бас ийм тодорхой хэмжээнд өөрсдөө эрсдэлээс хамгаалах зорилгоор богино хугацаатай хүмүүс байршуулж байгаа байхгүй юу. Жишээлбэл өчигдөр Олон Улсын Валютын Сангийн уулзалт дээр та бүхэн бас долларжилт дээр анхаараарай гэж хэлж байгаа юм.

Яагаад тэгж хэлж байна вэ гэхээр ерөнхийдөө манай арилжааны банкнуудын хугацаатай хадгаламжийн 50 орчим хувь нь одоо богино хугацаатай байгаад байгаа. Жилийн дотор хугацаатай мөнгөө хадгалж байна гэсэн үг. Тэгэхээр арилжааны банкнууд дээр жишээлбэл 1 сарын хугацаатай, 2 сарын хугацаатай ч юм уу ийм хадгаламжийн бүтээгдэхүүнүүд байгаа. Тэгэхээр жишээлбэл хугацаагүй хадгаламжид мөнгөө хийгээд тэн дээр 6, 7 ... авч байсан хүн 1 сарын хугацаатай яг тогтмол хийгээд мөнгөө авах боломж нь нэгдүгээрт байж байгаа.

Хоёрдугаарт, тэр хүн бас өөрийнхөө хөрөнгийг хөрөнгийн бирж дээр ч юм уу тодорхой хэмжээнд байршуулаад тэгээд тэндээсээ бас богино хугацаатай орлого олох боломж байж байгаа. Тэгэхээр эрсдэл гэдэг.../минут дуусав./

А.Ундраа: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

“Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэлтэй танилцаж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё. Айн сунгая гээд үү? Тэрийг та албан бичгээр явах ёстой юм байна лээ Их Хурлын дарга руу. Тогтоолоо хар л даа. Дараагийн асуудалдаа оръё.

11.54 цаг

“Сэлбэ дэд төв”-ийн нийгмийн хангамж болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Үндэсний Аудитын газар, Нийслэлийн засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад байгууллагын мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн гишүүд суудлаа эзэлж байна. Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Түмэндалайн Даваадалайг мэдээллийг танилцуулахыг урьж байна. Ажлын хэсгийн микрофоныг нээнэ үү 2 дугаар микрофон. 2, 3 уу? 3 дугаар микрофон дээр Даваадалай. Даваадалай 2 дугаар микрофон нээгдчихсэн байна хажуу талынх нь. Уучлаарай шилжүүлэе 3 дугаар микрофоныг нь нээчих үү. Даваадалай дарга танилцуулгаа.

Т.Даваадалай: Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

А.Ундраа: Ажлын хэсгийг танилцуулъя. Танилцуулгыг уншаад тэгээд ажлын хэсгээ танилцуулъя. Даваадалай орлогч

Т.Даваадалай:Танилцуулга юм уу, танилцуулга уу?

А.Ундраа:Даваадалай минутыг нь эхнээс нь явуулах уу тэгээд танилцуулгаа унших хэрэгтэй. Та саяын цаг яваад байгаа шүү дээ.

Т.Даваадалай: Гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Сэлбэ хотын бүтээн байгуулалтын талаарх танилцуулгыг хийе. Сэлбэ хот маань ЧД-ийн 14, 18 дугаар хороо СБД-ийн 13, 14 дүгээр хороонд Сүхбаатарын талбайгаас 5.2км зайд иж бүрэн хот байгуулах төслийг хэрэгжүүлэхээр явж байгаа. Одоогийн байдлаар Сэлбэ хотод маань, Сэлбэ хот маань бүтээн байгуулалтын хувьд энэ 158 га дээр хот байгуулах ийм төслийн багц явж байгаа. Нийт 45 багц ажлаас бүрдэнэ.

Бүтээн байгуулалтыг жишээ хэлэхэд 1974-82 онд хийгдсэн 3, 4 дүгээр хорооллын хэмжээний ийм бүтээн байгуулалтыг, дээрээс нь 6 дугаар бичил хорооллын бүтээн байгуулалт тухайн үед 149 га дээр хийгдэж байсан. Манай Сэлбэ хот маань 158 га дээр 45 багцаар хот байгуулах ийм төсөл явж байгаа.

Төслийн нийт ерөнхий мэдээллийн хувьд болохоор 3 сургууль, 5 цэцэрлэг, 1200 хүүхдийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, төрөх, гэмтэл согог, төрөх эмнэлэг, хүүхдийн хэвтэн эмчлүүлэх төвүүдтэй худалдаа үйлчилгээний иж бүрэн цогцолборыг тухайн бүс нутагт хамруулж хийхээр. Нийт га талбай нь ногоон байгууламжийн га талбай 36 хувь төслийн хэмжээнд 158 га дээр байхаар, хөрөнгө оруулалтын хувьд болохоор Нийслэлийн босгосон бонд, төр, хувийн хэвшлийн түншлэлээс орох орлогоор гэсэн ийм хэрэгжүүлэхээр төсөл явж байгаа. Ки Пи Ай/KPI/-ын хувьд болохоор нийт төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын хэмжээнд 15600 яндан буулгана гэдэг үндсэн Ки Пи Ай/KPI/-ын үр дүнтэй, орон сууц нь 10063, 113 блок 158 га дээр хэрэгжихээр байна. Төслийн хүлээгдэж буй үр дүн нүхэн жорлонг 1200-гаар нүхэн жорлонг буруулах болно.

Хөрсний эвдрэл, гэр хорооллоос үүдэлтэй хөрсний эвдрэлийг 0.5 хувийг 2.1 хувь болгож бууруулна. Хөрсний бохирдлыг бас бууруулахаар үр дүнтэй. Агаарын бохирдлыг, гэр хорооллын үүдэлтэй агаарын бохирдлын эхний ээлжид 1.4 хувь, цаашлаад 7.7 хувиар хотын хэмжээнд нөлөө үзүүлэхээр ийм тооцоолол гарсан. Тоосжилт РМ 2.5, 1.6 хувиар багассан, айлуудыг нүүлгэснээр ийм үр дүн гарсан байж байгаа. Мөн тухайн бүс нутагт нэг цэгийн үйлчилгээ, нягтарш, иргэдийн нягтаршлыг бууруулах, Улаанбаатарын хэмжээнд ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх, ДНБ Улаанбаатарын хэмжээнд симуляц хийж үзэхэд төсөл хэрэгжиж дууссанаас 2.5 дахин Улаанбаатарын хэмжээнд ихсэхээр ийм төлөвлөлт гарсан.

Төвлөрлийн хувьд төвлөрлийг 4.2 хувиар сааруулахаар ийм тооцоотой. Тээврийн системийн хувьд Сэлбэ хотын маань голоор LRT буюу трамвайны төсөл хэрэгжинэ. Ихэссэнээрээ өдөрт 35 мянган зорчигч тээвэрлэх ийм хүчин чадалтай. Үүнтэй уялдуулаад автомашины хэрэглээ доод тал нь 17 хувиар буурахаар ийм төслөөс хүлээгдэж байгаа үр дүнгүүд байна.

Төслийг хэрэгжүүлэх цаглаврын хэмжээнд ярихад 2022 онд “Сэлбэ дэд төв”-ийн Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа дэд бүтцүүдийн ажил хийгдээд ерөнхийдөө дуусаад 2 дугаар үе шат хэрэгжээд 60 хувьтай явж байгаа. Сэлбэ орчмын гэр хорооллыг орон сууцжуулах үүргийг Нийслэлийн орон сууц корпорацад 2024 онд даатгасан. 2025 оны 2 дугаар сард тус хотыг байгуулах Сэлбэ 20 минутын хот корпорац ХХК-г НИТХ-аар байгуулж, төсөл хэрэгжүүлэх бүрэн эрхийг 2025 оны 2 дугаар сард шилжүүлсэн байна.

Тус Сэлбэ 20 минутын хот корпорац маань үйл ажиллагаагаа эхлүүлж Сэлбэ төвийн нийт 45 багц ажлын 1, 2 дугаар багцын тендер сонгон шалгаруулалтыг 2025 оны 3 дугаар сард зарласан. 2024, 2025 оны 4 дүгээр сарын 23-наас үнэлгээний процесс эхэлсэн. Цаашлаад гэрээлээд одоо 3, 4 дүгээр багцыг 6 сарын 18-нд нээх үе шаттай ажил үргэлжлээд явж байсан гэдэг ийм цаглаврын хувьд ерөнхийд нь хэлж болно.

Тендер шалгаруулалтын үе шат дээр түрүүн сая хэллээ. 1, 2 дугаар багцыг шалгаруулалт дээр 2025 оны 5 сарын 7-нд нээгдэж, гэрээлэх үе шат дээр явж байгаа эхний хэлэлцээрүүд.

3, 4 дүгээр багцыг тендерийг 2025 оны 5 сарын 9-нд зарласан. Цаглавар хугацаагаар бол 2025 оны 6 сарын 18-нд нээхээр ингэж хуульд заасны хугацаанд уг нь нээгдэхээр байсан. Гэвч Монополын эсрэг газраас иргэдээс ирсэн гомдолтой холбогдуулаад 0/1381 тоотоор түр түдгэлзүүлчихсэний улмаас 3, 4 дүгээр багцын тендер хариу хүртэл нээгдэхээргүй түр хүлээгдэж байгаа. Үргэлжлүүлээд бид нар 5, 6 дугаар багц 7, 8 гээд эхний 11 багц дээр төлөвлөгөөтэй үйл ажиллагаануудыг цаашаа тендер зарлагыг нь зарлаад хийхээр төлөвлөж байгаа.

Багцуудыг хэлэхэд түрүүн би хэлсэн нь Сэлбэ 158 га дээр хийгдэж байгаа хот. Сүүлийн шинэчилсэн төлөвлөгөөгөөр нийт 45 багц дээр ажил хэрэгжинэ. Үүний эхний 11 багц нь орон сууц, инженерийн барилга байгууламж байж байгаа. Үүнээсээ эхний 4 багц нь орон сууцын хэсэг түрүүний хэлдэг. 5 дугаар багц гадна дулаан, усан хангамж, 6 дугаар багц хөрсний ус зайлуулах, 7 дугаар багц гадна цахилгаан хангамж, 8 дугаар багц гадна шугам хоолой, 9 дүгээр багц гадна дулааны эх үүсвэр гээд ингээд эхний 11 багц орон сууц, инженерийн барилга байгууламж, 12-19 дүгээр багцууд нийгмийн дэд бүтцүүд буюу сургууль, цэцэрлэгийн багцуудыг бид нар төр, хувийн хэвшлийн түншлэлээр мөн 2026 оныг боловсролыг дэмжих жил болгосонтой холбогдуулан Боловсролын яамтай ярьж байгаа сургууль, цэцэрлэгүүдийг бас шийдэхээр байж байгаа.

Багц 21-45 буюу энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар нийгмийн үйлчилгээнүүд худалдааны төв, үйлчилгээний төвүүдийг бид нар тэнд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн дагуу нээлттэй уралдаан зарлаж хэрэгжүүлэхээр манай Сэлбэ 20 минутын хотоос өнгөрсөн долоо хоногоос зарлалуудыг албан ёсны веб сайтуудаар байршуулж, хувийн хэвшлүүдээс Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн дагуу саналуудыг хүлээж авч байгаа

ажлууд яг өнөөдөр үргэлжилж байна. Багц 20-25 дугаар багцууд дээр. Тэгэхээр Сэлбэ хот маань нийт ийм 45 багц хэрэгжих ийм том төсөл байж байна.

Төр, түншлэлийн түншлэлээр хамтрах төлөвлөлтийн бүс нь 41.5 га байгаа 158 гагаасаа. 26 хэсэгт үйлчилгээний талбайтай. Урьдчилсан төлөвлөгөөгөөр үйлчилгээ, номын сан, кино театр зэрэг ийм нийгмийн үйлчилгээний төвүүд байхаар ингээд төлөвлөөд явж байгаа. Нийт түрүүн 20-45 дугаар багцуудын барилгажилтын талбай, га талбай, нарийн мэдээллүүдийг вэбсайт дээр байрлуулж, хүмүүстээ зарлал, хувийн хэвшлүүдэд хүргүүлж нээлттэй саналуудыг авах ажил явагдаж байгаа. Тэгээд саналуудыг авсны дараа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон Засгийн газрын 2 дугаар сард батлагдаж гарсан 210 дугаар тогтоолын дагуу үе шаттай сонгон шалгаруулалтыг хувийн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн дагуу хийж гүйцэтгэхээр төлөвлөөд бизнес төлөвлөлтийн дагуу өнөөдөр ажил явагдаж байна.

Тус Сэлбэ төвийн, Сэлбэ хотын хот байгуулах ажлын хүрээнд өмнө нь хийгдсэн инженерийн дэд бүтэц. ажлуудын хүрээнд товчхон танилцуулахад газар чөлөөлөлт 2206 нэгж талбараас өнөөдрийн байдлаар 92 хувь нь чөлөөлөгдсөн. 8 хувийн үлдэгдэлтэй. Тэр бусад 8 хувийн айлууд дээр хэлцэл хийгээд явж байгаа. Мөн түрүүний хэлсэн тэр төр, хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгэх байгууллагуудтай хамтарч бас чөлөөлөх хэсэг газрууд байж байгаа.

Авто замын хувьд 34 хувийн гүйцэтгэлтэй авто замын дэд бүтэц 6.1км авто зам, 13.1км явган зам гэх мэт замууд өмнө нь хэлсэн Азийн хөгжлийн банкны 2 үе шаттай хийгдсэн “GADIP” төслийн хэмжээнд Сэлбэ дэд төв дээр хийгдээд өнөөдөр явж байна.

Гадна дулааны хэмжээ дулаан хангамжийн хэмжээнд 15 хувийн гадна шугам хоолой болон эх үүсвэрүүдийг барьсан. Азийн хөгжлийн банкны өмнөх Сэлбэ дэд төвийн төслийн хэмжээнд 18 мега ваттын ДЦС Сэлбэ хотынхоо урд тал дээр, 63мвт-ын дулааны станц одоо ажил нь 17 хувийн гүйцэтгэлтэй Сэлбэ хотынхоо хойд талын хэсэг дээр гүйцэтгэгдээд явж байгаа. Мөн бид нар дахиад 1 дулааны эх үүсвэрийг гүний дулаанаар хийхээр ингээд төлөвлөөд явж байгаа. Нийт дулаан хангамжийн ажлын хувь 15 хувь гэж хэлж болно.

Цахилгаан хангамжийн хувьд болохоор нийт Сэлбэ хотын маань хэмжээнд одоогийн гүйцэтгэл 8 хувьтай гэж хэлж болно. Мөн түрүүн хэлсэн Азийн хөгжлийн банкны хэмжээнд түрүүний тодорхой хэмжээний шугам хоолой, дэд станцууд хийгдсэн. Шинэ хоттой уялдуулаад бид нар гадна цахилгаан хангамжийг 17 байршилтай дулааны цахилгаан байгууламж, 79 байрлал дээр Ки Ти Пи том хэлбэрээр байршуулах шаардлагатай гэдэг ажлуудыг төлөвлөөд явж байгаа. Энийг бас гадна цахилгаан хангамж дээр удахгүй багц 7-гийн хэмжээнд нээлттэй тендер зарлагдаад мөн явна.

Төслийн бэлтгэл, талбайн бэлтгэлийн хувьд болохоор ажил гүйцэтгэх талбайн бэлтгэлийн хувьд нийт 81 хувийн талбай бэлтгэсэн газар чөлөөлөлт, бусад хуучны нөгөө цахилгаан шугам хоолой худгууд болон цахилгааны холбооны, мэдээлэл холбооны хуучин шугам хоолойнууд чөлөөлөх ажлууд орж байгаа. Одоогийн байдлаар 81 хувийн гүйцэтгэлтэй хөрсний ариутгал, жорлонгийн хуучин нүхэн жорлонгийн ариутгах цэвэрлэх ажлууд ингээд гүйцэтгэгдээд энэ хүрээнд явж байгаа.

Гадна бусад инженерийн шугам сүлжээний хувьд нийт ажлын гүйцэтгэл 10 хувьтай явж байгаа. Нийт 158 га-гаас бид нар 10 хувийн инженерийн шугамжуулаад цэвэр, бохир усны шугам хоолой, үер усны байгууламжуудыг хийгээд явж байгаа. 90 хувийн ажлууд бусад багцын хэмжээнд цаашаа гүйцэтгэгдээд явахаар ийм ажлууд төлөвлөгдөөд эхний 11 багц дээр зарим ажлууд нь ороод явж байгаа.

Төслийн Сэлбэ минутын хот байгуулах төслийн нийт ганц чарт төлөвлөлтийн хувьд 2024 оноос анхны төлөвлөлт ажлаа эхлээд яваад бид нар 2027 оны төгсгөл рүү ажлын гүйцэтгэлийг хийхээр бүх үе шат, багцууд дээр төлөвлөснийг харж байна. Дэд бүтцийн ажлууд дээр цааш нь детальчлаад тайлбарлаад явахад авто замын гүйцэтгэсэн сүлжээ одоо 6.6км, гүйцэтгэхээр төлөвлөгдөж байгаа нэмж гүүрэн байгууламж 3 хэсэгтээ ингээд төлөвлөгдөж байна. Дулаан хангамжийн шугам 14км гүйцэтгэх усан хангамж ариутгах татуургын байгууламжууд 1000 м3 усан сангийн насос станц ширхэг байгуулна гэх мэт төлөвлөлтүүдийг хийгээд Азийн хөгжлийн банкны “GADIP” төслийн хэмжээнд 2 дугаар үе шатан дээр ажлууд 60 хувийн гүйцэтгэлтэй бас явж байгаа.

Үүний хүрээнд бас зүгээр товчхон танилцуулахад Сэлбэ дулааны төвд 28 мегаватт-ын станц, дулааны шугам 9.9км-т гүйцэтгэсэн, цэвэр усны шугам хоолой 9.3км-т, бохир усны шугам 15км-т гүйцэтгэсэн, 35, 10квт-ын дэд станцын цахилгаан хангамжийн шугам 3.5км дээр, мэдээлэл, холбооны нэгдсэн үйлчилгээний барилга 1 ширхэг холбооны шугам 5.5км-т дээр мөн гүйцэтгэгдээд байгаа.

Авто замуудын хувьд төлөвлөлтийн хувьд бид нар зурагт байршилд үзүүлсэн. Нийт ойролцоогоор 7км-т шахуу замуудыг туслах зам, гол замууд, дагалдах замуудтай төлөвлөөд бас явж байгаа. Гадна дулаан хангамжийн хувьд түрүүний хэлсэн дээр бид нар нэмээд Азийн хөгжлийн банкин дээр 63мвт-ын станц бол гүйцэтгэж байгаа түрүүний хэлсэн 28мвт-ыг гүйцэтгэгдчихсэн байгаа. Одоо нэмээд 63мв-ыг бас гүний дулаанаар шийдвэрлэх гээд суурь судалгааг нь өнөөдөр Монгол Улсын шинжлэх ухааны байгууллага хийж байгаа. Бид нар олон улсдаа бүрэн ТЭЗҮ, 1 өрөмдлөгтэй ийм ТЭЗҮ зарлах гээд гүний дулаан дээр бас ажлын даалгаврыг боловсруулаад явж байна. Ойрын хугацаанд бас нээлттэй тендер зарлана гэж гүний дулаан дээр тооцоолж байгаа. Нийт Сэлбэ хотын хэмжээнд 91.8мвт-ын дулааны ачаалал шаардлагатай гэсэн төлөвлөгөө гарсан байгаа.

Ус хангамжийн хувьд усны эх үүсвэр нь Дамбадаржаа болон Хайлаастын усан сангаас хангагдахаар төлөвлөгдсөн. Дамбадаржаагийн Дамбадаржаагаас усны хэрэглээний 20 хувь, Хайлаастын байгаа 1500м3-ын усан байгууламжаас 2000 дээр нэмж усан байгууламж хийж, одоо 80 хувийг нь Хайлаастаас 20 хувийг нь Дамбадаржаагаас усан хангамжийг хангахаар Сэлбэ хотынхыг төлөвлөөд үе шаттай ажлыг хийж байна.

Ариутгах татуурга байгууламж дээр бас мөн төлөвлөлтүүдийг хийгдээд гүйцэтгэгдээд явж байгаа. 7 буудал орчмын коллектор ер нь ариутгах татварын хувьд төвийн шугамд холбоно. Зарим захын хэсгүүд дээр жижиг хэмжээний ариутгах байгууламжуудыг хийхээр явж байгаа. Сэлбэ гэсэн үндсэн том коллектор 500-гийн шугамыг хүчин чадлыг цаашид үргэлжлүүлээд ингээд хийхээр төлөвлөөд явж байгаа. 600, 800-гийн шугам 1.8км-т хийхээр ингэж төлөвлөж төвийн шугам руу холбохоор төлөвлөөд явж байна.

Цахилгаан түгээх болон цахилгааны байгууламжууд дээр нийт 79 ширхэг Ки Ти Пи хаалттай хуваарилах байгууламжийг төлөвлөсөн байж байгаа. Түрүүн хэлсэн багцууд дээр тэр 7 дугаар багц дээр удахгүй тендер зарлагдаад цахилгаан хангамжийн түгээлтийн асуудлууд бас гүйцэтгэгдээд явахаар төлөвлөгдөөд ажиллаж байна.

Бусад инженерийн шугам сүлжээн дээр төлөвлөгдсөний дагуу ажлууд хийгдээд явж байгаа. Түрүүний эхний 11 багц дээр 3 багц багцууд дээр гадна шугам болон инженерийн шугам сүлжээний ажлууд бас тендер зарлагдаад гүйцэтгэгдэхээр ингээд төлөвлөж байна.

Нийтийн тээврийн хувьд болохоор хамгийн гол төлөвлөж байгаа нь болохоор бид нар Сэлбэ хотын голоор трамвайны, Улаанбаатар трамвайны 1 дүгээр шугам буюу Сүхбаатарын талбайгаас Зунжин хүртэлх нийт гол замын урт нь 10.7км урттай трамвайны шугамын ТЭЗҮ гүйцэтгэгдээд болчихсон. Ирэх долоо хоногт гэхэд Зам, тээврийн хөгжлийн төвөөр батлагдаад тэгээд ингээд төслийг цаашаа олон улсын баталгааны журмаар ингээд хэрэгжүүлэхээр төлөвлөгдөөд явж байгаа. Тэгэхээр трамвай маань 2.5 жилийн хугацаанд гүйцэтгэхээр ерөнхий хугацаа төлөвлөөд гарсан. 27 оны төгсгөл гэхэд ер нь Улаанбаатарын трамвайны 1 дүгээр шугам Сэлбэ хотын голоор дайрч өнгөрнө гэдэг нийтийн тээврийн ерөнхий төлөвлөлттэй ингээд гүйцэтгэж байгаа.

Сэлбэ 20 минутын хот, Сэлбэ хотын төслийн хөрөнгө оруулалт, төлөвлөгөөний хувьд танилцуулгыг хийе.

Ер нь хөрөнгө оруулалт, бонд болон төр, хувийн хэвшлийн түншлэлээс одоод хувийн хэвшлүүдээс санал болгох орлогоор ерөнхийдөө орлого бүрдэнэ гэж орлогын ерөнхий схем төлөвлөлтийг хийсэн. 2025-27 он онд төслийн багцууд дээр бид нар төслийн хотын төсөлтэй уялдуулаад 25, 26, 27 оны гүйцэтгэлүүдийг гаргаж төлөвлөсөн. Нийт эхний 11 багц тендер зарлаж, шууд хөрөнгө оруулалтаар хийх ажлууд нийт 2.3 их наяд гэсэн одоогийн тооцооллоор явж байгаа. Үүнээс 2025 онд гарах нь 1 их наяд, 2026 онд 800 тэрбум, 804 тэрбум. 2027 онд 520 тэрбум төгрөгийн санхүүжилтийг барилга угсралттай төслийн ганц ... төлөвлөгөөтэй уялдуулж гүйцэтгэлүүд гарч төслүүд хэрэгжихээр байна гэж төлөвлөж ажиллаж байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлтэй хам хамрах 26 байршил дээр санал аваад явж байгаа. Орон сууцын барилгын тооцоолол дээр товчхон мэдээлэл хүргэхэд одоогийн байж байгаа тооцооллоор нийт 10063 айлын өрхийн тендерийг 1-4 дүгээр багц дээр зарлаад эхний 2 багц гэрээлэх шатандаа явж байгаа. Үүн дээр айлуудын бас дундаж метр квадратаар нь хэлэхэд 30-40м²-тай айл 6.6 хувь, 40-50м²-тай айл 46 хувь, 50-60м²-тай айл 15 хувь, 60-70 нь 14 хувь, 70-80 нь 17.7 хувь ийм байхаар тооцоолол хийсэн. Нийт ашигтай талбай 498 мянга, дулаан зогсоолын ... 54 мянга, нийт барилгажих талбай эхний 4 багц дээр 10063 айл дээр 763887,30 байхаар эхний урьдчилсан байдлаараа тооцооллууд гарч байгаа. Гэвч бид нар 2025, 26, 27 оны энэ Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийн өсөлт, өрхийн дундаж орлогын тооцоолол эд нарыг хамаарах программ хангамж аппликэйшнээр Улаанбаатар хотын ДНБ-тэй уялдуулаад симуляц бас давхар гүйцэтгэж байна. Үүнтэй уялдуулаад дундаж үнэ метр квадратуудыг тодорхой хэмжээний бизнес төлөвлөлтийг тухайн үед нь гүйцэтгээд сайжруулаад явах ийм төлөвлөлтүүдийг давхар бас хийгдээд явж байгаа.

1, 2 дугаар багц дээр 1м2 дээр гарч байгаа дундаж зардал 3.7 сая төгрөгийн дундаж зардалтай байж байгаа. Багц 1, 2, 3 дээр газрын нийт талбай багц 1 дээр 10.3 га, багц 2 дээр 15.3 га, багц 3 дээр 19.9, багц 4 дээр ар 14.3 га талбай дээр ажлуудыг чөлөөлөөд одоо ингээд 1, 2-ын газар чөлөөлөлт яг багц 1, 2-ын хувьд газар чөлөөлөлт 98 хувьтай. 10-хан иргэн үлдсэн. Өнөөдөр ингээд хашаалаад барилга угсралтын бэлтгэл ажлыг хийгдээд явж байгаа ажил, хөрөнгө оруулалт үнэлгээний хувьд явж байна.

Сэлбэ төсөл дээр сүүлд нь нэмээд хэлэхэд 2024 оны 11 дүгээр сард нийт 17 хөрөнгө оруулагч нар 2 үе шаттайгаар 500 сая долларын бондыг Германы “Дойче” банкны андеррайтер банкны зарчмын дагуу бидний гаргасан ТЭЗҮ-ийн үндсэн дээр хөрөнгө оруулалтыг хийгээд өнөөдрийн байдлаар арилжааны банкнуудад хадгалагдаад эхний мөнгө сая 6 сарын 23-нд суларч, эхний төслийн эхний үе шатыг санхүүжүүлэхэд бэлэн болсон байдалтай эхний 2 дугаар багцаа гэрээлэх шатдаа ингээд бэлтгэл ажлыг хангаад явж байна.

Танилцуулж дууслаа. Баярлалаа.

А.Ундраа: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас оролцох гишүүд Нямбаатар Улаанбаатар хотын захирагч. Нямбаатар даргыг дуудаарай сая гадаа ярилцлага өгч байна гэсэн ороод ирэх байх. Даваадалай Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Гантулга ирсэн байна уу? Нэр нь гарахаар бас өөрийгөө яавал ирсэн эсэхээ харуулчихвал зүгээр байна. Гантулга Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга байхгүй байгаа юм байна. Дуудах хэрэгтэй шүү. Батцэцэг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дарга, У.Баатар Сэлбэ 20 минут хот корпорац ХХК Гүйцэтгэх захирал, Ш.Ганзориг Сэлбэ 20 минутын хот корпорац ХХК Төслийн удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Г.Анар Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Б.Амарболд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, С.Болдбаатар Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн байна уу тээ? Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2 хүн ирэх ёстой ирээгүй юм уу, эсвэл оронд нь орлож байгаа хүн ирсэн юм уу? Эдийн засгийн яам бүүр байхгүй байна уу. Бас Засгийн газар бүтэцтэй холбоотой эднийхэн ирээгүй байх шиг байна. Сангийн яамнаас Гантогтох, Л.Гантогтох Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгийн хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Монголын барилгачдын нэгдсэн холбоо Төрийн бус байгууллагуудаас Ч.Наранбаатар Монголын барилгачдын нэгдсэн холбоо ТББ-ын Ерөнхийлөгч, Ц.Цэндхүү ТББ-ын төлөөлөл, Ц.Наранбат ТББ-ын төлөөлөл, Я.Дашням ТББ-ын төлөөлөл, Б.Өлзийбат ТББ-ын төлөөлөл хүрэлцэн ирсэн байна.

Танилцуулгатай холбоотой асуулт, хариулт. Асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Сайнзориг гишүүнээр тасалъя. Батболд гишүүн.

Р.Батболд: Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Явж явж энэ чинь 2, 3 долоо хоног хэлэлцэх гээд чадахгүй байсан, танилцуулга сонсох гээд чадахгүй байсан асуудал юм байгаа юм. Энэ Сэлбэ төсөлтэй холбоотой энэ

шүүмжлэлтэй юм зөндөө байгаад байгаа юм. Би яамаар байгаа юм. Энэ байнга худлаа мэдээлэл өгөөд байгаа юм. Бид нар энэ чинь сар хагасын өмнө билүү очиж ажилласан. Тэгэхэд энэ юугаа гаргаагүй байсан юм шүү дээ энэ төсөвт өртгөө хүртэл мэдэхгүй сууж байсан шүү дээ. Одоо сүүлд нь танилцуулга дээрээ ингээд юм бэлдээд ямар ч байсан ороод ирэх нь ороод ирж.

Тэгэхдээ энэ чинь худлаа байгаад байна гэж би хэлэх гээд байгаа юм. Та хэдийн өгч байгаа энэ тэр багцуудын төсвийн мэдээлэл дотор, энэ зарлаж байгаа багцууд дотроос чинь ингээд хайгаад үзэхээр, тэгээд энэ сүүлд өгсөн мэдээлэлтэй чинь харьцуулаад үзэхээр наад метр квадратын чинь өртөг нь 2.2-2.6 л гараад байна шүү дээ. Яаж та нар 3 сая 700 болгоод байгаа юм бэ? Тэр дээр энэ газар шугам сүлжээний үнэ нэмээд 2.6-3 сая л болоод байх юм. Та нар яаж 3 сая 700 болгоод байгаа юм бэ? Энэ шал худлаа ийм тооцоо яваад байх юм. Энийг би энэ Аудитын газраас бүр хүсэлт тавьж байгаад шалгуулмаар байна. Энэ яаж авах ёстой юм? Энэ аягүй том төсөл шүү дээ. Энэ бид нарын бүр ДНБ-ий 3, 4 хувь, энэ төсвийн энэ 25 оны зарлагын чинь бараг 7, 8 хувьтай тэнцэж байгаа шүү дээ. Бид нарын энэ жил зарцуулж байгаа мөнгөний 12 төгрөг болгоны 1 нь ийшээ явж байгаа шүү дээ. Энийг яагаад ийм хайнга хийдэг юм бэ? Тэгээд 3, 4 дүгээр хороолол гээд жишээ аваад байна. 3, 4 дүгээр хороолол 9 аравны 9500 орчим ч юм уу ийм өрхтэй барилгажилттай ийм талбай байгаад байгаа юм.

Тэрний чинь 5-ны 1 дээр нь үйлчилгээний газар байхгүй шүү дээ. Та нар энэнийхээ 35 га дээр нь аваачиж үйлчилгээний газар гээд дахиад өндөр өндөр байшингууд замынх нь хажуугаар барих гээд байгаа шүү дээ. 3, 4 дүгээр хороололд тийм юм байхгүй байсан шүү дээ. Тэгээд ийм гоё яриад байдаг тэгээд ийм худлаа юм хийгээд байх юм. Тэгээд баахан юу хийчихсэн, 70-80 квадраттай, 60-70 квадраттай энэ тэр гэж яриад байдаг. Тэр нь ерөөсөө 8-хан блоктор л байгаа. Үлдсэн 105 дээр нь байхгүй шүү дээ та нарт. Үгүй ээ энэ 12 давхартаа ганц 12 ширхэг 1 70-тай оруулсан юм уу? Бусад нь байхгүй. Дандаа 50-аас доошоо. Энэ 10 мянгаа багасгаж болдоггүй юм уу гээд би улам бас сар хагасын өмнө хэлээд байсан. Та нар квадратаа нэмэх тал дээр бодож болдоггүй юм уу гээд, энэ байшингийнхаа планыг бид нарт бас өгч болдоггүй юм уу? Ямар төлөвлөлттэй, ямар байшин барих гээд байгаа юм? Ийм юм байгаад байх юм тэгээд энийг чинь яаж хэл.../минут дуусав./

А.Ундраа: Нямбаатар дарга. Уучлаарай ажлын хэсэг дээр бас Самбууням, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч бас хүрэлцэн ирсэн байна. Нямбаатар ажлын хэсгийн 4 номер.

Х.Нямбаатар: Би энэ сүүлийн үед энэ яг болж байгаа үйл явдлыг хараад ер нь шал дэмий төсөл санаачилчихъя гэдэг ийм ойлголтод хүрээд байж байна. Энэ бид нар Гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиа боловсруулаад, батлуулаад газраа чөлөөлөөд өөрсдөө ТЭЗҮ боловсруулаад тэгээд Европын зах зээл дээр очиж мөнгө босгоод, Европын хөрөнгө оруулагчдадаа амласан амлалтынхаа дагуу цаг хугацааныхаа хуанлингаар энэ худалдан авах ажиллагааг зохион байгуулаад явчихдаг. Би Батболд гишүүний саяын зүйл дээр бүүр ихэд гайхаж байна. Нийслэлийн хэрэгжүүлж байгаа төслийн метр квадратын хэмжээ дамжаа бүх юмыг Их Хурлаас заана гэвэл энэ хуулиас давсан шийдвэр болох байх гэж бодож байна. Энэ Нийслэл гэдэг өөрөө нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, сонгуулиар иргэд, сонгогчдод амлаад амласан амлалтынхаа дагуу төсөл, хөтөлбөрөө хэрэгжүүлээд ингээд л явж байгаа.

Тэгээд бид нар энэ барилгажилттай холбоотой метр квадратын хэмжээ дамжаан дээр энэ мэргэжлийн төсөвчид ажиллаад, аудитаар ороод ингээд явж байгаа. Энэ өөрийнх нь босож байгаа өртөг нь 2 сая 285 мянга орчим төгрөгөөр босоод яг цэвэр барилгажих ашигтай талбай нь. Үүн дээр ашиггүй талбайн өртгүүд нэмэгдээд, үүн дээр нэмэх нь гадна инженерийн шугам сүлжээний өртөг нэмэгдээд, үүн дээр нэмэх нь гадна зам талбай тохижилтын өртгүүд нэмэгдээд, үүн дээр нэмэх нь газар чөлөөлөлтийн өртгүүд нэмэгдээд ойролцоогоор 3.7 сая орчим төгрөгөөр энэ төсөл гарна гээд. Бид ашигтай талбайнхаа ашгийг нэмэгдүүлэх зорилгоор суурийн хийцлэлд өөрчлөлт оруулахгүйгээр нийтдээ 533 мянган м2-ыг цэвэр ашигтай талбай байхаар, үүн дээр нэмэх нь суурийн давхарт төлөвлөсөн зогсоолын 40 мянган м2-ыг зараад энэ төсөл ойролцоогоор 2.1 тэрбум их наяд төгрөгөөр энэ төслийн эцсийн үр дүн дуусна.

Цаана нь бид нарт 39 мянган га талбай, га үлдэж байгаа энийг бид нар төр, хувийн хэвшлийн түншлэлээр 20 минутын хот концепцынхоо хүрээнд худалдаа үйлчилгээ, нийгэм соёлын, барилга байгууламжуудыг хувийн сектороор барьж байгуулаад уг барьсан хувийн секторын барьсан талбайгаас бид нар ашигтай талбайнх нь тодорхой хувийг хэлцлийн үр дүнд аваад, дараагийн 5 буудал, 4 буудал Хайлааст, Чингэлтэйн газар чөлөөлөлтөд ашиглана. Үүнээс хойших барилгын төслүүд дээр төр өөрөө оролцохгүйгээр цэвэр шугам сүлжээгээ татаад газрыг нь чөлөөлөөд ингээд явдаг ийм газар чөлөөлөлтийн сангийн хуулиа төлөвлөөд ингээд оруулж ирж байгаа юм.

Үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотойгоор гадаа сая жагсаж байгаа энд орж ирсэн барилгын компанийн барилгын төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй бид нар зүйлийг би учирлаж маш олон удаа хэлсэн. Энэ юу вэ гэхээр бид нар мөнгө босгохдоо ТЭЗҮ урьдчилж танилцуулаад ТЭЗҮ дээр бичсэнийхээ дагуу хөрөнгө оруулагч итгэл төрж мөнгө өгч байгаа юм. ТЭЗҮ дээр бид нар бүх блокуудыг нь жижиглэж худалдан авалт ажиллагаа явуулна, блокуудыг жижиглэнэ ээ гэвэл хөрөнгө оруулагч бид нарт итгэл төрөхгүй.

Тийм учраас Шударга өрсөлдөөний газраар бид нарт гомдол гаргаач ээ та нар өрсөлдөөнийг хориглосон уу гэдэг асуудлыг тавь гэсэн тавьсан. Өчигдөр Монополын газраас өрсөлдөөнийг хязгаарласан зүйлгүй байна гэдэг дүгнэлт ирсэн. Одоо бид нарт сүүлд гарч байгаа ганцхан гарц бол манай энэ хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтыг босгоход оролцсон “Дойче” банк буюу андеррайтер банкт бид нар ярилцаад одоогийн байгаа 2 багцыг 5 багц болгож жижиглэх зөвшөөрлийг хөрөнгө оруулагч талаасаа аваад, хөрөнгө оруулагч тал окэй гэж үзвэл бид нар ингээд жижиглээд явъя. Тендерээ бүрмөсөн зогсооё гээд.../минут дуусав./

А.Ундраа: Батболд гишүүн тодруулж асууя.

Р.Батболд: Үгүй ээ Нямбаатар дарга. наадхыг чинь би буруу гэж хэлэхгүй байгаа юм. Наадах чинь зөв, хийх ёстой ажил юм байгаа юм. Энэ сүүлд энэ хэдэн гишүүд яваад байгаа энэ бондын санхүүжилтийг энэ жилд өөр арай өөр аргаар оруулаад төсөвтөө өөр аргаар тусгаад тусгахгүй ч юм уу байдлаар яваад ингээд санхүүжүүлчихье гэдэг юман дотор энэ сэлбэг төсөл явж байгаа. Энэ хууль санаачилчихсан явж байгаа шүү дээ энэ Ганхуяг гишүүн энэ тэр. Тэр дээр би гол нь хамгийн түрүүн гарын үсгээ зурчихсан хүн энийг би дэмжээд байгаа юм. Наад тооцоо чинь буруу байгаад байна шүү дээ л гэж хэлээд байгаа юм. Одоо та хэдийн жишээлэх юм бол энэ нэг дүгээр багцын 9 давхар энэ 119, тэр 199 тэрбумаар

бараг зарлалчихсан байгаа энэ 12 блок барилга чинь л өөрийнх нь өртөг нь 2 сая 500 гараад байгаа байхгүй юу. Энд юун дахиад ингээд ашигтай, ашиггүй талбай гээд юу тооцоод байгаа юм бэ? Энэ чинь л биш болчихоод байна шүү дээ гэж хэлээд байна шүү дээ. Хаанаасаа та нар тэр 704000-ыг аваачиж нэмээд байгаа юм бэ гэдэг асуудал байгаа. Би нэг мөр дахиад 1 минут авчихъя тэгэх үү? Энийг би аудитаар.../минут дуусав./

А.Ундраа: Батболд гишүүний цагийг нэмье.

Р.Батболд: Тэгээд ийм асуудлууд байна. Хоёрдугаарт гэх юм бол энэ нийт ашигтай талбай нь 4200, тэгээд нийт талбай нь 6500 энэ чинь гуравны нэг нь ашиггүй талбайтай ийм байшин бариад байгаа юм уу гээд бас нэг асуудал л даа. Энэ 87 айлынхаа орон сууцын энэ өгсөн материал дээрээ л хараарай. Тэгээд яаж ийм байдаг юм бэ гэдэг асуудал. Тэгээд Сангийн яамнаас асуумаар байх юм. Энэ танайх одоо яаж санхүүжиж яваад байгаа юм? Энэ 500 саяын тэрбум, 500 саяын бондын зарцуулалтынх нь эрх нь нээгдчихсэн юм уу? Энэ Сангийн яамнаас хүн байна уу, нээгдсэн юм уу ер нь? Энэ тооцоолол чинь буруу байгаа болоод би асуугаад байгаа юм шүү. Түүнээс биш энэ төслийг чинь би буруу биш гэж хэлээгүй. Буруу гэж хэлээгүй байна. Энэ тэгээд ийм байгаа юм. 3, 4 дүгээр хороололд чинь өөрөө байна шүү дээ 9 сургууль бас тэр хэмжээний цэцэрлэг байгаад байгаа юм. Та нарын энэ төсөл дээр болохоор 3 сургууль, 5 цэцэрлэг билүү ийм юм тусчихаад байгаа байхгүй юу.

А.Ундраа: Сангийн яамнаас ирсэн 5 дугаар микрофон дээр сууж байгаад хариулъя.

Р.Батболд: Энийг бас яаж тооцож байна?

А.Ундраа: 5 дугаар микрофоныг ажлын хэсгийн.

Р.Батболд: Энэ чинь суурьшил байгаа газар шүү дээ. Сургууль, цэцэрлэгүүд байгаа шүү дээ. Сангийн яамнаас асуусан шүү дээ. Тэн дээрээ нэмж бид нар дахиад 3 сургууль.

А.Ундраа: Цаг нь яваад байна шүү. Сангийн яамны 5 дугаар микрофон. Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг. 6 юм байна 5 биз дээ? Тэр 6.

Л.Гантогтох: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Нийслэлийн зүгээс энэ Сэлбэ дэд төв төслийг сая презентэйшн/presentation/ танилцуулга дээр дурдсан олон улсын зах зээл дээр босгосон гадаад үнэт цаасаар санхүүжүүлж байгаа. Энэ гадаад үнэт цаасыг яг санхүүжүүлэх удирдаж байгаа яг энэ чиг үүрэг нь нийслэл дээр төсөл, хөтөлбөрийг хэрхэн зарцуулах вэ энэ чиг үүргүүд бүгдээрээ нийслэл дээр байгаа болохоор нийслэл дээр яг энэ талаас хариултаа өгсөн нь зүйтэй гэж бодож байна.

А.Ундраа: Ер нь өрийн удирдлагын асуудал дээр өчигдөр Ай Эм Эф-ийн уулзалт дээр ч гэсэн энэ асуудал гарч байсан. Дэлхийн банкны дүгнэлт дээр ч гэсэн гарсан байна лээ. Тэгэхээр бичилт хийх, хэрхэн яаж тооцох дээрээ бас валютын нөөц энэ тэрд нөлөөлж байгаа асуудал учраас их хариуцлагатай хариулах хэрэгтэй шүү. Нямбаатар дарга 4 дүгээр микрофон.

Х.Нямбаатар: Одоо энэ өөрөө дандаа иргэдийн суурьшлын бүс шүү дээ. Тэгээд энд энэ чинь 7 сургууль, 8 цэцэрлэг байгаа шүү дээ. Нэмээд энэ дээр бид нар 3 сургууль барина. 1-ийг нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөтөлбөртэй сургууль болгоё гэж байгаа. Дахиад цэцэрлэгүүд нэмж барья гээд. Ингээд тооцооллын хувьд бид нар маш ойлгомжтой яг сүүлийн үед барьж байгаа стандартынхаа л дагуу тооцоолоод явж байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ Өрийн удирдлагын тухай хуулиар нийслэл Улаанбаатар хотыг гадаад бонд гаргаж санхүүжүүлэх энэ эрх нээгдсэн. Үүнийхээ дагуу бид нар бондоо оруулж ирээд энийг 12 сарын 15-нд оруулж ирсэн шиг санаж байна. Бид нар уг нь он гаргаад дараагийн төсвийн жил дээр оруулж ирье гэсэн. Тухайн үеийн Эдийн засаг, хөгжлийн сайд Гантөмөр дарга валютын нөөцийг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай байна гээд он дотроо багтааж оруулж ир гээд бид нар оруулж ирсэн юм. Оруулж ирсэн 500 сая ам.долларынхоо 400 сая ам.долларыг.../минут дуусав./

А.Ундраа: Нямбаатар даргын 4 номерын микрофон нэмэлт хариултыг гүйцээж хувиръя.

Х.Нямбаатар: Үлдсэн 400 сая ам.доллар-ыг нь Монголбанкны ханшаар Монголбанканд валютын нөөц нэмэгдүүлэх зорилгоор арилжаалсан. Арилжаалсан мөнгөө системийн банкнуудын дунд тендер зарлаад 14, 15, 16 хувийн хүүтэй хугацаагаар нь эрэмбэлээд арилжааны банкнуудад бүгдийг нь хадгалчихсан. Бид нарын эргэн төлөлтийн хүү нь 7.71. Цаана нь гарч байгаа 10 хэдэн 14, 15 хувь гэдэг бид нар ханшийн эрсдэлийг хамгаалах зорилгоор арилжааны банкнуудад хадгалуулчихсан. Одоогоор 1 ч төгрөг үрж эхлээгүй байна. 1, 2 дугаар багш дээр шалгарсан аж ахуйн нэгж нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа илэрхийлээд, гүйцэтгэлийн урьдчилгаа баталгаа банкны баталгаа байршуулсан тохиолдолд тэр дүнгээр нь санхүүжилтийг нь олгоод, гүйцэтгэлээр нь санхүүжилтийг нь хийж явна. Эндээс ерөөсөө хамгийн сүүлийнх нь бид нарын хадгалуулсан мөнгө 6 сарын 13-нд сая хугацаа нь дууссан. Гэтэл гүйцэтгэл гараагүй учраас тодорхой хувийг нь гүйцэтгэлтэй нь уялдуулаад дахиад гэрээгээ 3.../минут дуусав./

А.Ундраа: Таны юу залгуулаад авчихсан. Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ Сэлбэ төв төв дээр маш их гомдол гараад байгаа шүү дээ. Ялангуяа Монголын барилгачид их гомдол тавиад байгаа. Тэгэхээр би гол асуудал нь энэ багцуудаа яагаад ингээд 450 тэрбум төгрөг маш өндөр дүнтэйгээр ингэж 4 багцад хуваасан юм бэ, яагаад анхнаасаа жижиглэж болоогүй юм бэ гэдэг асуулт байгаад байгаа юм.

Бонд бол нийслэл ингээд Сэлбэ дэд төв байгуулна гээд бондоо босгочихсон байя. Яг тэр дотроо ингэж багцад хуваана гэдэг бүүр нарийн заалт руу нь. тэгж бонд худалдаж авсан хүмүүс чинь орохгүй шүү дээ ер нь гол нь. Тэгээд яагаад тэгж тийм асуудал гараад байгаа юм бэ гэдэг асуулт ямар ч байсан. Цаашдаа энэ багцуудаа жижиглэх гэж байгаа нь зөв байна. Тэгэхдээ ер нь Монголын барилгын компаниуд чинь энэ багц 1, 2-ыг чинь сонсохоор зүгээр л орон сууц барих гэж байгаа байхгүй юу. Тэгтэл Улаанбаатарт Яармагаар дүүрэн орон сууц бариад байгаа барилгын компаниуд олон байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр би анхнаасаа энэ багцыг ингэж өндөр дүнтэй хуваасан нь буруу байна. гэж үзэж байна. Тэгэхээр энэ дээр хариулт авъя нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ бондын мөнгөө ерөнхийдөө эргүүлээд төлөхдөө та нар энэ орон сууц, энэ үйлчилгээний талбай, зарсан мөнгө рүү бүтэн төлж чадна гэж харж байгаа юм уу, эсвэл цаашдаа ер нь нийслэлийн төсвөөсөө төлж явна гэж харж байгаа юм уу? Хэдэн хувийг нь ер нь орон сууцын борлуулалт энэ үйлчилгээний талбайн борлуулалтаасаа төлнө өө гэж харж байгаа юм бэ гэдэг ийм 2 асуулт байна.

А.Ундраа: Нямбаатар дарга ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Х.Нямбаатар: Соронзонболд гишүүн та өөрөө бас банканд ажиллаж байсан. Мөнгө босгох процесстой холбоотой юун дээр аягүй сайн нарийн ойлголттой байгаа байх. Бид нар нийтдээ энэ 11 багцыг энэ 500 сая ам.доллараар санхүүжүүлнэ гэж ТЭЗҮ хийж ТЭЗҮ-гээ магадлалаар оруулаад ингээд андеррайтераа сонгоод энэний дагуу явж байгаа. 11 багцыг би та бүхэнд танилцуулбал орон сууцын 4 багц, гадна шугам сүлжээ, ус хангамж, хөрсний усны түвшнийг бууруулах, гадна цахилгаан дэд өртөө, холбоо сувагчлал, гадна дулааны эх үүсвэр, гадна тохижилт, гадна зам талбай, хороолол дундах ногоон байгууламж, 1560 хүүхдийн сургууль, 1260 хүүхдийн сургууль, цэцэрлэг гээд ингээд сургууль, цэцэрлэгүүдээ багцлаад ингээд энэ 11 багцыг бид нар санхүүжүүлнэ ээ гэдэг ийм ТЭЗҮ-г танилцуулаад манай танилцуулгыг хүлээн зөвшөөрсөн аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчид энэ бондыг санхүүжүүлсэн гэж бид дахиад хэлье. Бид нар энэ энэ багцыг жижиглэх тохиолдолд дахиад ТЭЗҮ-дээ өөрчлөлт оруулаад дахиад андеррайтертаа энийгээ танилцуулаад ийм өөрчлөлт гаргаж байгаа шүү гэдгээ мэдэгдлээ хүргүүлнэ. Ингэж байж цаашаагаа явахгүй бол бид нар хөрөнгө оруулагчдын итгэлийг шууд хөсөрдүүлээд өөрсдийнхөөрөө өөрчлөлт оруулаад явах боломжгүй. Яагаад гэвэл бид нар мөнгө босгохдоо хүлээсэн үүрэг байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт, энэ юутай холбоотой бас асууж байна эргэн төлөлттэй холбоотой. Энэ цэвэр өөрөө бизнесийн төсөл. Энэ санхүүжилтээ өөрөө төлөөд, өөрөө 2027 оны 8, 9 дүгээр сард энэ босгосон 500 сая ам.доллаароо төлөөд бид нар дахин санхүүжилт хийхгүй байхаар төлөвлөж байгаа. Бид нар цаана нь гарч байгаа ашиг нь юу үлдэж байгаа вэ гэвэл тэр нүүрний эгнээнд байгаа 39 мянган га газрыг бид нар хувийн секторт өгч, тэр бизнесийн 20 минутын хотод тавигддаг шаардлага хангасан тэр барилга байгууламжуудыг бариад тэр барилга байгууламжуудаас бид нар ашигтай талбайн тодорхой хувийг бид нарт өгнө. Тэр хувиараа бид нар 5 буудал, Хайлааст, Чингэлтэйн дараагийн газруудыг чөлөөлнө гээд өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 71 байршилд яг ийм байдлаар газар чөлөөлөлт явагдаж байгаа. Үүнээс хамгийн түрүүлж эхлэх нь Ханын материал орчмын 1800 айлын орон сууцын төслийг бид нар төр, хувийн хэвшлийн түншлэлээр сонгон шалгаруулалтаар аж ахуйн нэгж жид өгнө. Аж ахуйн нэгж бариад барьсан талбайнхаа 15-20 хувийг манай орон сууцжуулалтын санд өгнө. Бид нар тэр сангаараа дараагийнхаа Толгойт, Баянхошууг чөлөөлөх гэдэг ийм байдлаар бид нар нийтдээ 71 байршилд газар чөлөөлөлтийн сан бүрдүүлэх зорилгоор газар чөлөөлөлтийн ажлыг явуулж байгаа. Тэгэхээр цаашаа бид нар нийслэл энэ төслийг бариад өөрөө бие дааж дахиж орон сууцын төсөл хэрэгжүүлэхгүй.

А.Ундраа: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Тэгэхээр 2.5 их наяд төгрөгөөр ДНБ өснө гэж байгаа л даа. Тэгэхээр нийт орон сууцууд маань болохоор ойролцоогоор 1.9 их наяд төгрөгийн борлуулалт хийх юм шиг байгаа юм багцыг нь харахаар. Тэгэхээр үлдсэн дэд бүтцийн ажлууд чинь энэ 2.5 их наяд төгрөгтөө бүгдээрээ орсон юм уу гэдэг ийм асуулт байгаад байна. Тэгээд энэ 2.5 их наяд төгрөг маань болохоор ирэх 3 жилийн хугацаанд гээд бодоод үзэхээр та хэдийн юуг харахаар чинь орон сууцын борлуулалт гэхэд л дангаараа л 900 хэдэн тэрбум байгаад байхгүй юу. Өөрөө 100 хувь бүтэн өөрийгөө санхүүжүүлнэ гээд байдаг. Орон сууцын борлуулалтыг чинь харахаар 980 тэрбум байх шиг байна лээ санхүүжилт талаас. Тэгэхээр нийт орон сууцын борлуулалт чинь хэдэн төгрөг болох юм бэ гэдэг ийм асуулт байгаад байгаа.

А.Ундраа: 4 дүгээр микрофон ажлын хэсгийн.

Х.Нямбаатар: 535 мянган м2-ыг орон сууц ашигтай талбайг бид нар худалдана. 1м2-ыг 3.8-аас 4 сая төгрөгийн хооронд зарахад бид нар 2 их наядын, 2.1 их наядын борлуулалт хийгээд энэ гаргасан бондоор босгосон санхүүжилтээ бид нар эргэн төлөх боломжтой гээд. Би таныг хаанаас яг ямар тоо аваад байгааг мэдэхгүй байна. Манай энэ бондыг худалдаж авсан 13 хөрөнгө оруулагч байгууллага байгаа. Эдгээр байгууллагууддаа бид нар төслийн явцын талаар байнга мэдээлэл өгч байгаа гэдгийг бас нэмж хэлье. Тэгээд бид нар нийтдээ тийм пинко ороод тийм 17 хөрөнгө оруулагч байгууллагууд манай энэ бондыг худалдаж авсан. Бид нар бондыг 2024 сарын хугацаанд барилга угсралтын ажлаа барьж, барилга эхэлснээс хойш 24 сарын дотор дуусгаад.../минут дуусав./

А.Ундраа: Мандхай гишүүн.

М.Мандхай: Энэ хүлээгдэж байгаа үр дүн дээр асуулт байна. Гэр хорооллын янданг 15600-гаар бууруулна гээд тавьчихсан тоо байгаад байгаа. Энэ нь байгаа гэр хорооллыг амины орон сууцтай дүйцүүлж байгаа юм уу? Амины орон сууц 6453 гэсэн тоо яваад байгаа. Тэгэхлээр энэ нийт өрх чинь 10063 өрх байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ 15600-г орон сууцжуулах гэж байгаа юу, эсвэл энэ ямар шийдэлтэй тоо байгаа вэ гэдгийг асуумаар байгаа юм. Яагаад гэхлээр энэ нөгөө гэр хорооллын яндан чинь өөрөө юунаасаа өндөр байгаа учраас өрхийн тоо яриад байна уу гэдэг нь сайн, өрхийн тоо бол энэ нийт төслийн чинь өрхтэй харьцуулахад өндөр дүнтэй уч учгаас энэ дээр тодруулж өгөөч ээ гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт, энэ нягтралын тоог 300-401, 1 га газарт 300-460 хүний нягтралтай байхаар тооцсон юм байна. Гэтэл олон улсын жишгээр өндөр нягтралтай бүсэд 1 га-д 150-250 хүн байхаар тооцсон байгаад байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө хэт ачаалал өндөр байхаар тооцсон юм биш үү? Энэ төлөлтийг яг яаж харсан бэ гэдэг дээр? Дунджаар 150 орчим байдаг. Өндөр нягтралтай бол 300-аас доош байгаад байгаа юм.

Гуравдугаарт, одоо бол гэр хороололд 205 мянга орчим өрх амьдарч байгаа. Тэгэхлээр энэ Сэлбийн хот өөрөө яг зөвхөн хотын иргэд ээ тэр дундаа гэр хорооллын иргэнүүдийг энэ Сэлбэ хотод оршин суух, тэр шилжилт шилжих хөдөлгөөнийг нь илүү хотын иргэдэд зориулсан ямар бодлого баримтлах вэ? Яагаад гэхлээр бид нар чинь нөгөө хөдөөгийн сэргэлт гэж яриад хөдөө орон нутагтаа хүмүүсийг илүү түлхүү тийшээгээ шилжиж явах ийм бодлого Засгийн газар хэрэгжүүлээд явж байгаа. Тэгэхээр энд ингээд таатай орчин хот үүсээд

ирэхээр нөгөө хөдөө орон нутагт оршин сууж байгаа нөхдүүд эргээд энэ Сэлбэ хот руу шилжих хөдөлгөөн нэмэгдэх ийм эрсдэл харагдаад байгаа. Тэгэхлээр энэ илүү Улаанбаатар хотдоо бүртгэлтэй иргэдэд ямар бодлого баримталж аль болох хөдөө орон нутагт оршин сууж байгаа иргэдийг түлхүү наашаа шилжилт хөдөлгөөнийг нь сааруулахад яг ямар бодлого барим хэлж ажиллах вэ гэдэг дээр хариулт авъя.

А.Ундраа: 4 дүгээр микрофон.

Х.Нямбаатар: Би гишүүний асуултад хариулъя. Бид жил болгон газар чөлөөлөлтийн сан байгуулъя гээд Их Хуралд хууль өргөн барьчихсан байгаа. Энэ сангийнхаа дагуу бид нар анхандаа буруу тооцоо хийсэн юм. Юу гэхээр барьсан байшингаар орон сууц хашаа байшин хоёрыг своп хийж явъя гэж ийм хуулийг анх оруулсан юм. Гэтэл нөгөө своп хийхэд энэ хоёрын өртөг ерөөсөө дүйцэхгүй болчихоод байгаа юм. Айлын хашаа чинь зарим нь 200 хэдэн метр квадрат, зарим нь 300. Хашаандаа 1 байшинтай, 2 байшинтай гээд.

Тэгэхээр хамгийн тохирох юм бол бид нар энд орон сууцын шинэ хорооллыг босгож байхтай зэрэгцээд энэ талын 5 дугаар, 5 буудал Хайлааст, Чингэлтэйн бусад айлуудаас бид нар газрыг нь бэлэн мөнгөөр худалдаж авах процесс зэрэг явагдах гээд байгаа юм. Тэгээд санал болгоход энд барилга тэдэн сарын тэдний өдөр орно, таны газрыг бид нар 180 сая төгрөгөөр худалдаж авлаа, тэнд 150 сая төгрөгийн орон сууцууд байгаа шүү гэдэг ийм маягаар хажууд зэргэлдээх газруудыг нь шууд бэлэн мөнгөөр худалдан авах процесс үргэлжилнэ. Энэ барилгын үйлдвэрлэл явагдаж байна. Энэ хоёрыг хооронд нь уях бид нар ийм бодлогуудыг барьж байгаа гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, хөдөө орон нутгаас орж ирж байгаа хүн сэлбэгийг худалдаж авахад бид нар хязгаарлалт, хориглолт хийх ямар ч боломжгүй. Энэ нөгөө Монгол Улсын Үндсэн хуулиар оршин суух газраа сонгох, нөгөө шударгаар үл хөдлөх хөдлөх эд хөрөнгө худалдаж авах тэр суурь зарчимтайгаа уялдаад л явна. Зүгээр нэг сайн юм нь бид нар хот газар чөлөөлөөд ямар ч байсан нэлээн дадлаа. Одоо жишээлбэл Ханын материал дээр 1800 айлын орон сууцын газар чөлөөлөхөөр бид нар энэ хавар эхэлсэн. Одоо 7 сарын 1-нд бүх айлуудыг чөлөөлж дуусах ийм гэрээ хэлцлүүд хийгдэж дуусаж байна. Тэгэхээр цаашид бид нар инженерийн дэд бүтэцтэй ийм газрууд дээрээ нийслэл өөрөө газар чөлөөлөлтөө хийдэг. Чөлөөлсөн газар дээрээ барилгын компаниудыг барилгаа барь, бид нарын газрын өртгийг байр хэлбэрээр төлөөрэй гэдэг л ийм концепц руу үндсэндээ явж байгаа. Их Хурлын гишүүдэд би нэг зүйл хэлэхэд бид нарын хамгийн бүр гол анхаарах асуудал дулааны асуудал шүү.

Одоо тэр Баянголын аманд баригдаж байгаа 2008 айлын орон сууцын дулаан хангамж маш хүндрэлтэй байна. Баянхошуу, Ханын материал, Толгойт дэд төвийн орон сууцжуулах газар чөлөөлөлтүүд хийгдээд байдаг. Яг дулаан хангамжийн хувьд маш хүнд байна. Тийм учраас би сая Эрчим хүчний сайдаар ажиллаж байсан Чойжилсүрэн сайдад хэлсэн. Хэдүүлээ энэ Улаанбаатар хотын дулаан хангамжийн асуудал дээр концепцоо нэгтгэе. Бид нар энэ Улаанбаатар хотын төвд цахилгаан үйлдвэрлэхээсээ илүүтэй дулаан үйлдвэрлэлээ нэмэгдүүлж байж орон сууцжих хэрэгцээгээ хувийн хэвшилтэйгээ хамтдаа шийдэж явъя л гэдэг л ийм бодлого. 2-ыг жишээлбэл дан дулаан хангамж руу, 3-ыг дан дулаан хангамж руу, Амгаланг дан дулааны өргөтгөл рүү гээд ингэж явж байж бид нар богино хугацаанд өртөг багатай байдлаар энэ дулаан хангамжийнхаа асуудлыг шийдэхгүй

бол одоо бид нарыг яг энд яриад сууж байхад энэ өвлийг яаж давах билээ л гэдэг л асуудал байгаа. Тэрнээс цаашаагаа дулааны асуудал бид нарын бүүр хамгийн том проблем болоод байгаа шүү л гэдгийг хэлье.

А.Ундраа: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон Даваадалай орлогч.

Т.Даваадалай: Гишүүний асуултад нэмээд хариулъя. 15600 гэдэг яндан бол 10069 айл нь 1 дүгээр 4 багц, 3700-гаад айлд төр, хувийн хэвшлийн түншлэлээр зарлах хэсэг дээр бас орон сууцжуулах хэсэг байж байгаа нам хорооллын. Мөн трамвай болон гүний дулаанаар хийгдэж байгаа ажлуудыг тооцоолж үзээд тэрнээс гарах агаарын бохирдлуудыг гаргаад нийт яндангийн хувилбарт хэрэглэхээр 15600 янданг буурна гэсэн 1 Ки Пи Ай/KPI/-аар хэмжих юм бол гэдэг үзүүлэлтийг гаргасан байж байгаа.

Хүн амын нягтаршилтайгаа холбогдолтой асуулт дээр хариулахад 1 га газарт 71 хүн ногдож байснаас хэттэй гээд 2040 оны симуляцтай уялдуулаад тооцоход нягтшил 300-400, 460 болохоор байна гэж хэттэй гэдэг ерөнхий ирээдүйн төлөвлөлтөөр гарч байгаа. Үүн дээр одоо нэмээд хэлэхэд Улаанбаатар хотод бид нар ямар нэгэн симуляц тооцоолол хийхэд Герман улсын Пи Ти Ви визим гээд суурин пиксел программ дээр суурилсан дээр өгөгдөл өгч оруулж байгаа. Мэдээж энэ дээр бас зарим хэмжээний симуляц дээр нарийвчлал хангалтгүй гэж үзэж байгаа. Ийм учраас бид нар олон улсын жишгийг дагаад виртуал, дижитал буюу Улаанбаатар хотыг дижитал хэлбэр дээр үе шаттайгаар оруулах ажлыг энэ жил бас нийслэл эхлүүлж байгаа. Ингэснээрээ ирээдүйд бид нар бүх шугам хоолой, гүний хоолой, иргэдээ дижитал байдал руу орсноороо симуляц тооцоолол бас нарийн болох, ДНБ-ий Улаанбаатар хотын өсөлт, замын түгжрэл гэдгийг нарийвчилж гаргах, Улаанбаатар хотын хэмжээнд тогтоод байгаа энэ борооны усыг аль хэсгүүд дээр хэрхэн тогтож байна гэдгийг тэр дижитал тивийн хотоос.../минут дуусав./

А.Ундраа: Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Яг үнэн. Энэ материал харж байхад 63 мегаваттын дулааны дутагдалтай буюу нийт энэ зардлыг чинь 56 биш ээ, нийт дулааны 56 хувь үндсэндээ шийдэгдээгүй орхигдчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ төсөл явахад маш хүнд гэсэн үг шүү дээ. Тэгэхлээр энэ төсвийн чинь энэ 63мвт-ыг нөхөх төсөв байгаа юу? Жишээлбэл бид нар дулааны хангамжийг нэмэгдүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлье гээд Эрчим хүчний яамтай ярихад энэ санхүүжилт ерөнхийдөө энэ төсөвт чинь туссан байгаа юу гэдгийг асуумаар байна. Тэгэх юм бол бид нар энэ санхүүжилтийг дулааны хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зарцуулж болох уу?

Хоёрдугаарт, хөдөөгийн иргэдийг худалдан авах мэдээж бид нар ялгаварлан гадуурхаж болохгүй. Гэхдээ нэг асуудал байна. Өнөөдөр Улаанбаатар хотод амьдарч байгаа, гэр хороололд амьдарч байгаа иргэдийн орлогын асуудал маш хүнд байгаа шүү дээ. Сул байгаа. Тэгэхлээр энэ байр, орон сууцыг худалдаж авах чадамж байхгүй байх юм бол хөдөө орон нутагт байгаа малтай иргэд чинь малаа зараад ийшийгээ байр орон сууц руу илүү түлэх үү.../минут дуусав./

А.Ундраа: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Х.Нямбаатар: Би түрүүн танд аягүй тодорхой хэлсэн шүү дээ. Гэр хорооллын иргэд чинь бид нар хажуу талынх нь айлуудын газрыг шууд худалдаж аваад ингээд мөнгөжүүлээд явна. Газар чөлөөлөлтөө. Тэгээд тэр хүний сонголтыг бид нар хүчээр тулгаж болохгүй. Манай энд ийм барилгууд байна. Энэнээс та сонголтоо хий гээд. Сая бид нар энэ Сэлбэ дээр 2000 гаран айлыг чөлөөллөө. Миний хийж байгаа судалгаа бид нар хийлгэж байна. Бараг 98, 9 хувь нь дандаа орон сууц авсан. Одоо хуучин орон сууцын эрэлт аягүй өндөр нэмэгдээд байгаагийн гол шалтгаан нь бид нар шинэ орон сууцын найдвартай тийм том хангалтууд байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ дээрээ өөрсдөө орон сууцынхаа хангалтыг бий болгоод, хажуу талынх нь айлуудыг худалдаж аваад явъя. Тэгээд сонголт, сонголт, сонголт. Нэг.

Хоёрдугаарт, наад дулаан дээр бид нар шийдлээ ерөнхийдөө гаргачхаад явж байгаа. Бид нар урьдчилсан ТЭЗҮ хийгдсэн. Энэ Сэлбэ голын орчимд газрын гүний.../минут дуусав./

А.Ундраа: Ажлын хэсэг гүйцээж хариулъя. 4 дүгээр микрофон.

Х.Нямбаатар: Бид нар 2 байршил дээр энэ 9 сард өрөмдлөгтэй хайгуул хийх гэж байгаа. Нэг нь Хүннү хот дээр, хоёр дахь нь Сэлбэ дээр. Бид нар сая урьдчилсан геофизикийн шинжилгээ хийгээд урьдчилсан ТЭЗҮ-гээр Сэлбэ хотод газрын гүний дулаан, газрын гүнд байгаа халуун ус байх магадлал 60-аас дээш хувьтай гарсан. Хүннү хот дээр бараг 90-ээс дээш хувьтай гарсан. Тэгэхээр энийг би их олон нийтэд нөгөө яг халуун усаа барьчихсанахаа хойно л зарлая гээд байгаа болохоос биш энийг зарлахгүй яваад байгаа. Энэ ТЭЗҮ дээр бичигдчихсэн байгаа газрын гүний хайгуул. Хэрвээ бид нар Дамбадаржаагийн ДЦС-ыг 100мвт-аар өргөтгөсөн тохиолдолд дулааныхаа асуудлыг шийдэж болно. Гэтэл хоногт дахиад нэмээд хоног болгон 60 HOWO нүүрсийг бид нар энэ түгжрэлтэй замаар зөөх, эргээд байгаль орчинд учруулж байгаа экологийн хохирлыг тооцоход их өндөр нөлөөлөл гарах учраас бид нар газрын гүний геотермо хайгуулын ажлыг энэ 9 сард хийгээд, үр дүнгээ энэ он дотроо гаргана.

А.Ундраа: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Сонголт гэж хэллээ. Тэгэхдээ бид нар бас зарим тохиолдолд арай илүү давуу эрх гэж хэлэх нь бас буруудчих байж магадгүй. Гэхдээ нөгөө их мөнгө хараад газраа зараад улсууд яг дорвитой хөрөнгө оруулалт хийхгүй байх эрсдэл бас байгаа байхгүй юу. Тэгэхлээр бид нар урьдчилсан байдлаар гэрээ хийх ч гэдэг юм уу, эсвэл илүү нөгөө багцын ийм санал болгодог ч юм уу? Энэ байраа би зарлаа л эргээд энэ байрыг худалдаж авна гэсэн байдлаар ийм тэрийгээ хөшүүрэг болгосон ийм баталгаажуулах ийм арга хэрэгсэл хийхгүй болохоор хүмүүс гэнэт 150 ч юм уу, 180 сая төгрөг авангуутаа тэрийгээ өр шир олон олон юманд зарцуулсаар байгаад тэгээд нөгөө яг байраа худалдаж авахгүй дахиад нөгөө асуудал баахан иргэд газраа зараад байргүй, орон сууцгүй болсон ийм шийдлүүд гарах вий дээ, эрсдэлүүд гарах вий дээ гэдэг ийм болгоомжлол байгаа учраас урьдчилсан гэрээ ч гэдэг юм уу ийм өөр бид нар бас санал болгох, энэ эрсдэлээс бууруулах юмыг бас давхар анхаарч хийх ч явах нь зүйтэй байх гэсэн ийм үг болгоод сана.../минут дуусав./

А.Ундраа: Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Би үг хэлж байна шүү гишүүд ээ. Цаг яваад байдаг гишүүд ээ бас уучлаарай. Эхнээс нь өгчхөөч. Би энэ дундуур нь ярьж чадахгүй байна. Цагийг эхлүүлээд өгчхөөч хуралдаан даргалагч би.

А.Ундраа: Сайнзориг, уучлаарай гишүүд ээ. Сайнзориг гишүүний цагийг шинээр эхлүүлье.

П.Сайнзориг: Манайхан байж байгаарай 3-хан минут байдаг. Маш том асуудал ярьж байгаа. Тэгэхдээ би зүгээр ингээд зөв ойлгоосой гэж бодож байгаа. Олон нийт ерөөсөө л юу гэдэг юм жоохон мэдээлэл дутуу байна. Ингээд ил тод яриад бас олон нийтэд мэдээлэл өгч байгаа өнөөдрийн бас энэ Байнгын хорооны хуралдаанаар авч хэлэлцэж байгаа асуудлын гол ач холбогдол нь гарч байгаа юм. Тэгээд би зүгээр энэ дээр хэд хэдэн үзүүлэлтийг бас авч үзээсэй гэж бодож байгаа юм. Яг газрыг эдийн засгийн эргэлтэд оруулна гэж олон жил ярьсан мөртөө бодитой ерөөсөө алхам хийгдээгүй байсан. Энэ удаад яг өмчлөх эрх болон эзэмших эрхтэй, ашиглах эрхтэй аж ахуйн нэгж байгууллагуудын ч гэсэн энэ эрхийг бид нар эдийн засгийн эргэлтэд оруулахад энэ төсөл хамгийн том алхам болсон юм. Мандхай гишүүний ярьж байгаа шиг эхний үе шат дээр ийм газар эрхээрээ хохирох иргэд гарахгүй. 2 дугаар шатан дээр тэр 5 буудал, 4 буудал, энэ Хайлааст, Чингэлтэй ч байдаг юм уу эдгээрийн иргэдтэй яг бэлэн орон сууц дээр асуудлаа ярих юм асуудал шал өөрөөр яригдана шүү дээ. Үнэлгээгээ гаргаад ингээд явчих учраас иргэдийн хохирох асуудал энэ дээр байхгүй байгаа юм.

Хоёрдугаарт, нь нөгөө бид хэдийн бүтэлгүй энэ зээл, тусламжийн чинь л энэ төсөл бас залруулах гэж л явна л даа. Азийн хөгжлийн банкны төсөл буюу “GADIP” гээд төслөөр баахан юм бариад л байдаг. Ямар ч ашиглалт байхгүй. 18мвт-ын станц дулааны станц барьчихсан, баахан шугам сүлжээ барьсан мөртөө нь 1 ч холбогдоогүй. Тэгээд хэрэглэгч байхгүй учраас яг нэгж бүтээгдэхүүний үнэ маш өндөр. Түрүүчээсээ холбосон аж ахуйн нэгж байгууллагууд нь таслаад буцаад уурын зуух руугаа оръё гээд байж байгаа байхгүй юу. Энэ хавьцаа чинь.

Хоёрдугаарт, Улаанбаатарын чинь хотын хоймор хэсэг дээр хөрсний бохирдол, нөгөө нойл энэ бүх чинь үерийн усаараа дамжаад энэ хот руу орж ирж байгаа, энэ бүх зүйлийг бас иж бүрээр нь яг мэргэжлийн барилга, архитектурын шийдлээр нь суурьшлын бүс дээрээ нэмэх нь энэ үерийн усны хамгаалалт, далан шуудууг хийх, ингэж байж энэ хоймор талаасаа Улаанбаатар хотыг үерийн усны эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бас энэ төсөл бүхэлд нь авч хэлэлцэж байгаа зэрэг ач холбогдол байгаа. Хэд хэдэн гишүүд маань энэ барилгын компаниудын асуудлыг хөндөж байна. Энэ ерөөсөө орон нутагт ч гэдэг юм уу энэ гүйцэтгэх шатад ажиллаж байгаа хүн чинь хууль мөрдөнө шүү дээ. Бид хэд хуулиа бодмоор байна. Өнөөдөр энэ татварын хуулиар чинь аж ахуйн нэгж байгууллагууд чинь 25 хувийн татвар төлөхгүйн тулд борлуулалтын оргоо багасгахын тулд хэд хэдэн жижиг аж ахуйн нэгж байгууллагуудад хуваагдаад энэ тендерт өөрсдөө оролцож чадахгүй байгаа юм. Бодит байдал нь энэ.

Тендер худалдан авалтын хууль чинь ерөөсөө эд нарт тендерийн баталгаа шаардаад оруулахгүй байгаа юм. Ийм асуудлуудаа сууриар нь ярихгүй байж байж ажил хийж байгаа хүмүүсээ нухчин дараад энэ эрийг нь мохоогоод байвал Монгол Улсын энэ энэ арилжааны зээл байхгүй юу. Хугацаандаа энэ явахгүй бол бид хэд энэ зээлийн хүүд унана. Тийм учраас энэ дээр ямар нэгэн байдлаар ийм улс төрийн хоосон юмаар битгий ажил саатуулаасай гэж хүсэж байгаа юм. Тэгэхдээ би нийт барилгын салбарынхаа бас энэ ярьж байгаа зүйлүүдийг шийдэхийн тулд энэ

Худалдан авалтын хуулиа би өөрөө өргөн барья гэж бодож байна. Ажиллаад өглөө. Яг энэ асуудлыг нь барихаар сайд нар нь бултдаг юм байна лээ. Бэлэн болоод жоохон концепц нь гайгүй болонгуут нь би барина гээд. Гал барьдгаараа ганц Учрал сайд л барьж байгаа байхгүй юу. Тэгээд энэ засаг төр юу болоод байгаа нь мэдэгдэхгүй.../минут дуусав./

А.Ундраа: Сайнзориг гишүүнд минут нэмж өгье.

П.Сайнзориг: Засаг төр бас ингээд ороо бусгаа ч гэдэг юм уу цэгцэрч өгөхгүй байна. Тийм учраас би бас энэ дараа дараагийн ийм төслүүдэд бас дотоодын нэгжүүд, аж ахуйн нэгж байгууллагууд илүү оролцох үүднээс энэ Худалдан авах ажиллагааны хуулийг бас гишүүдэд би бас танилцуулна. Өөрөө өргөн бариад явъя. Ингэж байж энэ манай барилгын салбарынхны хэлээд байгаа юм бас шийдэгдэх юм байхгүй юу. Түүнээс биш төсөл хэрэгжүүлж байгаа хүмүүсийг хууль зөрч өө гээд шаардлага тавиад байхаар бас хэцүү байгаа юм. Би бас энэ барилгын салбарынхныг ойлгож байгаа юм л даа. Тэгээд бид хэд том зургаараа энэ хууль яаж хэрэгжиж байна гэдэг зүйлийг авч хэлэлцдэг системээ Ерөнхий сайдын дэргэд хууль тогтоомжийн агентлаг байгуулж шийдэхгүй бол энэ хуулийн сөрөг үр дагаврыг, эерэг үр дагаврыг мэдэхгүйгээр ингээд байгаад л байдаг. Тэн дээр нь улс төрчид нь халуун чулуу атгахгүй ээ гээд л ингээд л хяраад л байгаад байдаг. Тэгээд л асуудал ужгирдаг ийм л нөхцөл байдлууд байгаа юм. Тэгээд би бас энэ барилгын салбар гэдэг юм уу энэ дээр шинэ стандарт оруулж ирээсэй гэж хүсэж байна. Би зүгээр олон юм яримааргүй байна. Өнөөдөр энэ хүүхдийн парк дээр байгаа энэ тоглоомын талбайг л хараарай. Хүүхдүүд очерлож сурч байна. Хотын соёлд сурч байна. Өнөөдөр ийм тоглоомын далбаатай газар орон сууц байхгүй. Энэнээсээ эхлээд бид нар энэ хандлагыг өөрчлөхөд энэ том.../минут дуусав./

А.Ундраа: Сайнзориг гишүүн үг хэллээ. Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Сэлбэ дэд төв гээд энэ том төсөл нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд ер нь анхлан энэ анх маш том хэмжээний маш том төсөвтэй, төсөвт өртөгтэй ийм том төсөл хэрэгжиж байна. Тэгээд саяын танилцуулгад ер нь энэ төслийн 60 хувь нь бараг хэрэгжихэж байгаа гэж харсан. Тэр зөв үү? Бэлтгэл ажил уу? Нямбаатар дарга ер нь сая бас үгийнхээ эхэнд хэллээ л дээ. Ер нь ч энэ төслийг ер нь хэрэгжүүлэх нь зөв ч байсан юм уу, ер нь яах гэж ч хэрэгжүүлэв ээ гэж ийм халирсан маягтай юм ярьж байна та. Энэ төсөл үнэхээр Улаанбаатар хотын хэмжээнд, нийслэлийн хэмжээнд цар хүрээ, хамрах хүрээ, ач холбогдол, стратегийн хувьд үнэхээр маш хэрэгтэй ийм том төсөл.

Тэгэхээр энэ төслийн гол нь тэр худалдан авах юуны газар энэ тендерийн явц дээр л иргэд аж ахуйн нэгжүүд бүүр дандаа харддаг. Энэ бол бүүр байдаг зүйл. Иргэд аж ахуйн нэгжид ерөөсөө нээлттэй, мэдээлэл маш хомс. Иргэдэд аж ахуйн нэгжид мэдээлэл хүргэдэггүй, ирүүлсэн тендерийн материалыг нь цаг хугацаанд нь авч үзэж харж, ач холбогдол өгч ингэж ерөөсөө тэр тендер шалгаруулж байгаа комисс ер нь сайн ажиллахгүй байгаагаас л энэ үр дүн, муу үр дүн гарч хүмүүс ингээд хардаж байна шүү дээ. Тэгэхээр одоо ер нь нийт хэрэгжих ёстой ажлын яг хэдэн хувь нь өнөөдөр яг ингээд хэрэгжихээд байгаа юм бэ? Хэд хэдэн багцад ингээд хуваарилаад ингээд өгчихсөн.

Тэгэнгүүт тэр багц чинь өөрөө бас ингээд будилаантуулаад байна шүү дээ. Одоо яагаад үндэсний компаниуд, барилгын компаниуд өнөөдөр ингээд хэдэн

өдөр энэ ордны гадаа ингээд жагсаал, цуглаан хийгээд эсэргүүцээд байгаа юм бэ? Яг энэ дээр та нар нийслэлийн зүгээс ер нь ямар арга хэмжээ авч, ямар дүгнэлт хийж байгаа юм бэ? Одоо нүүр нүүрээ харж байгаа юм чинь ер нь хэлэх хэрэгтэй байх.

А.Ундраа: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Х.Нямбаатар: Батчимэг гишүүн ээ бид нар дүгнэлт хийхээс илүү би хууль зөрчөөгүй гэдгээ нэгдүгээрт хэлчихье.

Хоёрдугаарт, манай татварын тогтолцооны гажиг тогтолцоог сая Сайнзориг гишүүн аягүй тодорхой хэллээ. 6 тэрбумаас дээш төгрөгийн борлуулалттай болохоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 25 хувиар татаж авдаг учраас л бүх барилгын компаниуд бүх томоохон аж ахуйн нэгжүүд компаниудаа жижиглэчихсэн, жижиглэчихсэн. Тэгээд энэ нь өөрөө Тендерийн хууль дээрээ болохоор босго тавьчихаж байгаа юм. Босго нь юу гэхээр сүүлийн 3 жилийн борлуулалтын дундаж орлогын бид нар бүр хамгийн багаар нь 20 хувиар тавьж байгаа байхгүй юу. Тэгээд би өнөөдөр бид нарын энэ Эдийн засгийн байнгын хороон дээр гарч уулзсан уулзалт тодорхой үр дүнтэй гараасай гэдэг үүднээс би сая Наранбаттай үүдэнд уулзсан. Бусдууд нь энд бараг ороод ирчихсэн байх шиг байна. Бид хэд өнөөдөр “Дойче” банктай шууд онлайн хурал зарлана. Бид нар худалдан авалтынхаа сүүлийн 2 багц буюу 600, 400-тай багцыг үндсэндээ хоёр хоёр зуу болгоод дахиж 5 багц болгоод жижиглэе гэдэг зөвшөөрлөө. Энэ 17 хөрөнгө оруулагч нэг бүр рүү мэйл явуулаад, саналаа солилцоод, энэний зөвшөөрөл ирэнгүүт бид хэд яг ийм байдлаар зарлая. Энэнээс, энийг ингээд цаад талдаа хүлээж авсан тохиолдолд бид нар явна. Энэ та хэд нэг юмыг ойлгоорой. Бид нар өөрсдөө анх 11 багц бүтээн байгуулалтын ажил хийе. Барилга 1 багц, барилга 2 багц, барилга 3 багц, барилга 4 багц гээд ингээд 11 багцаа нөгөөдүүлтэйгээ зөвшилцчихөөд дур мэдэж ингээд болохгүй, шийдэж болохгүй гэдгийг л та хэд өнөөдөр би ойлгосон байх гэж бодож байна. Тэгээд бид нар энэ дээр онлайн хурал хийгээд явчихъя.

Хоёрдугаарт, энэ дээр дүгнэлт хийгээд Батчимэг гишүүн ээ энд бид нар, би ялангуяа хууль зөрчсөн ч үйлдэл байхгүй.

Хоёрдугаарт, би энэ ер нь тендер худалдан авалттай холбоотой зүйлийг тань ярья гэж бодож байна. Энэ миний зүүн гар талд манай Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын дарга Батцэцэг сууж байна. Эдний байгууллагаас өнгөрсөн 2023, 2022 онуудад тэр нөгөө ногоон автобус, улаан автобус баахан юунууд дээр эдний нийт ажиллах бүрэлдэхүүний бараг хэчнээн хүн нь хууль хяналтын байгууллагад татагдаж, зарим нь сая шүүхээр тэр ногоон автобусны хэргээр ял аваад явчихлаа. Энэ тендер сонгон шалгаруулалт дээр Сангийн яамнаас худалдан авах ажиллагааны аргачлалыг дүгнэдэг маягтын дагуу бүх тендерийн үнэлгээний хороо үнэлгээ өгдөг. Одоо хэн ч хэний өмнөөс хэн даргын өмнөөс ялангуяа шоронд явж, тэр үнэлгээ, аргачлалыг зөрчиж, үнэлэх, дүгнэх тухай ойлголт байхгүй. Одоо ... хүчин төгөлдөр хуулийн 1 дүгээр зарчим нь эхлээд үнэ, 2 дугаарт, тендерийн баримт бичиг, 3 дугаарт, тэр, бусад тендерт өгсөн материалуудаараа тодорхой аргачлалын дагуу шууд үнэлгээ хийгдээд гардаг ийм загвараар явж байгаа гэдгийг хэлье.

Өнөөдөр Их Хурлын гишүүд Эдийн засгийн байнгын хорооны гол байнгын хорооны гишүүд байгаа дээр хэлье. Би өнгөрсөн жил Худалдан авахын тухай

хуулийг өөрчилж өө энэ бүх зовлонг гэтэлгээ ээ гээд өргөн бариад өнгөрсөн оны 8 сард өргөн барьсан. Харамсалтай нь энэ хууль дэмжигдээгүй. Худалдан авах үйл ажиллагааны хуульд 4 үндсэн суурь зарчмыг дэлхий нийт шингээдэг. Нэгдүгээрт, Дэлхийн худалдааны байгууллагын зарчим, хоёрдугаарт, Фидикийн зарчим зарчим, гуравдугаарт, OECD-гийн зарчим, 4 дүгээрт НҮБ-ын тогтвортой хөгжлийн зарчим. Харамсалтай нь манай энэ Тендерийн хууль ганцхан НҮБ-ын тогтвортой хөгжлийн зарчмыг шингээгээд үлдсэнийг нь хаячихсан. Гадаад валютаар ханшийн алдагдлыг тооцох, олон улсын арбитрт маргах бүх юмыг энэ хууль дээр бүүр хориглочихсон байгаа. Тэгэхээр бид нар өнөөдөр том бүтээн байгуулалтын ажлыг хийхэд оролцогч аж ахуйн нэгжээ хамгаалахын тулд ханш, инфляцын уналтыг хүртэл хамгаалах ийм зохицуулалтгүй ийм хуулиар явж байгаа. Өөрөөр хэлбэл, хөгжиж байгаа орнуудад зориулсан загвар хуулиар өнөөдөр манай худалдан авахын хууль явж байгаа. Тэгээд худалдан авахын хууль дээрээ маш өндөр босго критер шалгуурууд тавьчихсан.

А.Ундраа: Батчимэг гишүүн тодруулж асууя.

П.Батчимэг: Нямбаатар даргын хэлж байгааг ойлгож байна. Ер нь ажил хийхэд шүүмжлэл их дагуулдаг. Тэгээд гарах бас учрах бэрхшээл, зовлон зөндөө л байгаа мэдээж. Ер нь зарчмын санал, горимын ч юм уу юу санал гаргая л даа. Эдийн засгийн байнгын хороон дээр энэ Сэлбэ дэд төв төсөл орж ирж байгаатай, танилцуулга орж ирж байгаатай холбоотойгоор эсвэл энэ хаврын чуулган хаахаас өмнө ч юм уу, эсвэл намрын чуулган эхлэх үед ажлын хэсэг гаргаад энэ төсөл, төсвийн энэ төслийн тендер ийн байдал, тендер, өшөө цаашилбал төсвийн төсөлд хэрэгжсэн, энэ төсвийн байдалд дүгнэлт хийх ажлын хэсэг байгуулбал ямар вэ гэдэг санал гаргаж байна.

А.Ундраа: Тийм, ажлын хэсэг байгуулах талаар бас манай эрхлэх асуудлын хүрээнд багтаж байна уу, яаж, ямар томъёоллоор ажлын хэсгийн даалгавар байх ёстой юм бэ гэдгийг бас ярьж болно, гишүүн санаачлан ажлын хэсэг байгуулж болно.

Дараагийн гишүүн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Сэлбэ дэд төвийг барих асуудлыг анхнаасаа дэмжиж байгаа гишүүдийн нэг. Тэр байтугай гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх анхдагч хуулийн төсөл санаачлаад энэ дотроос хамгийн түрүүнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зарлагын дээд хэмжээнээс гаргах төслийн нэгэнд Сэлбэ дэд төв явж байгаа. Би өөрөө тэр хууль дээр гарын үсэг зураад нэлээд юутай явж байгаа. Өөрөө их оролцоогоо нэмэгдүүлээд явж байгаа. Гэтэл та бүгдийн зарласан Сэлбэ 1, 2, 1, 2 дугаар багцын ажил чинь үндэсний компаниуд оролцох ямар ч боломжгүй байсан. Сая Нямбаатар дарга яриад байна гадаадын хөрөнгө оруулагчийн тал чинь ийм болзол тавилаа гэсэн үг үү? Тэгэхээр байж бай би эхлээд асуултаа дуусгачихъя.

Та нар 1, 2 дугаар багц чинь хэтэрхий өндөр үнийн дүнтэй явсан, дээрээс нь баталгаа нь өндөр явсан тийм биз дээ? Тийм учраас үндэсний ямар ч том компани энэ бүтээн байгуулалтын ажилд оролцох боломжгүй болсон. 1982 оноос хойшоо 51 жилийн дараа Улаанбаатар хотод хийж байгаа хамгийн том бүтээн байгуулалт мөн үү? Мөн. Энэ дээр өнөөдөр бид нар Монголын барилгын түүхэнд барилгын компаниуд маань маш сайн өсөж бойжсон байгаа. Яагаад Монгол төрөөс зарлаж байгаа энэ ажилд Монголын үндэсний компаниуд оролцож чаддаггүй юм бэ?

Монгол компаниуд оролцох боломжийг нь босгыг нь хаачихсан учраас оролцож чадахгүй, Хятадын компани шалгарчихсан. Өнөөдөр Монгол компаниуд Хятадын компаниас ажил гуйдаг туслан гүйцэтгэгч болж хувирч байгаа.

Тийм учраас би эндээс хурал даргалагчаа энэ барилгын компаниудын төлөөлөл үзэгчээр орж ирсэн юм уу, эсвэл эд нараас асуулт асууж болох уу? Энэ хүмүүс бараг 20-иод хоног гадаа жагсаал хийлээ, касктай суулт хийлээ. Би та бүгдээс асууя ямар учраас барилга Монголын барилгын компаниуд оролцож чадахгүй байна вэ? Та бүхэн хаана хаана хандсан бэ? Та нарт хэдэн барилгын компани нэгдсэн бэ? 3, 4 дүгээр багц дахиад зарлачихсан байгаа. Энэ дээр байна шүү дээ.

3 дугаар багц дээр гэх дээр 616 тэрбум төгрөгийн багц ажиллагаа, 4 дүгээр багц дээр 491 тэрбум, 3 дугаар багцын баталгаа нь 3 тэрбум, 4 дүгээр багцын баталгаа нь 2.4 тэрбум. Дахиад үндэсний компаниуд орж ирж чадахгүй. Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулагчийн итгэлийг эвдэхгүй байх уу, эсвэл үндэсний компаниудаа бойжуулахгүй байх уу? Монголын үндэсний компаниуд гадаадынхнаас дор үзэгдэх ёстой юу? Тэр хүмүүс яагаад өнөөдөр хоолоо олж идэж чадахгүй гэж? Монголын төрөөс ажил зарлачихсан байна шүү дээ. Тэгэхээр Нямбаатар дарга би сая ингэж ойлголоо гадаадын хөрөнгө оруулагч тал чинь багц 1, 2, 3, 4-ийг ийм өндөр үнийн дүнтэй зарла гээд шаардаад байгаа юм уу? Тийм учраас аргагүйн эрхэнд зарлаад байгаа юм уу ямар учиртай юм? Одоо энийгээ буцаагаад жижиглэж бутлаад үндэсний компаниудаа оруулах боломж байна уу?

А.Ундраа: Ажлын хэсгийн гишүүдээс энэ хуралдаанд оролцож байгаа төрийн бус байгууллагуудын төлөөллөөс ажлын хэсгийн энэ 5 дугаар микрофоныг түр чөлөөлөөд өгөх үү? Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ч.Наранбаатар: Сайн байцгаана уу? Монголын барилгачдын нэгдсэн холбооны ерөнхийлөгч Наранбаатар гэж хүн байна. Бидний асуудлыг бас дэмжиж Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оруулсан явдалд бас тус хорооны гишүүдэд талархал илэрхийлье. Би сүүлийн асуулт Мөнхбаясгалан гишүүний ямар учраас ингээд 20 гаран хоног цургачхав гэдэг юм. Бас их чухал бас асуудал санагдаж байгаа учраас эндээс эхлээд ярьчихъя. Энэ Сэлбэ дэд төвийн энэ асуудлыг бид нар бас дэмжиж байгаа улс төрчдөө дэмжиж байна. Нийслэлийн ажлыг бас 20 минут энэ хотыг дэмжиж байгаа энэ барилгын салбарт ирэх 100 жилийн бараг үсрэнгүй хөгжлийг авчирч чадах энэ томоохон төсөл энэ ганцхан Сэлбэ дэд төв гээд зогсохгүй цаашлаад түрүүн ярьсан бусад дэд төвүүд нь үргэлжилнэ.

Мөн өчигдөр, уржигдархан Хархорин хотын нээлтийг Ерөнхийлөгч хийж байх шиг байна лээ. Цаана нь Хүннү хот гэдэг юм уу бас хэд хэдэн томоохон хотууд яригдаж байгаа. Өнөөдөр тэр хотуудыг хэн барих вэ? Уул нь монголчууд бид баримаар байна шүү дээ. Бид барихын тулд энэ Сэлбэ мэтийн ийм төслүүд дээр оролцож чадавхжиж Сэлбийг хийсний дараа 2 жилийн дараа Монголд нийт 2.5 их наядын гэдэг юм уу баланстай олон компаниуд гарах нь байна шүү дээ. 100 тэрбумын, 200 тэрбумын баланстай ийм компаниуд гараасай. Энийг л төр минь дэмжээсэй гэж байгаа юм. Нямбаатар дарга би бас Нямбаатар дарга, Даваадалай дарга, Баатар дарга нарт талархаж байгаа. Энэ том төсөл. Бид нар та нарын хийж байгаа ажлыг ерөөсөө эсэргүүцээд байгаа юм байхгүй шүү дээ. Та нар хуулийн хүрээнд би хууль зөрчөөгүй гээд олон удаа хэлж байгаа. Хэд хэд бид нар уулзсан. Би та нарыг хууль зөрчлөө гэж хэлээгүй. Хуулийн хүрээндээ л явж байгаа.

Тэгэхдээ хуулийн чинь 15.1 дээр ийм байгаад байгаа байхгүй юу. Монгол компаниудыг оруулах боломжгүй болгосон чинь л ерөөсөө л ганцхан нөгөө багцын өндөр хэт өндөр. 450 тэрбум гэххэж байгаа юм. Тэрнийхээ 30 хувийг түргэн хөрвөгч хөрөнгө гэдэг юм уу юмаар хангах гэхээр компани дээр 136 тэрбумын жилийн борлуулалтын орлоготой болчихоод байсан байхгүй юу. Тэгэхээр ийм Монгол компани 1 ч байхгүй ээ. Энийгээ л та нар бууруулж өг. Бид 4 сарын 28-наас хойш хэвлэлийн хурал хийгээд ингээд энэний эсрэг яваад судалгаа гаргахад монгол компаниуд 200-250 тэрбумын хооронд баллачих юм бол болчих юм байна гээд.

Хуулийн 15, энд худалдан авах билүү 15.1 дээр чинь санхүүгийн болон техникийн чадавх туршлагын талаар санхүүгийн болон техникийн чадавх туршлагын талаар хангав, хангавал зохих, доод шаардлага шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана гэххэж байгаа юм. Тэгэхээр л нөгөө 2 аравны их наядын чинь одоо 20 хувь гэж тооцоод 450 тэрбумаар зарлачихсан юм шиг байгаа юм. Энийгээ л энэ хууль дээр захиалагчийн эрх байгаа учраас та бүхэн ингээд бид нарын шаардлагын хүрээнд багасгаад өгчхөөч л гээд байгаа юм. Одоо үлдсэн байгаа 1.1 их наядынхаа тендерийг 5 хуваачхаач ээ гэдэг дээр ерөнхийдөө ойлголцоод сая Нямбаатар дарга ярилаа гэж бодож байгаа юм. Мэдээж анхны уулзалт нийслэлийнхэнтэй хийсэн уулзалтаар бид саналыг нь хүлээж аваагүй юм. Яагаад гэвэл энэ 2 Хятад компани шалгарчихлаа, бид нар та нарыг 20 хувьд нь ажиллах хүч, янз бүрийн юмаар оруулж өгье л гэсэн. Бид үгүй ээ монгол компаниудын эрх ашиг нэгд байх ёстой гэдэг юм тавьсан.

Тийм учраас 20-иод хоног энд жагсаж байгаа юм. Энэ бол цаашид энэ улс орон хөгжье гэж байгаа бол үндэсний компаниудаа бодлогоор, төр бодлогоор бүүр дэмждэг. Тэр байтугай шууд гэрээлэх арга хэмжээнүүдийг хүртэл заах ёстой байхгүй юу. Ярих ёстой одоо бол. Ингэж байж монгол компаниуд бойжиж, хөдөлмөрийн зах зээлээ л алдмааргүй байна гэдэг бас ингээд тэмцээд яваад байгаа гэж байна л даа. Дээр нь үндэсний эрх ашиг, үндэсний эрх ашиг болчихоод байгаа байхгүй юу ерөнхийдөө.

Яагаад гэвэл энэ бондыг хэдийгээр гадаадын банкаар авч байгаа ч гэсэн монголчууд өөрсдөө төлнө шүү дээ. Тэгэхээр Монголын эх үүсвэр гэсэн үг. Тэгэхээр энэ монголчууд чинь өөрийнхөө босгосон эх үүсвэрээр өөрсдийнхөө компаниудыг л дэлхийн жишиг тийм шүү дээ. Хятадууд 1008 ..., Сэлбэ, Ногоон нуурыг оруулж ирээд буцалтгүй тусламжаар манай Монголд барьж байгаа. Тэгэхдээ гүйцэтгэгч компани нь Хятад компани. Тэгээд бид нар доор нь гүйцэтгэгч. Яг энэ шиг нийслэлд мөнгө босгож чадсан юм чинь тэрүүгээрээ монгол компаниудаа дэмжээд өгөөч. Одоо нийслэл энэ 500 саяын бонд босгож байгаа нь сайн жишиг. Улс орон хөгжих гэж байгаа юм байна. Энийг дагаад Дархан, Эрдэнэт, Өмнөговь гээд юугаа өгчихсөн байгаа шүү дээ.

А.Ундраа: Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Барилгачдын төлөөллийн үгийг бас сонслоо. Тэгэхээр хот бол буулт хийсэн юм байна. 5 болгож багцуудыг жижиглэж үндэсний компани оролцох босгыг нээж өгч байгаа юм байна тийм үү зөв үү? Одоо надад хариулт хэрэггүй ойлгочихлоо. Тэгэхээр аливаа төсөл, хөтөлбөр Монголын төрөөс явахдаа заавал ингэж жагсаал цуглаанд хүрмээргүй л байгаа юм уг нь. Ойлголцоод л явчих

хэрэгтэй. Үндэсний компаниуд 1 номерт байх ёстой. Одоо тэгээд ингээд ойлголцсон бол сайн байна. Баярлалаа. Ойлгочихлоо.

А.Ундраа: Тэгэхдээ ер нь тэр “Дойче” банктэй энэ тэр ярилцахдаа бас энэ ТББ-д төлөөллүүдээ оролцуулах ёстой юм биш үү гэдэг санааг бас хэлэх гэсэн юм. Даваадалай дарга нэмж хариул. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Т.Даваадалай: Мөнхбаясгалан гишүүн түрүүн төслүүдийн хуваарилалтын талаар харсан. Олон улсын 17 хөрөнгө оруулагч нар “Дойче” банкны шаардлага, ТЭЗҮ дээр шаардаад бидэнд хөрөнгө оруулахдаа энэ төслийг хөгжиж буй орон буюу Монгол Улс шиг оронд ороход олон улсын төслийн менежментийнх нь дагуу зөв, зохистой, олон улсын жишгээр нь зөв хийгээсэй л гэж хүссэн. Хөрөнгө оруулж байгаа хүмүүсийн шаардлага тийм байна. Миний мөнгийг аваад хулхидаад алга болчихгүй гэдэг энэнээсээ банкнаасаа ч шаардлага тавьдаг, ТЭЗҮ-ээрээ ч шаардлага тийм байж. Тийм учраас бид нар энэ төслийг 11 багц дээр төслийн менежерийнх нь дагуу зөв задлаад энийг л ингээд зарлаж байгаа бас асуудал. Би ингээд зарим байршлын холбоотой уулзахад зарим нь 100 задлаач гэдэг. Яг үнэнээ л хэлье. Манай холбоо маань сүүлд Наранбаатар ах маань 4, 5 задлаач гээд шаардлага тавьдаг. Энийг түрүүний хөрөнгө оруулагч нартай ярилцъя. Энэ чинь 100 хувь бид нар ингээд нөхөр Даваадалай чинь мөнгөө үрээд байгаа асуудал биш. Энэ бас хөрөнгө оруулагч нар банкны шаардлага, андеррайтер банкны шаардлага, олон улсын төслийн менежментийн дагуу явж байгаа. Энэ дээр бид нар жил болгон аудит хийгдэнэ. Хөрөнгөө гаргаад зээлж байгаа хүн шаардлагаа тавьдаг. Тэгэхээр олон улсад хэрэгжиж байгаа энэ мега төслүүд, том төслүүд төслийн менежментийн хувьд.../минут дуусав./

А.Ундраа: Би 1 асуулт нэмж асууя. Ер нь энэ Сэлбэ дэд төв Улаанбаатар хотын хөгжил тэгээд Монгол Улсын хотжилтын асуудал хот байгуулалт ер нь хэрхэн өрнөх вэ гэдэг дээр маш их чухал ач холбогдолтой төсөл. Олон шинэлэг зүйлийг бас бид хийж байна. Та бүхэн бас тал талаасаа олон хүн хүч хөдөлмөр зарцуулж ажиллаж байгаа юм байна. Тэр дундаа жишээлэхэд Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнд захиалга өгөөд газрын гүний дулаан ашиглах геотермо шинэ эх үүсвэр барих талаар ялангуяа энэ ТЭЦ 3 ийм хүндрэлтэй нөхцөл тулгамдаж байгаа үед шинэ эх үүсвэр гаргахаар ингээд зоримог хөдөлж байгаад бас баяртай байна. Ялангуяа захиалга өгөөд энэ геологи, геофизик, гидрогеологи, ... гээд энэ чиглэл чиглэлийн хүмүүсийг оруулаад мэдлэгтэй хүмүүсээ ашиглаж байгаа нь бас давуу талтай байна. Энэ дээр талархаж байгаагаа хэлмээр байна.

Тавих асуулт төлөвлөлтийн тухайд 20 минут гэж ярьдаг, олон улсад 15 минутын хот гэж нэлээн олон жилийн турш яригдаж байгаа. Тэгэхээр энэ нягтшил хэт өндөр байгаа гэдэг дээр энэ түрүүн Мандхай гишүүн хэлж байсан энэ байр суурьтай санал байна. Ямар ч байсан энийг ажин эхлүүлээд цаашаагаа ингээд хэт өндөр бишээр, дунд зэргийн өндөртэй нягтшил багатайгаар хөгжих боломж бас нээгдэх болов уу гэж найдаж байна. Ганцхан жишээ хэлэхэд Кэй Пи Ай/KPI/ дотроо сургуулийн болон цэцэрлэгийн хүртээмж ярихад ингээд 3980 хүүхдийн сургууль, 1900 биш ээ, 1200 хүүхдийн цэцэрлэг гэж байна шүү дээ. Тэгээд 10070 өрх тийм ээ, 73 өрх гээд. Тэгэхэд тэнд чинь 1 өрхөд статистикийн юугаар дундаж жоор 2.2 хүүхэд оногдож байна гэж байгаа. Тэгэхээр 20 гаруй мянган хүүхдэд ингээд 5180 сургууль цэцэрлэг ингээд анхнаасаа хүртээмжгүй байдлаар төлөвлөгдөж байгаа юм шиг ингэж харагдаж байна л даа. Энийг жишээлэхэд яаж хүртээмжийг нь

бодолцож байгаа юм бэ? Хувийн сургуулиудаар бусад хэрэгцээг нь шаардлагыг нь нийцье гэж байгаа юм уу гэдэг ийм асуулт байна.

А.Ундраа: Нямбаатар дарга 4 дүгээр микрофон.

Х.Нямбаатар: Тийм газрын гүний дулаан дээр бид нар Шинжлэх ухааны академтай, Барилга, хот байгуулалтын яамтай хамтраад нэлээн суурь судалгаанууд хийгдээд тэгээд нэлээн урагшилж байна. Тэгээд одоо бид нар яг өрөмдлөгтэй хайгуул руугаа орохоор ингээд бэлтгэл ажил хангагдаж байгаа. Тэгээд 2 газар явна. Нэгнийх нь зардлыг Эй Ди Би/ADB/-ээр бид нар даалгаж байгаа. Нэгийг нь төслөөсөө гаргаж байгаа. Ай Ди Би/IDB/-ээр бид нар энэ Сэргэлэн, Зуунмодын хавтанцрын зааг дээр өрөмдлөг хийлгэхээр ингээд урьдчилсан ТЭЗҮ хийгдсэн.

Нөгөөх нь энэ Сэлбэ дээр хийгдэх юм. Тэгээд бид нарын энэ газрын гүний дулаан яг амжилттай болох юм бол энэ манай улсын барилгын салбарт маш том хувьсгал явагдана. Хувьсгал болно. Энэ дээр бид нар бас хичээж ажиллаж байгаа гэдгээ хэлье сургууль, цэцэрлэг дээр. Одоо байгаа сургууль, цэцэрлэгүүд дээр 7 сургууль, 8 цэцэрлэг дээр нэмээд бид нар 3 сургууль, 4 цэцэрлэг барина гээд явж байгаа. Энэнийхээ бид нар 2-3-ыг нь хөтөлбөртэй сургууль болгож байж энэ нөгөө Сэлбийн маань борлуулалтыг дэмжинэ. Тухайлах юм нэгийг нь бид нар нөгөө техникийн суурь боловсрол олгодог ЕБС болгоё гээд хувийн сектортой уулзаж байгаа.

1 дээр нь бид нар энэ Сингапурын хөтөлбөртэй сургуулийг байгуулахад сургалтын төлбөр ямар байх вэ гэдэг уулзалтууд хийгдэж байгаа. Мөн бас манайд олон жил үйл ажиллагаа болсон хувийн сургуультай уулзаад энэ хэдээсээ бид нар сонголт хийгээд 2 хөтөлбөртэй сургууль байгуулахаар ингээд төлөвлөөд явж байгаа. Дээр нь мөн Соёлын яамтай яриад Улсын цирк байгуулагдана. Мөн энэ Сэлбэ голын усны урсцыг хөв цөөрөм болгож хиймэл нуур байгуулах ажил, одоо ажил нь эхэлчихсэн. Зураг нь явж дуусаад ажил нь эхэлж байгаа. Ажлыг нь Геодези, усны барилга байгууламжийн газар хийхээр төлөвлөж байгаа. Тэгээд энэ жил суурь ажлуудаа хийгээд мембран давхаргуудаа тавиад ирэх жилээс ус хуримтлуур хийх гадна тохижилт хийх ажлууд хийгдэнэ. Бид нар барилгаа зарахдаа мэдээж хэрэг нуур руугаа харсан байршил юутай газрыг нь арай өндөр үнэтэй байдаг ч юм уу ийм байдлаар маркетингийн хувьд нэлээн ийм ялгамжтайгаар явж байгаа.

Гол нь Эй Ди Би/ADB/ анх энэ төслийг бүр 1900, 2013 онд эхлүүлэхдээ ийм холимог орон сууцын хороолол болго гэдэг л шаардлага тавьсан юм. Өөрөөр хэлбэл гэр хорооллоос тийшээ анх очиж байгаа, мөн төрийн албанд ороод орон сууцаа сонгож очиж байгаа, мөн өөр орон сууцын хороолол очиж байгаа хүмүүсээ ийм холимог орон сууцын хороолол болгох энэ зарчмын дагуу бид нар боловсрол, соёл, эрүүл мэнд дээр нь үйлчилгээгээр нь нэг дор үйлчилгээ үзүүлэх ийм нөхцөлийг хангаж л явж байгаа. Тэр Мандхай гишүүний хэлээд байгааг бид нар аягүй сайн анхаарч байгаа. Өөрөөр хэлбэл, бид нар хажуу талын айлынх нь мөнгөө үрэхгүйгээр тийшээ очих тийм давуу байдлыг үүсгэж, маркетинг талдаа бид нар нөгөө хүмүүст дискаунт/discount/ үзүүлдэг ч юм уу ийм байдлаар тодорхой ажлууд хийгдэж байгаа. Бид нар өнөөдөр энэ төслийн бүх деталийг ярихад нэлээн цаг бага байгаа учраас товчхон би хэлж байна.

Ундраа гишүүний хэлж байгаа дээр бид нар нэмээд хэлэхэд ер нь бид нар энэ одоогийн боловсролын тогтолцоогоо өөрчилье л гэвэл ерөнхий боловсролын сургуулиудынхаа дунд заавал ийм тусдаа хөтөлбөрт сургуулиудыг хольж байж бид нар цаашид явна гэж үзэж байгаа. Толгойтод жишээлбэл бид нар Орост 4 дүгээр сургуулийг байгуулсан. Баянхошуунд бид нар Кембрижийн хөтөлбөртэй сургуулийг байгуулсан. Гэтэл эцэг эхчүүдийн хүсэл дахиад нэмээд хөтөлбөртэй сургууль байгуулж өгөөч ээ гэдэг нь өөрөөр хэлбэл тэр нөгөө дараагийн ээж, аавуудын хүсэлт рүү л бид нар чиглэж л ийм боловсролын тогтолцоонд энэ төслөөр өөрчлөлт оруулъя гэсэн зорилготой явж байгаа.

А.Ундраа: Гишүүд асуулт асууж дууслаа.

Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Мандхай гишүүний нэр тасалъя. Лувсанжамц гишүүн. Ирцээрээ юм байна. Соронзонболд гишүүний микрофоныг.

Л.Соронзонболд: Ер нь нийслэлийн энэ төсөв томорсон. Олон төсөл хэрэгжүүлэхээр том төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа. Тэгэхээр ер нь аливаа хэрэгжүүлж байгаа төслийн чинь 1 төгрөг болгон яаж Монголдоо үлдээх вэ, Монголын компанид бизнес эрхлэгчдийн хийж чаддаг ажил дээр яаж дэмжих вэ гэж бодож техник эдийн засгийн үндэслэгээ боловсруулдаг болох хэрэгтэй байна. Гадаадын компаниудыг өндөр технологи, мэдлэг шаардсан ажил дээр л ажиллуулах хэрэгтэй. Тэгэхээр Монголын компаниуд танай төсөл дээр оролцоод явбал Монголын эдийн засагт хэрэгтэй. Тэр нь эргээд нийслэлийн авсан зээл төлөхөд хэрэгтэй гэдгийг хөрөнгө оруулагчид эсэргүүцэх ямар ч үндэслэл байхгүй. Тийм учраас ТЭЗҮ боловсруулахдаа яаж Монголын компаниуд Монголд мөнгөө үлдээх вэ гэж боддог ийм ТЭЗҮ-г боловсруулж байгаарай гэж захимаар байна.

А.Ундраа: Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Сэлбээ төвийн бүтээн байгуулалтыг дэмжиж байгаа. 100 хувь дэмжиж байна. Тэгээд сая та хэд маань барилгын холбоонуудтайгаа яриад тохиролцоонд хүрч байгаа, хэлэлцээрт орж байгаа гэж ойлголоо. Амжилт хүсье.

Өнөөдөр танилцуулсан материалууд дээр жоохон мэргэжлийн зөвлөгөөнүүд өгөх гэсэн юм. Өмнө нь шуурхай штаб дээр бас зөндөө л хэлж байсан зүйлээ давтаж хэлэх гээд байна л даа. Нөгөө нэгдсэн төлөвлөлтийн тогтолцоондоо шилжих ёстой гээд энэ слайдуудыг эргүүлээд харахлаар дэд бүтэц, зам, трамвай, сургууль, цэцэрлэг эд нар төлөвлөгөөнүүд нь бүгдээрээ тусдаа яваад байгаа. Тэд нарыгаа бүгдийг нь нэгтгээд яахгүй бол нэгэнт хот байгуулалт стандартын газартай юм чинь та хэд маань энэ төлөвлөгөөгөө 1 төлөвлөгөөтэй болгох ёстой гэсэн зүйлээ барьж яваач ээ гэсэн санал байна. Тэгээд тэр төлөвлөгөө дээрээ багцуудыгаа хэдий хэмжээгээр хувааж байгаа юм, үнийн дүн нь хэд байгаа гэсэн санхүүгийн тооцооллоо 1 төлөвлөгөө дээр бас оруулах буюу тусдаа 4 дүгээр бүлэг дээр нь ороод байгаа шүү дээ тээ? Санхүүгийн тоо тооцоолол нь тэрийгээ хот төлдөг болгоод өгөх юм бол манай аж ахуйн нэгжүүд маань ч гэсэн хараад ойлгоход хялбар шүү дээ. Хэдэн га газар хэдий хэмжээний санхүүжилттэй, тендер хэзээ зарлагдах төлөвлөгөөтэй байгаа юм бэ гэсэн л 1 ойлгомжтой төлөвлөгөөтэй болмоор байна гэсэн тийм зөвлөгөө байна.

Хоёрдугаарх нь орон сууцын метр квадратын хэмжээ байна. 29 дүгээр хуудсан дээр нийт талбайн эзлэх хувь гээд 30-40, 40-50, 50-60 гээд метр квадратууд нь байгаад эзлэх хувь нь байна. Энэ дээр 40-50м²-тай 2-3 өрөө байр нийт орон сууц дотор эзлэх хувь нь 46 хувь гээд нэлээн өндөр байна л даа. Энийг ямар үндэслэлээр гаргасан гэдгийг нь сайн мэдэхгүй байна. Энийг жич дараа нь 20 минутын хот корпорацаас бас асууя гэж бодож байна. Яагаад тэгж байгаа вэ гэхлээр жижиг метр квадрат дээрээ байр олон болох тусмаа нөгөө коммунити буюу яг 20 минутын хотыгоо бий болгох гээд байгаа орчин нөхцөл хэцүү болчихдог учраас 80м²-аас дээш байр нь орон сууцад хэрэгтэй байна л даа. Энэ дээр хамгийн их нь 70-80м², 17.75 хувь гэж байгаа юм. Эндээс нэмээд дээшээгээ 80-100, 100-120 гэсэн 2 төрлийн сонголт бас байх ёстой болов уу гэж бодож байна. Тэгж байж яг ингээд юу гэх юм илүү амьд хүн төвтэй тийм хот болж хөгжих болов уу гэсэн тийм санал байна.

Гуравдугаарх нь болохлоор барилгын холбоонуудтайгаа бас идэвхтэй явж байгаад баярлалаа. Өнөөдөр хүрэлцэн ирсэнд баярлалаа. Тэгээд өмнө нь бас та хэдийгээ хүлээж авч уулзаж байхдаа хэлсэн саналуудаа протоколд үлдээхийн тулд дахиж саналаа хэлье. Та хэд маань сайн сонссон байх Сайнзориг гишүүн Худалдан худалдан авалтын тухай хууль дээрээ асуудал байгаад байгаа, Татварын хууль дээрээ бас асуудал нь байгаад байгаа юм, эд нар дээр та бүхэн маань саналаа өгөх хэрэгтэй байна. Төрийн бүх ажил бичиг цаасаар яг зарчмын зөрүүтэй санал гэсэн байдлаар л явах учраас та хэд маань нийлээд энэ хувийн хэвшлүүд маань бүгдээрээ энэ тухайн 2 хууль дээр бас саналуудаа тусгаад хэрвээ өгөх юм бол би ажлын хэсэгт нь орж ажиллая гэж бодож байгаа болохлоор надад өгвөл бас их зүгээр байна. Тэгээд өмнө нь бас уулзаад би та хэдэд 2 бичиг гаргаж өгөөч ээ гэж хэлсэн одоогоор би 1 ч бичиг хүлээж аваагүй байгаа гэдгийг бас жоохон сануулж хэлэхгүй бол. Нэгэнт хэдүүлээ би та бүхний төлөөлөл болоод Улсын Их Хуралд сууж байгаа учраас 2 талаасаа проактив байдлаар хамтраад ажиллая гэсэн тийм санал байгаа юм.

Үргэлжлүүлээд дахиад зүйл фидик/FIDIC/-ийн гэрээ мэргэшсэн төслийн менежер буюу Пи Эм Пи зэрэг байгаа. Тэр дээрээ та бүхэн маань тийм хүмүүс байдаг, манай барилгын салбарт тийм зэрэгтэй хүмүүс байгаа гэж хэлж байсан. Тэр тоогоо нэмэхгүй бол дахиад ямар нэгэн байдлаар ийм тендер гараад л ирэх болгонд л дахиад л фидик/FIDIC/-ийн гэрээгээр үйл ажиллагаа явуулах боломжгүй аж ахуйн нэгж болчихлоо, төслийн менежергүй аж ахуйн нэгж гэх юм бол тэгээд тендерт оролцох боломжгүй болчих учраас өмнө нь хэлснийгээ давтаад хэлье. Та хэд маань энэ 2 фидик/FIDIC/-ийн гэрээний маягтыг ашиглаж сурах Барилгын инженерүүдийн холбоо дээр байгаа шүү дээ тээ? Тэрийгээ ашиглаж сурах.

Хоёрдугаарт нь Пи Эм Пи зэрэг гэсэн төслийн мэргэшсэн менежер гэсэн энэ зэргийг авсан хүн болж өгвөл байгууллага болгонд, бригад болгонд 1 хүн байх хэрэгтэй байна. Тэгж байж л манайх яг хэлээд байгаа энэ нийслэлийн хөгжил утаагүй, түгжрэлгүй болох энэ үйл ажиллагаа нь хийх боломж нь бүрдэнэ шүү гэдгийг протоколд үлдэхийн тулд албаар хэлж байна. Тэгээд цаашдаа нийслэл болон барилгын холбоонуудтайгаа нягт уялдаж ажиллах учраас та хэдийнхээ бас тасралтгүй дэмжлэг болон санал, зөвлөмж зүйлүүдийг хүлээж байгаа шүү. Баярлалаа.

А.Ундраа: Мандхай гишүүн.

М.Мандхай: Би түрүүн хэлсэн үгээ дахиад тодруулаад хэлээдэхье. Монголд тухайн хотын иргэдийг давуу эрхтэй оролцуулах бодлого олон улсад хэрэгждэг. Би тэндээс хэдэн жишээ хэлье гэж бодож байгаа. Орон нутгаас ирэх хүсэлтэй иргэдэд бид нар аль болох мэдээж ялгаварлан гадуурхахгүй, дээрээс нь хүн амын шилжилтийг хязгаарлахгүй зарчим мөрдөгдөх нь зайлшгүй. Гэхдээ яг энэ миний хэлсэн дээр Солонгос бол Сөүл орчим дахь шинэ хотууд барихдаа ялангуяа энэ Сычуань, Пхеньян гэсэн хотууд байгаа. Тухайн бүс нутгийн хуучин оршин суугчдад түрүүлж газар, орон сууц эзэмших давуу эрхийг олгосон, Засгийн газар орон нутгийн иргэдэд бас мөн адилхан татаастай орон сууцын квот хуучин газрын өмчийг үнэлж солих механизмуудыг авч ажилладаг. Сингапур жишээлбэл Хаусинг Девелопмент Боард/Housing Development Boarding/ гэж байгаа. Орон сууцын энэ хөгжүүлэх энэ зөвлөл энэ нь өөрөө орон сууцын хөтөлбөр шинээр төлөвлөгдөж байгаа хороололд тухайн бүс нутгийн иргэдэд илүү оноо өгч, байрны сонголт хийх боломжийг нь бас олгодог. Мөн хуучин оршин суугчдад зориулсан рилокэйшн приорити/Relocation priority/ схем гээд бас яг энэ тусгай ийм схемээр дамжуулан дэд бүтэц шинэчлэгдэх явцад хурдан хугацаанд солих, давуу байршилд шилжих боломжийг бас олгож байгаа.

Хятад улс шинэ хот, шинэ дүүрэг барихад тухайн орон нутгийн иргэдийг анхны эзэмшигчид гэж үзэн хямдралтай үнээр орон сууц эзэмшүүлэх, түрээслэх нөхцөлийг бас санал болгодог. Хөдөөгөөс ирэх шилжих ирэх иргэдэд шууд эрх олгодоггүй. Зарим тохиолдолд бүртгэлийн системээр бас хязгаарлалт тавьдаг. Тэр нь яаж байна гэхлээр одоо байгаа оршин суугчдаа эхлээд давуу эрхийг нь олгож байгаад, тэгээд дараагийн 2 дахь, 3 дахь гээд үе шатуудтай хөгжүүлдэг гэсэн үг. Яг энэ зарчмаар Вьетнам, Индонез, Тайланд улсууд бас яг информал сеттлмент/informal settlement/ гээд бас яг энэ зарчмыг баримталж ажилладаг байгаа. Тэгэхээр би энд юм зохиож хэлээгүй, энэ угаасаа олон улсад хэрэгждэг зарчмыг л би зүгээр хэлж байгаа юм шүү гэдгийг хэлмээр байна. Тэгээд энэ Хот байгуулалтын тухай хууль дээр бас яг энэ зарчим ерөнхийдөө зохицуулалт орж байгаа гэж сая ойлгосон. Тийм болохоор энэ дээр бас анхаараад яваарай гэдэг дээр санал хэлмээр байна.

А.Ундраа: Би хэдэн үг хэлмээр байна. Ер нь манай Монгол Улсын барилгын салбар бол үүсэж хөгжөөд бас багагүй хугацаа өнгөрч байна. Тэгээд олон хүчин чадлууд бас бий болж байгаа. Дотоодын нөөц бололцоо сайжирч байгаа. Тэгэхээр Монгол Улсын барилгын салбарын компаниуд бригадууд, зураг төслийн бусад туслан гүйцэтгэх чадалтай компаниуд тоо нь олширч байгаа. Тэгэхээр энэ төслийн хүрээнд бол зөвхөн багцаа ингэж хэт цөөлж болохгүй байгаа зарчмыг хөрөнгө оруулагчийн зүгээс тавьж байгааг ойлгож байна.

Гэхдээ туслан гүйцэтгэгч болон бусад худалдан авалт хийхдээ аль болох Монголын үндэсний компаниудаа оруулах чиглэлийг барьж ажиллах нь зарчмын хувьд зүйтэй гэж үзэж байна. Тэгэхээр барилгын мэргэжлийн холбоодын хувьд ч гэсэн бид нар төрийн бодлогын зүгээс аль болох төрийн үйл ажиллагааг мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх чиглэлийг баримталж тэр хүрээнд эндээ Монголын барилгын үндэсний ассоциаци жишээлэхэд тусгай зөвшөөрлийг хариуцаж, мөн шалгаруулж, шалгаж, ингэж ажиллаад бас тодорхой хэмжээнд бусад салбарыг бодоход зохих хэмжээнд хөл дээрээ босож байгаа. Тэнд авууштай зүйлс бий.

Гэхдээ харьцуулаад үзэхэд зарим мэргэжлийн холбоод Их Хурлаар асуудал хэлэлцэхэд маш идэвхтэй ажилладаг, бичиг цаасаа цэгцтэй байлгадаг, байр

сууриа нэгтгээд ирүүлдэг. Тэгээд нээлттэй, ил тодын, маш илүү сайн мэргэжлийн холбоо өөрөө их төгөлдөршсөн байдаг. Тэгэхээр тэр утгаараа Монголын барилгын салбарын мэргэжлийн холбоод энэ дээр идэвхтэй байгаа нь сайн хэрэг. Гэхдээ жагсаал хийх, суулт хийх юм уу эдгээр хэлбэрээс гадна бас бичгээр байр сууриа илэрхийлэх илүү хууль тогтоогчдыг өөрсдийнхөө байр суурийг мэдээллээр хангаж, эсвэл санал солилцох, талуудын зөвшилцөх энэ процесс чухал гэдэг нь бас эндээс харагдаж байна. Тийм болохоор тал талаасаа бас хамтдаа энэ хөгжих хэрэгтэй байгаа нь энд харагдаж байна. Туслан гүйцэтгэгчид ярьсных, багц ярьсных Монгол Улсын хувьд ногоон эрчим хүчний хэмнэлттэй, ногоон тэгээд байгаль орчинд ээлтэй энэ барилга байгууламж барих чиглэлээр салбарын яам тодорхой ажлууд хийж байгааг бас энд хэлмээр байна.

Тэгэхээр нийслэлийн удирдлагуудын зүгээс улсын доторх улс мэтээр ингэж ажиллаж болохгүй 1 улс байгаа учраас энд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, барилгын норм, дүрмийг хэрэгжүүлэх аль болох тэрийг илүү хурдан хэрэгжүүлэх шатад нь ажиллах нь бол бүгдээрээ бүгдэд нь хэрэгтэй. Тэгээд энэ утаа, хөрсний бохирдол, агаарын бохирдол, тоосжилт гээд энэ эрүүл мэндэд ноцтой тулгамдаж байгаа олон асуудлууд дотор бүгдээрээ л тийм нэг завин дээр явж байгаа шүү дээ.

Тийм болохоор Барилгын яамнаас баталсан ногоон барилгын стандартын дагуу ялангуяа нийтийн, олон нийтийн зориулалттай сургууль, цэцэрлэг, сувилал эдгээр барилга байгууламжийг бэст гэр стандартын дор хаяж “B+” зэрэглэлтэй барихуйцаар худалдан авах төлөвлөгөө гаргах шаардлагатай шүү гэдгийг бас та бүхэнд бас хэлмээр мээр байна. Ингэж байгаа эсэхийг бас Эдийн засгийн байнгын хороон дээр ажлын хэсэг гарч энэ дээр олон гишүүд энэ дээр бас санал бодол, мэдээлэл авах чиглэлээр цаашаа үргэлж, тэгээд өнөөдрийн хуралдаанаар ажлын хэсгийнх нь нэрийг нь унших ёстой гэсэн тээ протоколд.

Сэлбэ дэд төвийн нийгмийн хангамж болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Үндэсний аудитын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад байгууллагын мэдээлэлтэй танилцаж дууслаа. Баярлалаа.

Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа.

13.30 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

